



СҮХБААТАР АЙМГИЙН БАЯНДЭЛГЭР
СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

СҮХБААТАР АЙМГИЙН БАЯНДЭЛГЭР СУМЫН НУТАГ ДЭВСГЭРИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ СУУРЬ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Гүйцэтгэгч:



Газрын мэргэжлийн байгууллага
“ГАЗАР ДЭЛХИЙ” ХХК

2023 оны 08 сар

ГАРЧИГ

ОРШИЛ.....	6
ЕРӨНХИЙ ХЭСЭГ	7
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. СУМЫН БАЙГАЛЬ, ЦАГ УУРЫН ОНЦЛОГ	12
1.1. СҮХБААТАР АЙМГИЙН БАЯНДЭЛГЭР СУМЫН ГАЗРЫН ГАДАРГА, ГАЗАРЗҮЙН БАЙРЛАЛ	12
1.2. БАЙГАЛЬ ЦАГ УУР, УУР АМЬСГАЛЫН НӨХЦӨЛ.....	17
1.2.1. Агаарын температур	17
1.2.2. Салхины горим.....	18
1.2.3. Чийгийн горим	20
1.3. БАЙГАЛЬ ЦАГ УУРЫН НӨХЦӨЛ ӨӨРЧЛӨЛТ	22
1.4. Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл, эрсдэл эмзэг байдал.....	26
1.4.1. Шороон шуурга, хүчтэй салхитай өдрийн тоо.	26
1.4.2. Цасан шуурга.	27
ХОЁРДУГААР БҮЛЭГ. БАЯНДЭЛГЭР СУМЫН БАЙГАЛЬ НУТАГ ДЭВСГЭРИЙН НӨХЦӨЛ, НӨӨЦИЙН СУДАЛГАА.....	30
2.1. БАЙГАЛЬ-НУТАГ ДЭВСГЭРИЙН ЦОГЦОЛБОР НӨХЦӨЛ, НӨӨЦИЙН МУЖ, ТОЙРОГ	30
2.1.1. Хамрагдах мужуудын онцлог	31
2.1.2. Хамрагдах мужуудын уур амьсгалын нөхцөл.....	31
2.1.3. Хамрагдах мужуудын ургамлан нөмрөг	32
2.1.4. Хамрагдах мужуудын хөрсөн бүрхэвч	35
2.1.5. Хамрагдах мужуудын ан амьтан	38
2.2. ИНЖЕНЕР ГЕОЛОГИЙН НӨХЦӨЛ	38
2.3. ГАДАРГЫН УС	41
2.3.1. Усны сав газар, усны эх үүсвэр.....	41
2.3.2. Усны сан бүхий газрын ашиглалт хамгаалалт, тооллого, судалгаа	43
2.4. ГИДРОГЕОЛОГИ	51
2.4.1. Гидрогеологийн нөхцөл	51
2.4.2. Газрын доорх усны орд ба нөөц, чанар	55
2.4.3. Баяндэлгэр сумын ундны усны чанарын судалгаа	56
2.5. ХӨРСӨН БҮРХЭВЧ	58
2.6. УРГАМЛЫН АЙМАГ, УРГАМАЛЖИЛТ	61
2.7. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ.....	67
2.8. ТҮҮХ СОЁЛЫН ДУРСГАЛ.....	69
2.9. ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТАГ	71
2.10. УУЛ УУРХАЙН ҮЙЛДВЭРЛЭЛ, АШИГТ МАЛТМАЛЫН СУДАЛГАА	74
ГУРАВДУГААР БҮЛЭГ. СҮХБААТАР АЙМГИЙН БАЯНДЭЛГЭР СУМЫН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ.....	76
3.1. ХҮН АМ ЗҮЙ	76
3.1.1. Хүн амын тоо.....	76
3.1.2. Хүн амын цэвэр өсөлт, бууралт	77
3.1.3. Хүн амын ердийн цэвэр өсөлт, бууралтын коэффициент	78
3.1.4. Нас хүйсийн бүтэц	78
3.1.5. Хүн ам зүйн үзүүлэлтүүд	79
3.1.6. Өрхийн мэдээлэл.....	83
3.1.7. Шилжих хөдөлгөөн.....	85
3.2. МАЛ АЖ АХУЙН САЛБАР	87
3.2.1. Малчин өрх.....	87
3.2.2. Малын тоо	89
3.2.3. Төл бойжилт	93
3.2.4. Сүргийн бүтэц	94
3.3. ГАЗАР ТАРИАЛАНГИЙН САЛБАР	95
3.3.1. Тариалсан талбай, таримлын төрөл.....	95

3.3.2. Байгалийн болон таримал тэжээлийн бэлтгэл.....	100
3.4. ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БАЙДАЛ.....	101
3.4.1. Боловсрол.....	101
3.4.2. Эрүүл мэнд.....	103
3.4.3. Дэд бүтэц.....	103
3.4.4. Аж үйлдвэр.....	103
3.4.5. Хөдөлмөр.....	105
3.4.6. Хадгаламж, зээл.....	105
ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ТОХИРОМЖТОЙ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ.....	107
4.1. ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН ТОХИРОМЖТОЙ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ.....	108
4.1.1. Бэлчээрийн газрын тохиромжтой байдлын үнэлгээ.....	108
4.1.2. Тариалангийн газрын тохиромжтой байдлын үнэлгээ.....	113
4.1.3. Аялал жуулчлалын газрын тохиромжтой байдлын үнэлгээ.....	116
4.2. ШУГАМАН БАЙГУУЛАМЖИЙН ЗОРИУЛАЛТААР АШИГЛАХ ГАЗРЫН ТОХИРОМЖТОЙ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ.....	118
ТАВДУГААР БҮЛЭГ. ГАЗРЫН НЭГДМЭЛ САН.....	121
АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ.....	123

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг№1.	Баяндэлгэр сумын сумын хилийн цэсийн зураг.....	10
Зураг№2.	Баяндэлгэр сумын байршлын схем.....	12
Зураг№3.	Өндөржилтийн зураг.....	13
Зураг№4.	Налуужилтын зураг.....	14
Зураг№5.	Зүг зовхисын зураг.....	15
Зураг№6.	Геоморфологийн зураг.....	16
Зураг№7.	Баяндэлгэр сумын агаарын үнэмлэхүй их, бага температурын норм, 1991-2020 он	18
Зураг№8.	Баяндэлгэр өртөө, салхины дундаж хурд м/с 2016-2020 оны дунджаар.....	19
Зураг№9.	Цасан болон шороон шуургатай өдрийн тоо, жилийн дунджаар, 2016-2021 он	20
Зураг№10.	Дундаж хур тунадас, мм, 2016-2020.....	21
Зураг№11.	Агаарын даралтын зураг.....	21
Зураг№12.	1940-2021 оны агаарын температур, хур тунадасны үзүүлэлт.....	22
Зураг№13.	Сүхбаатар аймгийн сумдын байгаль, цаг уурын нөхцөл, өөрчлөлт.....	23
Зураг№14.	Баяндэлгэр сумын уур амьсгал, ургамалжилтын нормчлол /Зуншлагын байдал/	24
Зураг№15.	Баяндэлгэр сумын уур амьсгал, ургамалжилтын стандартчилал /Зуншлагын байдал/	25
Зураг№16.	Шороон шуургатай өдрийн тоо /2000-2019 он/.....	26
Зураг№17.	Нэн хүчтэй болон хүчтэй салхитай өдрийн тоо /2000-2019 он/.....	27
Зураг№18.	Цасан шуургатай өдрийн тоо /2000-2019 он/.....	28
Зураг№19.	Баяндэлгэр сумын зудын эрсдэл /2000-2022 он/.....	29
Зураг№20.	Баяндэлгэр сумын байгаль нутаг дэвсгэрийн цогцолбор нөхцөлийн тойргийн зураг	30
Зураг№21.	Баяндэлгэр сумын инженер-геологийн нөхцөлийн зураг.....	40
Зураг№22.	Баяндэлгэр сумын нутаг дэвсгэр хамаарах усны сав газар.....	41
Зураг№23.	Гадаргын усны зураг.....	42
Зураг№24.	Гидрогеологийн зураг.....	54
Зураг№25.	Баяндэлгэр сумын төвийн усан хангамжийн газрын доорх усны орд.....	56
Зураг№26.	Хөрсний зураг.....	60
Зураг№27.	Ургамалжилтын зураг.....	66
Зураг№28.	Баяндэлгэр сумын нутаг дахь түүх соёлын үл хөдлөх дурсгалын байршил	71
Зураг№29.	Баяндэлгэр сумын тусгай хамгаалалттай газар нутгийн зураг.....	73
Зураг№30.	Геологийн зураг.....	74

Зураг№31.	Баяндэлгэр сумын ашигт малтмалын тархалтын зураг	75
Зураг№32.	Баяндэлгэр сумын хүн амын өсөлт, 2017-2022	76
Зураг№33.	Хүн амын тоон өөрчлөлт, багаар 2017-2022	77
Зураг№34.	Хүн амын ердийн өсөлт	77
Зураг№35.	Хүн амын ердийн цэвэр өсөлт/бууралтын коэффициент	78
Зураг№36.	Баяндэлгэр сумын нас хүйсийн суварга, 2021 он.....	79
Зураг№37.	Хүн ам зүйн ачаалал, харьцуулалт	79
Зураг№38.	Хүн амын нягтрал, ойролцоох самдуудтай харьцуулсан байдал.....	80
Зураг№39.	Баяндэлгэр сумын хүн амын нягтшил 2022 оны байдлаар.....	81
Зураг№40.	Гэрлэлт, гэр бүл цуцлалт.....	82
Зураг№41.	Гэрлэлт хүйс, насны бүлгээр сүүлийн 5н жилээр харьцуулсан байдал	83
Зураг№42.	Баяндэлгэр сумын нийт өрхийн тоон үзүүлэлт.....	84
Зураг№43.	Өрхийн тоо багаар	84
Зураг№44.	Өрхийн ам бүлийн дундаж тоон харьцуулалт 2017-2021 он.....	85
Зураг№45.	Баяндэлгэр сумын шилжих хөдөлгөөн, 2017-2021 он	86
Зураг№46.	Дотоод шилжих хөдөлгөөний цэвэр коэффициент	87
Зураг№47.	Баяндэлгэр сумын малчин өрх.....	88
Зураг№48.	Баяндэлгэр сумын малтай өрхийн тоо.....	88
Зураг№49.	Сумын нийт малын тоон өөрчлөлт.....	89
Зураг№50.	Сумын нийт малын өсөлт, төрлөөр.....	89
Зураг№51.	Малын тооны өсөлт, багаар 2017-2022 он.....	90
Зураг№52.	Хээлтэгч малын тоо /багаар/ 2017-2022 он	91
Зураг№53.	Сувайрсан малын тоо	92
Зураг№54.	Малын зүй бус хорогдол / багаар/.....	93
Зураг№55.	Баяндэлгэр сум нийт бойжуулсан төл, төрлөөр, багаар	94
Зураг№56.	Сүргийн бүтэц	95
Зураг№57.	ЕБС-д өдрөөр суралцагчдын тоо, сумаар, 2017-2022 он.....	101
Зураг№58.	ЕБС-ийн үндсэн багшийн тоо, сумаар, 2017-2022 он.....	101
Зураг№59.	Сургуулийн өмнөх байгууллагын ажиллагчдын тоо, төрлөөр, 2017-2022 он 102	
Зураг№60.	Баяндэлгэр суманд бүртгэлтэй үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж байгууллагын тоо 2018-2022 он	104
Зураг№61.	Үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж байгууллагын тоо, үйл ажиллагаа эрхлэлтийн байдлаар 2018-2022 он.....	104
Зураг№62.	Газар ашиглалтын тохиромжтой байдлын үнэлгээ	107
Зураг№63.	Бэлчээрийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний зураг	109
Зураг№64.	Өвөл хаврын улирлын тохиромжтой байдал.....	112
Зураг№65.	Зун намрын улиралд тохиромжтой байдал	113
Зураг№66.	Тариалангийн газрын тохиромжтой байдлын үнэлгээ хийх аргачлал.....	114
Зураг№67.	Тариалангийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний зураг.....	115
Зураг№68.	Аялал жуулчлалын газрын тохиромжтой байдлын нэгдсэн үнэлгээний зураг 117	
Зураг№69.	Шугаман байгууламжийн тохиромжтой байдлын нэгдсэн үнэлгээний зураг 119	
Зураг№70.	Баяндэлгэр сумын ГНС-ын ангилал, /га-аар/ 2022 он.....	121
Зураг№71.	Баяндэлгэр сумын ГНС-ын ангилал, /хувиар/ 2022 он.....	122

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт№1.	Засаг захиргааны анхан шатны нэгж, 2022 оны байдлаар	7
Хүснэгт№2.	Баяндэлгэр сумын хилийн цэсийн эргэлтийн цэг, солбицол	8
Хүснэгт№3.	Баяндэлгэр сумтай хиллэдэг сумд, хилийн урт	9
Хүснэгт№4.	Багуудын газар нутгийн хэмжээ, эзлэх хувь	11
Хүснэгт№5.	Баяндэлгэр сумын байршлын үзүүлэлтүүд	12

Хүснэгт№6.	Агаарын олон жилийн дундаж температур, Баяндэлгэр өртөө, 1991-2020 он 17	
Хүснэгт№7.	Баяндэлгэр сумын агаарын үнэмлэхүй их, бага температурын норм, 1991- 2020 он 18	
Хүснэгт№8.	Баяндэлгэр өртөө, Салхины дундаж хурд м/с /2016-2020/	18
Хүснэгт№9.	Цасан болон шороон шуургатай өдрийн тоо, 2016-2021 он	19
Хүснэгт№10.	Хур тунадас, Баяндэлгэр өртөө, мм, 2016-2020	20
Хүснэгт№11.	Баяндэлгэр сумын байгаль нутаг дэвсгэрийн муж, тойрог	31
Хүснэгт№12.	Дундад халхын болон дорнод Монголын талархаг хээрийн мужийн хөрсний нөөц 36	
Хүснэгт№13.	Дорнод говийн цөлөрхөг мужийн хөрсний нөөц	37
Хүснэгт№14.	Дундад халхын болон дорнод Монголын талархаг хээрийн мужийн сээр нуруутан амьтдын зүйлийн бүрэлдэхүүн*	38
Хүснэгт№15.	Дорнод говийн цөлөрхөг мужийн сээр нуруутан амьтдын зүйлийн бүрэлдэхүүн* 38	
Хүснэгт№16.	Ширхгийн бүрэлдэхүүн болон чийгийн төлөв байдлын үзүүлэлт	39
Хүснэгт№17.	Нягт болон ул хөрсний механик шинж чанарын үзүүлэлтийн норматив болон тооцооны утга	39
Хүснэгт№18.	Чулуулгийн физик механик шинж чанарын үзүүлэлт	40
Хүснэгт№19.	Хөрс, чулуулгийн овойлт болон газар шорооны ажлын зэрэг	40
Хүснэгт№20.	Усны сав газрын үзүүлэлт	41
Хүснэгт№21.	Сав газрын усны тооллогоор бүртгэгдсэн булаг	43
Хүснэгт№22.	Сав газрын усны тооллогоор бүртгэгдсэн нуур, тойром	44
Хүснэгт№23.	Худгийн бүртгэл	46
Хүснэгт№24.	Газрын доорх усны нөөц баялгийн нөхцөлийн шалгуур	53
Хүснэгт№25.	Баяндэлгэр сумын гидрогеологийн нөхцөл	55
Хүснэгт№26.	Баяндэлгэр сумын газрын доорх усны ашиглалтын нөөц	55
Хүснэгт№27.	Ундны усны стандартын шаардлага хангаагүй худаг, уст цэгүүд, болон стандарт хангаагүй үзүүлэлтүүд	57
Хүснэгт№28.	Баяндэлгэр сумын ургамалжилт	65
Хүснэгт№29.	Баяндэлгэр сумын аялал жуулчлалын өрсөлдөх чадвар	68
Хүснэгт№30.	Улсын тусгай хамгаалалтад авсан газар	71
Хүснэгт№31.	Орон нутгийн тусгай хамгаалалттай газрын мэдээлэл	72
Хүснэгт№32.	Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн судалгаа	74
Хүснэгт№33.	Хүн амын тоон өөрчлөлт	76
Хүснэгт№34.	Баяндэлгэр сумын хүн амын ердийн өсөлт	77
Хүснэгт№35.	Хүн амын ердийн цэвэр өсөлт/бууралтын коэффициент	78
Хүснэгт№36.	Хүн ам зүйн ачаалал	79
Хүснэгт№37.	Баяндэлгэр сумын хүн амын нягтрал	80
Хүснэгт№38.	Гэрлэлт, гэр бүл цуцлалт	82
Хүснэгт№39.	Гэрлэлт хүйс, насны бүлгээр	82
Хүснэгт№40.	Баяндэлгэр сумын нийт өрхийн тоо, багаар	83
Хүснэгт№41.	Өрхийн ам бүлийн дундаж	85
Хүснэгт№42.	Баяндэлгэр сумын шилжих хөдөлгөөн, 2017-2021 он	86
Хүснэгт№43.	Дотоод шилжих хөдөлгөөний цэвэр коэффициент	86
Хүснэгт№44.	Малчин өрхийн тоо, багаар	87
Хүснэгт№45.	Малтай өрх	88
Хүснэгт№46.	Малын тоо, төрлөөр 2017-2022 он	89
Хүснэгт№47.	Нийт малын тоо, багаар 2017-2022 он	90
Хүснэгт№48.	Хээлтэгч малын тоо /багаар/	91
Хүснэгт№49.	Хээл хаясан хээлтэгч малын тоо	92
Хүснэгт№50.	Хээл хаясан хээлтэгч малын тоо	92
Хүснэгт№51.	Сувайрсан малын тоо, төрлөөр	92
Хүснэгт№52.	Малын зүй бусын хорогдол, багаар	93

Хүснэгт№53.	Баяндэлгэр сум нийт бойжуулсан төл.....	93
Хүснэгт№54.	Баяндэлгэр сумын 2022 оны малын тоо, сүргийн бүтэц.....	95
Хүснэгт№55.	Баяндэлгэр сумын нийт тариалсан талбай га, төрлөөр 2017-2022 он..	95
Хүснэгт№56.	Баяндэлгэр сумын нийт тариалсан талбай га, багаар, төрлөөр, 2021 он	97
Хүснэгт№57.	Баяндэлгэр сумын нийт хурасан ургац тн, төрлөөр 2017-2022 он.....	99
Хүснэгт№58.	Га талбайд ноогдох ургацын хэмжээ.....	100
Хүснэгт№59.	Байгалийн хадлан тэжээл бэлтгэл, тн.....	100
Хүснэгт№60.	Тэжээлийн ургамлын тариалсан талбай, га.....	100
Хүснэгт№61.	ЕБС-д өдрөөр суралцагчдын тоо, сумаар, 2017-2022 он.....	101
Хүснэгт№62.	ЕБС-ийн үндсэн багшийн тоо, сумаар, 2017-2022 он.....	101
Хүснэгт№63.	Сургуулийн өмнөх боловсролын мэдээний үзүүлэлтүүд, 2020-2022.....	102
Хүснэгт№64.	Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад ажиллагсдын тоо, 2020-2021	102
Хүснэгт№65.	Сургуулийн өмнөх байгууллагын ажиллагчдын тоо, төрлөөр, 2017-2022	102
Хүснэгт№66.	Бизнес регистрийн санд бүртгэлтэй үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж байгууллагын тоо 2018-2022 он.....	103
Хүснэгт№67.	Бизнес регистрийн санд бүртгэлтэй үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж байгууллагын тоо, үйл ажиллагаа эрхлэлтын байдлаар 2018-2022 он.....	104
Хүснэгт№68.	Ажилгүй иргэдийн тоо.....	105
Хүснэгт№69.	Ажилгүй иргэдийн тооны өсөлт, бууралт.....	105
Хүснэгт№70.	Хадгаламжийн мэдээлэл /сая.төг/.....	105
Хүснэгт№71.	Баяндэлгэр сумын нийт хадгаламжийн мэдээлэл 2018-2022 он.....	106
Хүснэгт№72.	Нийт зээлийн хэмжээ, сая.төг.....	106
Хүснэгт№73.	Нийт зээлийн хэмжээ, сая,төг.....	106
Хүснэгт№74.	Бэлчээрийн ашиглалтын хүчин зүйлүүдийг эрэмбэлж жигнэх нь.....	109
Хүснэгт№75.	Өвөл-хаврын бэлчээр ашиглалтын тохиромжтой байдлын нэгдсэн үнэлгээ	112
Хүснэгт№76.	Зун-намрын бэлчээр ашиглалтын тохиромжтой байдлын хүчин зүйлийн нэгдсэн үнэлгээ	112
Хүснэгт№77.	Тариалангийн газрын хүчин зүйлүүдийг эрэмбэлж жигнэх нь.....	114
Хүснэгт№78.	Тариалангийн газрын тохиромжтой байдлын үнэлгээ.....	116
Хүснэгт№79.	Аялал жуулчлалын газрын тохиромжтой байдлын үнэлгээ.....	116
Хүснэгт№80.	Авто болон төмөр замын зориулалтаар ашиглаж болох газрын нэгдсэн үнэлгээ эрэмбэ, жингийн утга.....	118
Хүснэгт№81.	Цахилгаан дамжуулах агаарын шугам татах газрын нэгдсэн үнэлгээ эрэмбэ, жингийн утга.....	118
Хүснэгт№82.	Газрын хүчин зүйлүүдийн эрэмбэ, жингийн утга.....	118
Хүснэгт№83.	Шугаман байгууламжийн зориулалтаар ашиглах газрын суурь нөхцөл	118
Хүснэгт№84.	Шугаман байгууламжийн тохиромжтой байдлын үнэлгээ.....	120
Хүснэгт№85.	Баяндэлгэр сумын ГНС-ын үндсэн ангилал.....	121
Хүснэгт№86.	ХАА-н газрын ангилал.....	122
Хүснэгт№87.	Хот тосгон бусад суурин газрын ангилал.....	122

ОРШИЛ

Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг уур амьсгалын өөрчлөлт, эрсдэл, эмзэг байдалтай уялдуулан боловсруулах ажлын үндсэн зорилго нь аймгийн хэмжээнд болон сумуудын нутаг дэвсгэрийн хил хязгаарын доторх байгаль газарзүйн нөхцөл, газрын нөөц, түүний экологи эдийн засаг, орон зайн багтаамж, чадавхыг үнэлсний үндсэн дээр тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд газрыг оновчтой, үр ашигтай эзэмших, ашиглах, хамгаалах, үр өгөөжийг нь сайжруулах бодлогыг тодорхойлон хэрэгжүүлэх арга хэмжээний менежментийг эрх зүй, шинжлэх ухааны үндэслэлтэй, төлөвлөлтөөр дэмжиж, газар эзэмшигч, ашиглагчдын эрх зүйн баталгааг хангаж, газрын кадастрыг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

Сүхбаатар аймгийн Засаг даргын тамгын газартай 2022 оны 06 дүгээр сарын 21-ны өдөр байгуулсан СБАОНӨГ/202109140 дугаар бүхий зөвлөх үйлчилгээний ажил гүйцэтгэх гэрээ болон гэрээний хавсралт болох ажлын даалгавар, ажил гүйцэтгэх төлөвлөгөөний дагуу гүйцэтгэв.

ЕРӨНХИЙ ХЭСЭГ



Баяндэлгэр сум нь Дарьганга хошууны баруун гар тэмээчин сүргийн нутагт 1925 онд байгуулагдсан. 7.1 мянган хавтгай дөрвөлжин км нутаг дэвсгэртэй, говийн бүст багтдаг, 1000-1200 метр өндөр ухаа, гүвээ, өндөрлөг гадаргатай.

Орлой гурван зээрд, Онгон таван булаг, Өөш морин хошуу, Өргөө таван толгой, Өргөн цагаан дэрс, Тойг тээгийн тал, Төгрөг гүйлстэйн нуруу болон Дөхөмийн говь, Дөхөмийн баян овоо, Онгон элс, Шал, Хужиртын ам, Дунд булгийн цоорхой, Цагаан булаг зэрэг дуу шүлэгт мөнхөрч, түүх шастирт дурсагдсан уул, ус, баянбүрд, элст манхан олонтой нутаг. Сумын төв нь Баруун-Уртаас 146 км, Улаанбаатараас 560 км, Сайншандаас 210 км зайтай, аймгийнхаа хамгийн баруун талын сум юм. Өмнөд хэсгээрээ БНХАУ-тай, баруун өмнөд хэсгээрээ Дорноговь аймгийн Өргөн, баруун, хэсгээрээ Дорноговь аймгийн Дэлгэрэх, хойд хэсгээрээ Сүхбаатар аймгийн Түвшинширээ, зүүн хойд хэсгээрээ Уулбаян, зүүн хэсгээрээ Халзан, зүүн өмнөд хэсгээрээ Онгон сумдтай хиллэдэг. Тус сум нь аймагтаа хамгийн олон малтай сум бөгөөд Ширээтийн цагаан адуу, сайн чанарын ноолууртай “Баяндэлгэр” омгийн нутгийн улаан ямаагаараа алдартай. Одоо хөгжлийн жинхэнэ эрин үед явж байгаа алдарт хүмүүсийн өлгий нутаг юм.

Баяндэлгэр суманд ерөнхий боловсролын сургууль 1 үйл ажиллагаа явуулдаг ба 1080 суралцагсад, 93 багш, ажилтан албан хаагч мөн 1 сургуулийн өмнөх боловсролын байгууллагад 169 хүүхэд, 11 багш, ажилтан албан хаагч ажиллаж байна. 2022 оны жилийн эцсийн байдлаар тус суманд Баян, Дэлгэр, Төв, Дөхөм, Хонгор, Ширээт 6 багийн 1420 өрхийн, 5083 хүн оршин суудаг бөгөөд нийт өрхийн 1109 малчин өрх байна. 2022 оны байдлаар нийт малын тоо 565805 тоологдсон байна. (<https://bayandelger.mn/>, 2022)

Хүснэгт №1. Засаг захиргааны анхан шатны нэгж, 2022 оны байдлаар

№	Багийн нэр	Хүн ам	Өрхийн тоо	Малын тоо
1	1-р баг, Баян	856	234	109433
2	2-р баг, Дэлгэр	810	219	85611
3	3-р баг, Төв	681	194	87514
4	4-р баг, Дөхөм	979	269	130942
5	5-р баг, Хонгор	848	243	109855
6	6-р баг, Ширээт	909	261	42450
	Нийт дүн	5083	1420	565805

СУМЫН ХИЛИЙН ЦЭС

Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын хилийн цэсийг анх БНМАУ-ын АИХ тэргүүлэгчдийн 1977 оны 4-р сарын 04-ний өдрийн 75-р зарлигийн 1-р хавсралтаар батлагдсан. Энэ зарлигаар Баяндэлгэр сумын хилийн цэсийг Чандмань овоо /894.0/, Морин хошууны хойд худаг, Холбоо шарилж, баруун зүүн бор толгой /1018.2/, Хар тойрмын урд эрэг, 113.3 тоот, Тосонгийн худаг, Тосохгийн овоо /1089.4/, 7-р шон, сайрын худаг, Хонгор овоо /1047.8/, Хонгор худаг, 1067.3 тоот, Бэлгэхийн худаг, Билүүтийн худаг, Бор хужирын овоо /1162.7/, Бор хужирын худаг, Баяр ихтийн овоо /1159.9/, Цагаан худаг, Төгрөгийн худаг, 1103.2 тоот, Хонтгор чулуу /1022.6-390-р тэмдэг/, улсын хилээр, 384-р тэмдэг, Зүүн уртын эхэн шандын худаг, 1113.5, 1022.2, 889.9 тоотууд, Оорцог овоо, 1049.5 тоот, Нарангийн овоо /1052.8/, 1040.2: 1012.9 тоотууд, гашуун сүүжийн худаг, Хөнхөр цант /1058.0/, Баян-өндөр /1024.4/, Түвшин ширээ уул /1020.4/, Сайн усны худаг, 918.3 тоот, Хар нуурын зүүн эрэг, Бага лахтын худаг, Чандмань овоо /894.0/ зэрэг газруудаар тогтоосон байна.

Баяндэлгэр сум нь Баян, Дэлгэр, Төв, Дөхөм, Хонгор, Ширээт гэсэн 6 багтай байна.

Хүснэгт №2. Баяндэлгэр сумын хилийн цэсийн эргэлтийн цэг, солбицол

Цэгийн дугаар	Сум	Эргэлтийн цэгийн нэр	Өргөрөг	Уртраг
1	Баяндэлгэр	Чандмань их овоо	46° 12' 26.221"	112° 26' 19.821"
2	Баяндэлгэр	Морин хушууны хойт худаг	46° 4' 36.428"	112° 36' 22.728"
3	Баяндэлгэр	Холбоо шарилж	46° 0' 41.137"	112° 39' 31.399"
4	Баяндэлгэр	Баруун зүүн бор толгой	45° 58' 16.571"	112° 49' 1.244"
5	Баяндэлгэр	Хар тойрмын урд эрэг	45° 58' 43.327"	112° 53' 55.254"
6	Баяндэлгэр	1130.3	46° 0' 32.000"	112° 59' 44.171"
7	Баяндэлгэр	Адаг тосонгийн худаг	45° 56' 13.086"	112° 57' 22.913"
8	Баяндэлгэр	Цагаан овоо/Тосонгийн овоо/	45° 54' 43.001"	112° 57' 10.481"
9	Баяндэлгэр	Шон 7	45° 50' 38.555"	112° 57' 46.476"
10	Баяндэлгэр	Сайрын худаг	45° 49' 36.489"	112° 57' 42.914"
11	Баяндэлгэр	Хонгор овоо	45° 46' 45.212"	112° 55' 55.951"
12	Баяндэлгэр	Хонгорын худаг	45° 45' 9.944"	112° 57' 21.386"
13	Баяндэлгэр	1067.3	45° 42' 52.560"	112° 57' 31.527"
14	Баяндэлгэр	Билгэхийн худаг	45° 36' 21.694"	112° 54' 50.690"
15	Баяндэлгэр	Билүүтийн худаг	45° 34' 2.772"	112° 51' 56.646"
16	Баяндэлгэр	Бор хужирын овоо	45° 31' 59.567"	112° 50' 41.014"
17	Баяндэлгэр	Бор хужирын худаг	45° 30' 36.823"	112° 49' 50.366"
18	Баяндэлгэр	Баяр ихэтийн овоо	45° 29' 56.212"	112° 48' 18.799"
19	Баяндэлгэр	Цагаан худаг	45° 27' 27.047"	112° 44' 33.985"
20	Баяндэлгэр	Төгрөгийн худаг	45° 23' 45.499"	112° 38' 18.805"
21	Баяндэлгэр	1103.2	45° 14' 15.429"	112° 27' 33.358"
22	Баяндэлгэр	Хонтгорын чулуу	45° 4' 30.555"	112° 25' 24.103"
23	Баяндэлгэр	улсын хилийн 384р тэмдэгт	45° 5' 0.440"	111° 58' 31.684"
24	Баяндэлгэр	Зүүн уртын эхэн шандын худаг	45° 12' 55.511"	111° 57' 48.192"
25	Баяндэлгэр	1113.5	45° 16' 21.135"	111° 59' 15.387"
26	Баяндэлгэр	1022.2	45° 19' 13.485"	111° 56' 12.315"
27	Баяндэлгэр	889.9	45° 23' 30.988"	111° 50' 37.429"
28	Баяндэлгэр	Оорцог овоо	45° 27' 11.024"	111° 51' 19.888"
29	Баяндэлгэр	1049.5	45° 30' 15.760"	111° 46' 23.746"
30	Баяндэлгэр	Нарангийн овоо	45° 31' 9.074"	111° 43' 54.400"

**БАЯНДЭЛГЭР СУМЫН НУТАГ ДЭВСГЭРИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
СУУРЬ СУДАЛГААНЫ ТАЙЛАН**


2023 он

31	Баяндэлгэр	1040.2	45° 35' 0.965"	111° 44' 45.201"
32	Баяндэлгэр	1012.9	45° 37' 16.957"	111° 45' 5.533"
33	Баяндэлгэр	Гашуун сүүжийн худаг	45° 38' 3.497"	111° 45' 17.237"
34	Баяндэлгэр	Хөнхөр цант	45° 47' 52.088"	111° 47' 14.306"
35	Баяндэлгэр	Баян өндөр	45° 49' 33.072"	111° 50' 34.722"
36	Баяндэлгэр	Түвшинширээ уул	45° 52' 26.968"	111° 54' 32.464"
37	Баяндэлгэр	Сайн усны худаг	45° 53' 38.192"	111° 58' 33.735"
38	Баяндэлгэр	918.3	45° 55' 46.774"	112° 2' 42.959"
39	Баяндэлгэр	Хар нуурын зүүн эрэг	45° 57' 24.700"	112° 6' 51.200"
40	Баяндэлгэр	Бага лахтын худаг	46° 5' 33.757"	112° 10' 11.289"

Хүснэгт №3. Баяндэлгэр сумтай хиллэдэг сумд, хилийн урт

№	Хиллэх сум	Хилийн урт, км
1	Түвшинширээ	46.9
2	Уулбаян	24
3	Халзан	55.4
4	Онгон	120
5	Дэлгэрэх	31.2
6	Өргөн	57.7
7	БНХАУ	36.6
НИЙТ		371.8

Зураг№1. Баяндэлгэр сумын сумын хилийн цэсийн зураг



Багийн товч мэдээлэл: Баяндэлгэр сум нь засаг захиргааны нэгжийн хувьд Баян, Дэлгэр, Төв, Дөхөм, Хонгор, Ширээт гэсэн 6 багтай.

Хүснэгт №4. Багуудын газар нутгийн хэмжээ, эзлэх хувь

№	Багийн нэр	Талбайн хэмжээ, га
1	1-р баг, Баян	149309.14
2	2-р баг, Дэлгэр	171608.68
3	3-р баг, Төв	996.37
4	4-р баг, Дөхөм	134116.85
5	5-р баг, Хонгор	145242.68
6	6-р баг, Ширээт	156135.33
	БҮГД	757409.05

Баян баг: Тус баг нь 2022 оны жилийн эцсийн байдлаар 856 хүн амтай, нийт 234 өрхтэй. Нийт 109433 толгой мал тоологдсон байна.

Дэлгэр баг: Тус баг нь 810 хүн амтай, нийт 219 өрхтэй. 2022 оны жилийн эцсийн байдлаар 85611 мал тоологдсон байна.

Төв баг: Тус баг нь 681 хүн амтай, нийт 194 өрхтэй. 2022 оны жилийн эцсийн байдлаар 87514 мал тоологдсон байна.

Дөхөм баг: Тус баг нь 979 хүн амтай, 269 өрхтэй, 2022 оны жилийн эцсийн байдлаар 130942 мал тоологдсон байна.

Хонгор баг: Тус баг нь 848 хүн амтай, 243 өрхтэй, 2022 оны жилийн эцсийн байдлаар 109855 мал тоологдсон байна.

Ширээт баг: Тус баг нь 909 хүн амтай, 261 өрхтэй, 2022 оны жилийн эцсийн байдлаар 42450 мал тоологдсон байна.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. СУМЫН БАЙГАЛЬ, ЦАГ УУРЫН ОНЦЛОГ

1.1. СҮХБААТАР АЙМГИЙН БАЯНДЭЛГЭР СУМЫН ГАЗРЫН ГАДАРГА, ГАЗАРЗҮЙН БАЙРЛАЛ

Баяндэлгэр сумын хилийн шугамын нийт урт нь 371.8 км бөгөөд Түвшинширээ сумтай 46.9 км, Уулбаян сумтай 24 км, Халзан сумтай 55.4 км, Онгон сумтай 120 км Дорноговь аймгийн Дэлгэрэх сумтай 31.2 км, Өргөн сумтай 57.7 км, БНХАУ-тай 36.6 км урт газар нутгаар хиллэн оршиж байна. Физик газарзүйн хувьд Дундад халхын болон Дорнод Монголын тал, Дорнод Монголын нам уулс, цав толгодууд, цөлөрхөг хээрийн мужид багтдаг. Байгалийн бүс бүслүүрийн хувьд хуурай хээр, цөлжүү хээрийн бүсүүдэд багтана. Байгаль нутаг дэвсгэрийн цогцолбор нөхцөлийн муж тойргийн хувьд Дундад Халхын болон Дорнод Монголын талархаг хээрийн мужийн Хэрлэн голын өмнөд Баруун уртын нам уулсын тойрог (Т-3), мөн Дорнод говийн цөлөрхөг мужийн Дорнод говийн хойд хэсгийн тойрог (Г-9), гэсэн тойргуудад харьяалагдана. Ерөнхийдөө тэгш талархаг гадаргуутай бөгөөд нутгийн төв хэсгээр цөөн тооны намхан уулстай бөгөөд эдгээр уулсын үнэмлэхүй өндөр нь далайн түвшнээс дээш 1226м хүрнэ. Нутгийн зүүн хэсэгт Хонгорын элс, зүүн өмнөд хэсэгт Онгоны элс зэрэг томоохон элснүүд оршдог. Урд хэсэгт улсын хил орчим газрын гадарга ил гарсан том том хад чулуу нэлээд их тохиолдоно. Томоохон гол горхи байхгүй, гадаргын усны хангамж муутай бүс нутагт тооцогдоно. Тус сумын нутагт хөрс үүсгэгч эх чулуулаг нь эльюви, дэлювийн хурдас зонхилно.


Хүснэгт№5. Баяндэлгэр сумын байршлын үзүүлэлтүүд

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
1	Аймгийн төвөөс зай	Км	150
2	Улсын нийслэлээс	Км	600
3	Дорноговь аймгийн Сайншанд	Км	200


Зураг№2. Баяндэлгэр сумын байршлын схем




Зураг №3. Өндөржилтийн зураг




Зураг№4. Налуужилтын зураг



Зураг №5. Зүг зовхисын зураг



Зураг №6. Геоморфологийн зураг



1.2. БАЙГАЛЬ ЦАГ УУР, УУР АМЬСГАЛЫН НӨХЦӨЛ


1.2.1. Агаарын температур

Агаарын температурын олон жилийн дундажаас Баяндэлгэр сумын дулаан, хүйтний горимыг ажиглахад сумын нутгаар жилийн хамгийн хүйтэн нь 1-р сар байх ба олон жилийн дундаж нь -18.8°C ба 7-р сард хамгийн дулаан буюу 21.7°C хүрч ажиглагджээ. (Сүхбаатар аймгийн ус цаг уур орчны шинжилгээний төв, 2022)

Хүснэгт №6. Агаарын олон жилийн дундаж температур, Баяндэлгэр өртөө, 1991-2020 он

Үзүүлэлт	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII	Жил
Дундаж	-18.8	-14.1	-4.9	5.1	12.9	18.9	21.7	19.8	13.1	3.4	-8.2	-16.7	2.7
Стан/хазайлт	2.7	2.7	2.5	2.2	1.5	1.8	1.5	1.6	1.5	1.6	2.5	2.0	2.0
Тох/тоо	30.0	30.0	30.0	30.0	30.0	30.0	30.0	30.0	30.0	30.0	30.0	30.0	30.0
Үнэм/их	2.2	10.9	22.5	29.4	36.2	38.9	40.3	39.9	36.9	30.5	16.0	4.6	40.3
Үнэм/бага	-44.2	-40.5	-37.7	-21.4	-9.1	-0.5	5.1	-1.2	-8.9	-22.5	-38.3	-43.9	-44.2
Тох/тоо	82.0	82.0	82.0	82.0	82.0	82.0	82.0	82.0	82.0	82.0	82.0	82.0	82.0

Зураг №7. Агаарын дундаж температурын норм, Баяндэлгэр өртөө, градус, 1991-2020 он



/Эх үүсвэр: Сүхбаатар аймгийн УЦУОШТ, 2022он/

Сарын дундаж үнэмлэхүй их, үнэмлэхүй бага температур.


Тухайн сарын өдөр бүр ажиглагдсан үнэмлэхүй их температурын утгуудыг хооронд нэмж, гарсан утгыг тухайн сард оногдох өдрийн тоонд хувааж илэрхийлнэ. Сарын дундаж үнэмлэхүй бага температур нь дээрхтэй адилхан буюу тухайн сарын өдөр бүрийн үнэмлэхүй бага температурыг хооронд нь нэмж гарсан утгыг тухайн сард оногдох өдрийн тоонд хуваана. Үнэмлэхүй их температурын хамгийн өндөр утга өдрийн цагт нартай үед, үнэмлэхүй бага температурын хамгийн бага утга шөнийн цагт, үүрээр нар мандахаас өмнө ажиглагддаг.

Уур амьсгалын стандарт нормоос үзэхэд, Баяндэлгэр өртөөнд агаарын үнэмлэхүй бага температур -44.2°C , агаарын үнэмлэхүй их температурын утга 40.3°C байна.

Хүснэгт№7. Баяндэлгэр сумын агаарын үнэмлэхүй их, бага температурын норм, 1991-2020 он

Үзүүлэлт	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII	жил
Агаарын үнэмлэхүй их температур	2.2	10.9	22.5	29.4	36.2	38.9	40.3	39.9	36.9	30.5	16	4.6	40.3
Агаарын үнэмлэхүй бага температур	-44.2	-40.5	-37.7	-21.4	-9.1	-0.5	5.1	-1.2	-8.9	-22.5	-38.3	-43.9	-44.2

Зураг№7. Баяндэлгэр сумын агаарын үнэмлэхүй их, бага температурын норм, 1991-2020 он



1.2.2. Салхины горим

Салхины горим нь агаар мандлын орчил урсгал, агаарын даралт, тухайн нутгийн физик газар зүйн нөхцөлөөс ихээхэн шалтгаалдаг.


Сүхбаатар аймгийн ус цаг уур орчны шинжилгээний газраас авсан 2016-2020 оны мэдээллээр тус сумын салхины дундаж хурд хавар 5 дугаар сард, өвөл 10,11 дугаар сард өндөр байна.

Хүснэгт№8. Баяндэлгэр өртөө, Салхины дундаж хурд м/с /2016-2020/

Он	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	Нийлбэр
2016	3.7	4.5	4.5	4.9	5.8	2.9	2.5	3	2.4	2.9	3.5	3.4	44
2017	3	3	3.1	4.6	5.1	2.6	3.1	2.4	3.5	2.8	3.5	3.4	40.1
2018	3.2	3.7	4.1	4.5	5.4	2.8	2.6	2.7	2.3	2.7	3.4	3.2	40.6
2019	4	3	3.9	3.6	5.5	5.2	2.7	2.8	2.9	4.2	3.3	3.3	44.4
2020	1.9	3.2	4.2	3.9	4.7	3.3	2.1	2.3	2.8	4.3	3.3	3.5	39.5
дундаж	3.16	3.48	3.96	4.3	5.3	3.36	2.6	2.64	2.78	3.38	3.4	3.36	41.72

/Эх үүсвэр: Сүхбаатар аймгийн УЦУОШТ, 2022он/

Зураг№8. Баяндэлгэр өртөө, салхины дундаж хурд м/с 2016-2020 оны дунджаар



/Эх үүсвэр: Сүхбаатар аймгийн УЦУОШТ, 2022он/


Өвөл, зуны байгаль, цаг уурын хамгийн тохиромжтой нөхцөлд малын ашиг шим, удамшлын чадамж дээд зэргээр илэрдэг. Харин, цаг уурын тохиромжтой нөхцөл өөрчлөгдөх нь мал сүрэгт сөргөөр нөлөөлж тарга хүч, ашиг шим нь муудах ялангуяа дасан зохицох чадварын хэмжээнээс хэтэрвэл үхэж хорогддог байна (Төмөржав, 2004, Туваансүрэн нар, 1996).

Доорх хүснэгтээс харахад Баяндэлгэр сумын цасан болон шороон шуургатай өдрийн тоо 2016 онд хамгийн их буюу цасан шуургатай өдөр 15, шороон шуургатай өдөр 12 байсан ба эдгээр өдрүүд бусад онуудад багассан төлөвтэй харагдаж байна. 2016 онд тус сумын салхины дундаж хурд 12 сарын нийлбэр дүнгээр 44 м/с байсан бол 2020 онд 39.5 м/с болж буурсан байна. Үүнтэй холбоотойгоор 2020 оны цасан болон шороон шуургатай өдрийн тоо бусад оноос бага байгаа нь ажиглагдаж байна.

Хүснэгт№9. Цасан болон шороон шуургатай өдрийн тоо, 2016-2021 он

Сум	2016		2017		2018		2019		2020		2021	
	Цасан шуургатай өдрийн тоо	Шороон шуургатай өдрийн тоо	Цасан шуургатай өдрийн тоо	Шороон шуургатай өдрийн тоо	Цасан шуургатай өдрийн тоо	Шороон шуургатай өдрийн тоо	Цасан шуургатай өдрийн тоо	Шороон шуургатай өдрийн тоо	Цасан шуургатай өдрийн тоо	Шороон шуургатай өдрийн тоо	Цасан шуургатай өдрийн тоо	Шороон шуургатай өдрийн тоо
Баяндэлгэр	15	12	8	11	8	11	7	12	3	2	16	7

Зураг№9. Цасан болон шороон шуургатай өдрийн тоо, жилийн дунджаар, 2016-2021 он



1.2.3. Чийгийн горим

Тус сумын нутаг хуурайдуу уур амьсгалтай бүсэд багтана. Агаарт хуурай хөрснөөс уурших чийгийн нөөц бага учраас жилийн дулаан улирлын дундаж харьцангуй чийгшил 30-60 хувь хүрнэ. 30 хувиас бага чийгтэй өдрийн тоо 51-62 өдөр байна. Зарим өдөр харьцангуй чийг 6-10 хувь хүртэл буурах явдал бий. Агаар хуурайдуу учир хур тунадасны хэмжээ жилд 108.7-280.6 мм хэмжээтэй орно.


Олон жилийн дунджаар 200.6 мм тунадас орох боловч гантай жил 101.5-111.5 мм болж эрс багасдаг байна. Хүйтний улирал болох 1-3, 10-12 дугаар саруудад хамгийн бага тунадас дунджаар 1.5-10.5 мм, дулааны улирал болох 4-9 дүгээр саруудад дунджаар 4.9-56.7 мм тунадас ордог байна.

Хүснэгт№10. Хур тунадас, Баяндэлгэр өртөө, мм, 2016-2020

Он	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	нийлбэр
2016	0.9	0	0	2.4	72.9	34	43	0	62	21.3	3.3	2.4	241.9
2017	2.7	1.3	0	4.4	4	4.1	44	45	13	0.3	2.6	0	120.9
2018	5.6	0.9	0.6	20.6	2.5	0.8	62	64	38	1.1	2	0	198.2
2019	0.6	0.2	0.6	5.4	25.8	11	54	76	12	2.6	1.6	3.7	194.1
2020	0	0.2	0.2	0.8	31	22	71	98	1.9	9.1	11.6	0	245.3
дундаж	1.96	0.52	0.28	6.72	27.2	14	55	56	25	6.88	4.22	1.22	200.08


/Эх үүсвэр: Сүхбаатар аймгийн УЦҮОШТ, 2022он/

Зураг№10. Дундаж хур тунадас, мм, 2016-2020



/Эх үүсвэр: Сүхбаатар аймгийн УЦУОШТ, 2022он/

Зураг№11. Агаарын даралтын зураг




1.3. БАЙГАЛЬ ЦАГ УУРЫН НӨХЦӨЛ ӨӨРЧЛӨЛТ


Уур амьсгалын ногоон сангийн санхүүжилтээр БОАЖЯ, ХХААЯ, НҮБХХ хамтран 2021 оноос хэрэгжүүлж байгаа “Монголын орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамжийг дээшлүүлэх, эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох нь” буюу АДАПТ төслийн захиалгаар “Жэмр” ХХК-ийн гүйцэтгэсэн “Сүхбаатар аймгийн уур амьсгалын өөрчлөлтийн өнөөгийн нөхцөл байдалд үнэлгээ хийх, үр дүнг ашиглан эдийн засгийн тэргүүлэх салбаруудын төлөвлөлтийг туршилтын хэлбэрээр хийх” зөвлөх үйлчилгээний тайланд тусгагдсаны дагуу Сүхбаатар аймгийн Баяндэлгэр станцын 1940-2021 оны жил бүрийн дундаж агаарын температур, жилийн нийлбэр хур тунадсыг авч үзэхэд агаарын температур 82 жилд 2.40C-3.40C -ээр нэмэгдсэн (99% статистик үнэмшилтэй), хур тунадас 10 жил тутамд Баяндэлгэр станцад 0.2 мм багассан байна (статистик үнэмшилгүй).

Зураг№12. 1940-2021 оны агаарын температур, хур тунадасны үзүүлэлт

Жилийн дундаж агаарын температур, 1940-2021 он




Жилийн нийлбэр хур тунадас, 1940-2021 он




Тус төслийн хүрээнд Уур амьсгал, ургамалжилтын өөрчлөлтийг үнэлэхдээ 2000-2021 оны жил бүрийн ургамалжилт олон жилийн дунджаас -1σ (стандарт хазайц)-аас бага байсан, газрын гадаргын температур болон ууршилт олон жилийн дунджаас $+1\sigma$ -их байсан жилийн хазайцын (Z-score) утгуудыг авч жинлэсэн нийлбэрийг тооцоолж нэгтгээд сум тус бүрээр статистик үзүүлэлтүүдийг гаргаж сумдыг эрэмбэлсэн. Тус эрэмбээр Баяндэлгэр сум уур амьсгал, ургамалжилтын нормчиллоор буюу зуншлагын өнөөгийн байдлаар өөрийн аймгийн 13 сумаас 13-рт, стандартчилал буюу зуншлагын өөрчлөлтөөр 9-рт эрэмбэлэгдсэн байна. (“Татмын ой, отрын бэлчээр, булаг шанд хамгаалах, тэжээлийн агуулах байгуулах газрыг эрсдэл, эмзэг байдлыг харгалзан сонгож, сайн туршлагад түшиглэн хэрэгжүүлэх бэлтгэл хангах” төслийн тайлан, 2022 он)

Зураг №13. Сүхбаатар аймгийн сумдын байгаль, цаг уурын нөхцөл, өөрчлөлт




Дээрх графикаас харахад Баяндэлгэр сум байгаль, цаг уурын нөхцөл, хазайцын үзүүлэлтээр Ургамалжилт бага, халалт, ууршилт их, өөрчлөлт бага суманд багтсан байна. 2000-2021 оны 5-8 дугаар сарын дундаж газрын гадаргын температур, нийлбэр ууршилт, дундаж ургамалжилтын индексийн мэдээллийг нормчилж, стандартчилж олон жилийн дундаж нөхцөл байдал болон түүнээс хазайх цараа, давтагдал буюу өөрчлөлтийг Баяндэлгэр сумаар гаргахад ургамалжилтын нормчилж буюу дундаж нөхцөл байдлаар ≤ 0.32 маш муугаас, $0.32-0.35$ муу, $0.35-0.41$ дунджаас муу, $0.41-0.47$ буюу дунджид хамаарах үнэлгээ авсан байгаа ба уур амьсгал, ургамалжилтын стандартчилсан буюу өөрчлөлтийн хувьд < 3 буюу маш бага өөрчлөлттэйгөөс $10 <$ маш их их өөрчлөлттэй байна.

Зураг №14. Баяндэлгэр сумын уур амьсгал, ургамалжилтын нормчиллол /Зунилагын байдал/



Зураг №15. Баяндэлгэр сумын уур амьсгал, ургамалжилтын стандартчилал
/Зуншлагын байдал/



1.4. Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл, эрсдэл эмзэг байдал

1.4.1. Шороон шуурга, хүчтэй салхитай өдрийн тоо.

Уур амьсгалыг бүрдүүлэгч хүчин зүйлүүдийн дотор байгалийн тэнцвэрт байдлыг хангах нөхцөлүүдэд хуурайшлын зэргийн үзүүлэлт чухал байр суурь эзэлдэг. Үүнийг шороон шуурга буюу хүчтэй салхитай өдрийн давтамжийн тоогоор илэрхийлдэг.

Цаг уурт шороон шуургыг шороон /элсэн/ хуй, явган шороон шуурга, шороон шуурга, тоосон будан гэж ялган ажигладаг. Шороон шуурга нь салхины хурд, хөрсний гадаргын байдлаас хамаарч үүсдэг бөгөөд сар, улирал бүрд өөр давтамжтай тохиолддог жилийн явцтай. Сүхбаатар аймгийн нутаг дээр шороон шуурга хаварт хамгийн олон, зун, өвөлдөө цөөн, намартаа зун, өвлөөсөө арай олон тохиолддог байна.

Байгалийн гамшигт үзэгдлийн мэдээллийн санд Баяндэлгэр станцын мэдээ байгаагүй тул Баруун-Урт станцын мэдээллийг ашиглав. Баруун-Урт станцын 19 жилийн ажиглалтын мэдээнээс үзэхэд 2005 болон 2006 онд хамгийн их шороон шуургатай өдөр буюу жилд нийт 49, 58 удаа шороон шуурга тохиолдсон байна. Нийт нутгийн хэмжээгээр 2000 онд шороон шуургатай өдрийн тоо 34-т хүрсэн байгаа ба дараах онуудад буурч 11-15 өдөр тохиолдож 2004 оноос дахин шороон шуургатай өдрийн тоо нэмэгдсэн төлөвтэй байх ба 2004-2011 онуудын хооронд 17-58 өдөр шороон шуургатай өдөр тохиожээ. 2012-2019 оныг өмнөх онуудтай харьцуулахад шороон шуургатай өдрийн тоо эрс багассан үзүүлэлттэй байна. 2004-2011 онуудад нийт нутгаар шороон шуургатай өдрийн тоо олон тохиолдсон нь хур тунадас буурсантай, хуурайшилт ихтэй байсантай холбоотой гэж үзэж болохоор байна.

Зураг №16. Шороон шуургатай өдрийн тоо /2000-2019 он/




Эх сурвалж: Байгалийн гамшигт үзэгдлийн мэдээллийн сан <https://sur.ly/o/eic.mn/>

Хүчтэй салхи нь Монгол оронд тохиолддог цаг агаарын аюулт үзэгдлийн нэг юм. Хүчтэй салхи буюу 16 м/с хүртэлх хурдтай салхитай өдрийн ажиглалтын мэдээнээс үзэхэд нийт нутгаар орон зайн хувьд ч, цаг хугацааны хувьд ч харилцан адилгүй ажиглагдсан байх ба 2006 онд хүчтэй салхи буюу 16 м/с-ээс их хурдтай салхи 41 өдөр, 2009-2010 онуудад хүчтэй салхи буюу 16 м/с-ээс их хурдтай салхи 42-53 өдөр тохиолдсон нь хамгийн олон удаа давтагдсан ажиглагдаж байна. 2012-2019 оны хооронд хүчтэй салхитай өдрийн тоо өмнөх онуудтай харьцуулахад буурсан төлөвтэй байх бөгөөд 2019 онд гэхэд нийт нутгийн хэмжээнд хүчтэй салхитай 24 өдөр тохиолдсон байна.

Баруун-Урт станцын нэн хүчтэй салхи буюу 28 м/с хүртэлх их хурдтай салхитай өдрийн ажиглалтын мэдээнээс буюу доорх графикаас харахад 2005 онд 3 удаа, 2008-2009 онуудад нэн хүчтэй салхи буюу 28 м/с-ээс их хурдтай салхитай 2 өдөр тохиолдсон бол 2001-2002, 2006-2007, 2014, 2018 онуудад нэн хүчтэй салхи буюу 28 м/с-ээс их хурдтай салхитай 1 өдөр тохиолдсон байна.

Зураг №17. Нэн хүчтэй болон хүчтэй салхитай өдрийн тоо /2000-2019 он/



1.4.2. Цасан шуурга.

Монгол орны дорнод тал нутагт цасан шуурга элбэг тохиолддог цаг агаарын аюултай үзэгдэл юм. Цасан шуургыг дотор нь цасан шуурга, орон шуурга, намын шуурга, явган шуурга гэж ангилна. Сүхбаатар аймгийн нутагт цасан шуурга өвлийн улиралд 40%, хавар 3-4 дүгээр сард 32%, намар 10-11 дүгээр сард 28%-ийн давтагдалтай тохиолддог бөгөөд нийт нутгийн өмнөд болон зүүн хэсгээр Баяндэлгэр, Эрдэнэцагаан сумдын нутгаар цасан шуургатай өдрийн давтагдал их ажиглагддаг байна.

Сүхбаатар аймагт 1987 оны 12 дугаар сарын 21-ний 08 цагийн 500 гПа гадаргын өндрийн зураг дээр Монгол орны нутгийн зүүн хэсгийг хамарсан гүнзгий хотос илэрсэн байна. Газар орчмын бэсрэг циклон болон түүний фронтын долгион,

өндрийн гүнзгий хотосын нөлөөгөөр нөлөөгөөр салхины хурд 24 м/с хүрч цасан шуурга шуурч, орсон цасны зузаан 15-25 см хүрч, агаарын температур өмнөх хоногоосоо 6-9оС-аар буурсан байна. Энэ үед цасан шуурганы улмаас Сүхбаатар аймагт 6 хүн амиа алдаж 11 мянган мал, 8510 төл хорогдсон байна. Мөн 2005 оны 3 дугаар сарын 9-нд Сүхбаатар аймгийн нийт нутгаар хүчтэй цасан шуурга 6-19 цагийн турш үргэлжилж энэ үед салхины хурд 16 –20 м/с, зарим үед 22 м/с хүртэл ширүүсэж цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлийн хэмжээнд хүрч байжээ.

Баруун-Урт станцын 19 жилийн ажиглалтын мэдээнээс үзэхэд 2000-2009 онуудад цасан шуургатай өдрийн тоо 11-20 өдөр байсан бол 2010 онд урд оныхоос цасан шуургатай өдрийн тоо 11-ээр нэмэгдсэн байна. Нийт 19 жилийн хугацаанд хамгийн олон цасан шуурга тохиолдсон нь 2010 онд буюу 31 өдөр тохиолджээ. 2011-2019 онуудад цасан шуургатай өдрийн тоо 4-10 өдөр болж буурсан төлөвтэй байна.

Зураг№18. Цасан шуургатай өдрийн тоо /2000-2019 он/




Эх сурвалж: Байгалийн гамшигт үзэгдлийн мэдээллийн сан <https://sur.ly/o/eic.mn/>

Баяндэлгэр сумын зудын эрсдэлийн төлөв байдлыг 2000-2022 оны дунджаар Ус, цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнгээс гаргасан зудын эрсдэлийн зургаас харахад их эрсдэлтэй 274628.56 га, дунд зэрэг эрсдэлтэй 482710.64 га талбай байна. ADAPT төслийн хүрээнд “Уур амьсгалын эрсдэлийн мэдээллийг ашиглан газар, ус, мал аж ахуйн менежментийг үндэсний болон орон нутгийн түвшинд төлөвлөх заавар, аргачлал, гарын авлага боловсруулах зөвлөх үйлчилгээ”-г гүйцэтгэж байгаа эрсдэлийн төлөвлөлтийн багийн гаргасан зудын эрсдэлийн индексээс харахад 2020 оны байдлаар Баяндэлгэр сумын зудын эрсдэлийн индекс 3.4 байгаа бол 2030 он гэхэд 3.9 болж 0.5 өсөх буюу зудын давтагдал болох эрсдэлтэй ажиглагдаж байна.

Дээрхээс үзэхэд зудын эрсдэл болоод уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, эрсдэлийг бууруулахын тулд Баяндэлгэр сумын хэмжээнд тариалангийн газрыг сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгасан. Мөн тус сумын хувьд зудын эрсдэлээс сэргийлэхийн тулд тэжээлийн нөөцийг бэлтгэх, худалдаж

авах, эрсдэл учрах магадлалтай цаг үеүдэд нөөцлөх, тэжээлийн нөөцийн чанарыг алдагдуулахгүй байхаар хадгалах горим, агуулах бэлдэх мөн малын үүлдэр, таваарлаг байдлыг сайжруулахад анхаарах, малчид хоорондоо хорших зэрэг арга хэмжээ авах нь эрсдэлээс сэргийлэх, бууруулах үйл ажиллагаа юм.

Зураг№19. Баяндэлгэр сумын зудын эрсдэл /2000-2022 он/




ХОЁРДУГААР БҮЛЭГ. БАЯНДЭЛГЭР СУМЫН БАЙГАЛЬ НУТАГ ДЭВСГЭРИЙН НӨХЦӨЛ, НӨӨЦИЙН СУДАЛГАА

2.1. БАЙГАЛЬ-НУТАГ ДЭВСГЭРИЙН ЦОГЦОЛБОР НӨХЦӨЛ, НӨӨЦИЙН МУЖ, ТОЙРОГ

Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сум нь байгаль нутаг дэвсгэрийн цогцолбор нөхцөлийн муж тойргийн хувьд Дундад Халхын болон Дорнод Монголын талархаг хээрийн мужийн Хэрлэн голын өмнөд Баруун уртын нам уулсын тойрог (Т-3), мөн Дорнод говийн цөлөрхөг мужийн Дорнод говийн хойд хэсгийн тойрог (Г-9), гэсэн тойргуудад харьяалагдана.

Зураг№20. Баяндэлгэр сумын байгаль нутаг дэвсгэрийн цогцолбор нөхцөлийн тойргийн зураг



Хүснэгт №11. Баяндэлгэр сумын байгаль нутаг дэвсгэрийн муж, тойрог

Газар нутгийн хэмжээ /га/	Мужийн нэр	Тойргийн дугаар	Талбайн хэмжээ /га/	Сумын нутаг дэвсгэрт эзлэх хувь
763315.01	Дундад Халхын болон Дорнод Монголын талархаг хээрийн муж	Т-3	348853.87	45.70
	Дорнод говийн цөлөрхөг муж	Г-9	414461.14	54.30

/Эх үүсвэр: Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, 2018 он/

2.1.1. Хамрагдах мужуудын онцлог

Тал хээрийн бүсийн Дундад Халхын болон Дорнод Монголын талархаг хээрийн муж:

Дундад Халхын болон дорнод Монголын талархаг хээрийн муж нь Дундад Халхын тэгш өндөрлөгийн тойрог (Т-1), Хэрлэн голын хойд Хөх нуур орчмын тойрог (Т-2), Хэрлэн голын өмнөд Баруун уртын нам уулсын тойрог (Т-3), Мэнэнгийн тэгш талын тойрог (Т-4) гэсэн 4 тойрогт хуваагдана.

Дорнод Монголын тэгш талын хил хязгаар геоморфологийн хувьд нарийн сайн тодорхойлогдож, нэг мөр болоогүй байна. Хэсэг судлаачид Дорнод Монголын талд Хэрлэн-Улзын районыг оруулдаг /Герасимов, Лавренко, Чичагов/ бол зарим судлаачид энэ мужийн хойд хилийг дээрх районоос урдуур авдаг. /Мурзаев, Селиванов/ Н.А.Маринов, Р.А.Хасин нарынхаар бол энэ талархаг муж нь баруун хойд талдаа Хэнтийн салбар уулс, зүүн өмнөд хэсэгтээ Их Хянганы уулсын хооронд оршино. Хэрлэн-Улзын район бол Хэнтийн салбар уулсын нэг хэсэг бөгөөд тэрээр цав толгод, нам уулс, тусгаар салангид нам уулсын тарамцгуудын нэгдэл бөгөөд дунд төрмөл-шинэ төрмөлийн эриний настай, өргөн биш, хавтгай хотгорууд болон эвдрэлийн тэгш талуудаар тусгаарлагдсан байна. Хэрлэн болон Улз голуудын хоорондын нам уулсын өндрийн хэмжээснүүд нэлээд их байна. Тухайлбал: Дэлгэрхан уул 1411 м, Хай Дэлгэр хан - 1594 м, Бүрэнхан овоо уул 1348 м, Улаан уул - 1132 м болно.

Говийн бүсийн Дорнод говийн цөлөрхөг муж:

Дорнод говийн цөлөрхөг муж нь Дорнод говийн хойд хэсгийн тойрог (Г-9), Дорнод говийн өмнөд хэсгийн тойрог (Г-10) гэсэн 2 тойрогт хуваагдана. Гадаргын хувьд ухаа гүвээт тал, цав толгод, хотгор нам газар гол суурийг эзлэх бөгөөд говийн зүүн хэсэгт байгаа уулс харьцангуй намхан, өндөр нь 1300-1800 метрээс үл хэтэрнэ.

2.1.2. Хамрагдах мужуудын уур амьсгалын нөхцөл

Дундад Халхын болон Дорнод Монголын талархаг хээрийн муж: Энэ мужид Монгол орны хээрийн бүсийн ихэнх нутаг багтана. Уг муж нь дотроо байгаль-газарзүйн хэв шинжийн хувьд 4 тойрогт багтдаг боловч уур амьсгалын нөхцөлийн хувьд жигдэвтэр байдаг. Зөвхөн хойноосоо өмнө зүг рүү шилжих тутам дулаан, хуурай болох зэрэг ялгаа илэрдэг. Энд жилийн дундаж агаарын температур -2°-оос +2°-ын хооронд хэлбэлзэнэ. Өөрөөр хэлбэл тал хээрийн бүсийн дунд орчмоор 0°-ын шугам дайрдаг. Энэ нь тогтвортой цасан бүрхүүлийн урд хилийн шугам, олон

жилийн цэвдгийн (алаг цоог) өмнөх хил зэрэгтэй үндсэндээ давхацдаг байна. бдугаар сарын дундаж агаарын температур 20-25°C. Хоногийн дундаж агаарын температур 10°C-ын заагийг хавар 5 дугаар сарын эхээр, намар 9 дүгээр сарын сүүлчээр дайрч, уг заагаас дээших хоногийн тоо 122-137 байна. Энэ хугацааны идэвхтэй температурын нийлбэр дунджаар 2250-2750°C байдаг.

Хаврын эцсийн цочир хүйтрэлт 5 дугаар сарын 20-доор дуусаж намрын эхний 9 дүгээр сарын дундуур эхэлдэг тул хүйтрэлтгүй байх хугацаа 110-140 хоногт хүрнэ. Таримал ургамлын ургалтын хугацаанд цочир хүйтрэлтийн нөлөө бага. Энэ мужид ихэнх таримал ургамлын дулааны хангамж хүрэлцээтэй. Гэвч жилд дөнгөж 150-250 мм хур тунадас орно. 5, 6 дугаар сар болон 7 дугаар сарын эхэн хагаст хур бороо хомс учир чийг хангамжийн бодит хэмжээ нь ургамлын ургах шаардлагын дөнгөж 60-70%- ийг эзэлдэг. Жилийн дундаж салхины хурд 3-4 м/с хаврын улиралд хүчтэй салхи, цасан болон шороон шуурга болж мал аж ахуйд үлэмж хохирол учруулсан тохиолдол цөөнгүй байна.

Дорнод говийн цөлөрхөг муж: энэ мужид жилийн дундаж агаарын температур 2- 4°C орчим байна. Мужийн хойд хэсгээр арай сэрүүн, 2°C байдаг бол өмнө талдаа 4°C ба түүнээс их байна. 7 дугаар сарын дундаж агаарын температур 21.4-22°C, зуны хамгийн их температур 30°C-аас дээш байх өдрийн тоо 24-26 байна. Хавар дунджаар 5 дугаар сарын 10-даар цочир хүйтрэлт дуусаж, намар 9 дүгээр сарын 25-ны үеэр анхны цочир хүйтрэлт болж эхэлнэ. Ийнхүү хүйтрэлтгүй үеийн үргэлжлэх хугацаа 130 гаруй хоног байна. +10°C-аас дээших идэвхтэй температурын нийлбэр дунджаар 2500°C байдаг. 1 дүгээр сарын дундаж агаарын температур -16...-18°C орчим байна. Жилийн нийлбэр тунадасны хэмжээ 100-120 мм, үүнээс дулааны улиралд ихэнх нь унана. Дулааны улиралд арав хоног тутам харьцангуй чийгшил 30% ба түүнээс доош байх өдрийн тоо 4-7 өдөр буюу дулааны улирлын нийт хоногийн 50%-д нь хуурай байдаг учир ууршил их явагдах нөхцөлтэй. Дорнод говийн өмнөд тойрог нь нэг өргөрөгт орших цөлийн бусад тойргоос хур тунадас арай ахиу ордог тул бэлчээрийн ургамлын ургац бага зэрэг илүү байдаг. Энэ мужид ургамлын ургах дулааны хангамж сайтай боловч хур чийг дутмаг тул тариалан эрхлэхэд нэн хүндрэлтэй. Зайлшгүй усалгаа хийх шаардлагатай. Энэ зорилгоор булаг, шанд, борооны усыг усалгаанд зориулан ашиглах нь зүйтэй юм.

2.1.3. Хамрагдах мужуудын ургамлан нөмрөг

Дундад Халхын болон Дорнод Монголын талархаг хээрийн муж: Газрын гадаргын байдал нэг жигд учраас ургамалжилт мөн тийм байдаг. Тухайлбал: Сибирь хялгана, Крыловийн хялгана, Нангиад түнгэ, дэрвээн хазааргана, саман дурваа, сунагар биелэг, Баллисийн ботууль, саман ерхөг гэх мэт үетэн бүхий хялгана-дурваат, шивээт хялгана-шавагт, шивээт хялгана-хазаарганат, түнгэ-шивээт хялганат хуурай хээр зонхилно. Чойбалсан, Тамсаг булагийн хооронд орших элсэрхэг хүрэн хөрстэй газраар түнгэ, жижиг навчит харгана оролцсон шивээт хялгана-дурваат, хялгана-жижиг дэгнүүлт үетэн-дурваат хээртэй. Мужийн дорнод ба умард хэсгийн хар хүрэн хөрстэй газраар зүр өвс-алаг өвст, зүр өвс-хялганат,

алаг өвс-түнгэ-хялганат хээр зонхилно. Хотгор хонхрын дагууд дэрстэй цайдам бий. Харин өмнөд хэсэгт хөмөл бүхий таана-хялганатай болон улаан бударганатай цөлөрхөг хээртэй. Бэсрэг уулсын ам хавцлаар хайлаас, бургас цөөнөөрөө, гүйлс харгана элбэг тохиолдоно. Энэ мужид умард зүгээс дагуурын, өмнө зүгээс Монголын ургамлын аймгийн төлөөлөгчид харилцан нийлж байгаа шилжилтийн бүс юм. Нөгөө талаар дорноос Манжуурын элементүүд багагүй нөлөөтэй байна.

Дорнод Монголын мужид одоогоор 539 зүйл гуурст ургамал бүртгэгдсэний дотор 60 зүйл модлог, сөөглөг (11.13%), 479 зүйл өвслөг ургамал (88.87%) байна. Энэ мужийн ургамлыг экологийн бүлгүүдэд хувааж үзвэл:

- хуурайсаг 101 зүйл (18.74%),
- чийгсүү-хуурайсаг 100 зүйл (18.55%),
- хуурайсуу-чулуусаг 73 зүйл (13.54%),
- чийгсэг 86 зүйл (15.95%),
- чийгсүү намагсаг 16 зүйл (2.97%),
- намагсаг 24 зүйл (4.45%),
- хуурайсуу-намагсаг 4 зүйл (0.74%),
- уссаг 19 зүйл (3.53%),
- чийгсүү чулуусаг 17 зүйл (3.15%),
- чийгсүү-давссаг болон бусад хэлбэрийн давссаг 64 зүйл (11.87%)
- элссэг 23 зүйл (4.27%) байна.

Хүйтсэг ургамал тун цөөн (бүгд 12 зүйл). Экологийн задлагаас хуурай хээрийн ургамал зонхилохын зэрэгцээ хонхор хотгор газар, гол, нуурын эргийн чийглэг, давссаг ургамал цөөнгүй байгааг харж болно. Дундад халхын тэгш өндөрлөгийн тойргийн бүх нутаг нунтаг карбонатлаг сайргархаг хүрэн хөрстэй чулуусаг алаг өвс-хялганат, хар хүрэн хөрстэй харгана-хялганат, хазаар өвс-хялганат тэгш өндөрлөг, тал газрын хуурай хээрийн бэлчээртэй. 8-9 ц/га тэжээлийн нөөцтэй, 400-500 кг/га тэжээлийн нэгжтэй. Жилийн турш үхэр, адуу болон бүр төрлийн малд тохиромжтой.

Тэгш өндөрлөгийн хотос, хонхор газруудаар зурман сүүлт буюу цахилдаг нуга, хэсэг хэсгээр тохиолдох нугын давсархаг хөрстэй дэрст марзлаг нугын бэлчээр. 3-4 ц/га тэжээлийн нөөцтэй, 170-200 кг/га тэжээлийн нэгжтэй, намар-өвөлдөө бог мал, тэмээнд тохиромжтой. Хэрлэн голын хойд хэсгийн тойрогт багтах Хэрлэн голын хойд Талын гол орчим нутгаар нугат-хүрэн, нунтаг карбонатлаг хүрэн хөрстэй харгана бүхий бутлаг үетэн-хялганат, хиаг-бутлаг үетэн-хялганат, хялгана-бутлаг үетэн- дааган сүүлт хуурай хээрийн бэлчээр. 8-10 ц/га тэжээлийн нөөц, 500-600 кг/га тэжээлийн нэгжтэй. Жилийн турш бүх төрлийн малд тохиромжтой.

Улз голын урд хэсэг, Хөх нуур орчмоор нунтаг карбонатлаг сайргархаг хар хүрэн хөрстэй алаг өвс-хялганат, зүр өвс-хялганат, алаг өвс-хиаг-хялганат бэлчээртэй. Мөн уулын хар шороон хөрстэй чаргай бүхий алаг өвс-улалжит, шилийн бутнуур ба алаг өвс-зүр өвст нугат хээрийн бэлчээртэй, 15-16 ц/га тэжээлийн нөөцтэй, 1000-1100 кг/га тэжээлийн нэгжтэй. Зун-намарт үхэр адуунд тохиромжтой. Голын сав, хотос хонхор газраар зурман сүүлт буюу цахилдагт нуга хэсэг хэсгээр

тохиолдох нугын давсархаг хөрстэй дэрст марзлаг нугын бэлчээртэй. 10-15 ц/га тэжээлийн нөөцтэй, 750-800 кг/га тэжээлийн нэгжтэй. Зун-намар бог мал, тэмээнд тохиромжтой.

Тойргийн баруун сэжүүр-Бэрх орчмоор нунтаг карбонатлаг сайрхаг хүрэн хөрстэй чулуулаг алаг авс-хялганат, хазаар өвс-хялганат цав толгодын хуурай хээрийн бэлчээртэй. 11-13 ц/га тэжээлийн нөөцтэй, 500-700 кг/га тэжээлийн нэгжтэй. Өвөл-хавар бог мал, адуунд тохиромжтой. Хэрлэн голын өмнөд хэсгийн тойрог нэлэнхийдээ тэгш 1000-1500 м өндөр. Нунтаг карбонатлаг сайргархаг хүрэн хөрстэй чулуусаг алаг өвс- хялганат, нугат-хүрэн, харгана бүхий бутлаг үетэн-хялганат, хиаг-бутлаг үетэн- хялганат, хялгана-бутлаг үетэн-дааган сүүлт хуурай хээрийн бэлчээртэй. Өвөл-хавар бог мал, адуунд тохиромжтой. 8-9 ц/га тэжээлийн нөөцтэй, 500- 550 кг/га тэжээлийн нэгжтэй. Нунтаг карбонатлаг хар хүрэн, хүрэн хөрстэй. Харгана-хялганат, хазаар өвс-хялганат бэлчээртэй. 8-8.5 ц/га тэжээлийн нөөцтэй, 400-450 кг/га тэжээлийн нэгжтэй. Хэрлэн голын татмын дагуу болон хотос хонхор газраар зурман сүүлт буюу цахилдагт нуга хэсэг хэсгээр тохиолдох нугын давсархаг хөрстэй голын татам, нуурын хөвөөний марзлаг нугын бэлчээртэй. 12-15 ц/га тэжээлийн нөөцтэй, 800-1100 кг/га нэгжтэй.

Мэнэнгийн тэгш талын тойрогт Буйр нуураас гадна бусад жижиг нуур цөөрөм олон бий. Тэдгээрийн эрэг хөвөө, хотгор хэсгээр нам дор газрын давслаг цахилдаг-үетэн бүхий дэрс, түнх, өлөн оролцсон бэлчээртэй, үхэр, тэмээ, адуунд тохиромжтой, 8.0 ц/га тэжээлийн нөөцтэй, 500-600 кг/га тэжээлийн нэгжтэй. Буйр нуураас баруун, зүүн тийш хиаг-бутлаг үетэн-алаг өвст (80%), нуга, дааган сүүл-түнх-өлөн оролцсон тэгш талын хээр, хуурай хээрийн хэв шинжийн бэлчээртэй үхэр, адуу, тэмээ зэрэг малд тохиромжтой.

Тойргийн өмнөд хэсгээр хялгана-жижиг дэгнүүлт үетэн-түнхтэй харгана оролцсон хуурай хээрийн бэлчээртэй жилийн турш ашиглагдана. Бүх төрлийн малд тохиромжтой, 13.0 ц/га тэжээлийн нөөцтэй, 500-600 кг/га тэжээлийн нэгжтэй.

Дорнод говийн цөлөрхөг муж: Дорноговийн муж ургамалжилтын хувьд тачирхан, сийрэг ургамалтай, өдлөг хялгана-таанат, өдлөг хялгана-боролзойт хээр зонхилно. Шавранцар-хайргархаг, бэлээр баглуурт, бор бударганаас гадна хайргархаг-элсэнцэр хөрстэй газраар нь, ялангуяа өмнөд хэсгийн нутгаар хойргот, тостот, модлог бударганат, тэсэгт цөл зонхилно. Элсэрхэг хөрстэй газраараа сийрэгхэн загийн шугуйтай, эсвэл харгана-шавагт эвшил тааралдана. Шаварлаг марцлаг хотгоруудад гоолиг шар бударгана, Зүүнгарын улаан бударгана, эсвэл луулийн овгийн нэг наст ургамлууд оролцсон эвшлүүд тохиолдоно. Энэ мужийн нутгуудаас Баянзагийн хотгор бол Монголын цөлөрхөг хээр дэх өвөрмөц газрын нэг бөгөөд тэнд говийн бараг бүх элементүүд хуран цуглажээ. Дорноговийн тойрогт Монгол улсын нутаг дэвсгэрийн 9.35%-ийг эзэлнэ. Энд одоогоор 327 зүйл гуурст ургамал бүртгэгдсэний дотор 68 зүйл (мужийн ургамлын 20.8%) модлог, сөөглөг ургамал, 259 зүйл өвслөг (79.2%) ургамал байна. Энэ задлагаас үзэхэд мод, том сөөг тун цөөн: харин ердийн сөөг, сөөгөнцөр,

заримдаг сөөг, сөөгөнцөр бусад өвслөг ургамлынхаа зүйлийн тоогоор Алтайн өвөр говийн мужтай тун ойролцоо юм.

Ургамлын экологийн үндсэн бүлгүүдийг авч үзвэл:

Хуурайсаг ургамал 70 зүйл (21.41 %);

Давссаг 4 бүлгийн 64 зүйл ургамал (19.57%);

Элссэг 20 зүйл ургамал (10.93%);

Хуурайсуу-чийгсэг 35 зүйл ургамал (10.7%);

Чийгсэг 24 зүйл ургамал (7.34%);

Хуурайсуу-намагсаг 6 зүйл ургамал (1.84%).

Харин ус, намгийн ба хүйтсэг ургамал байдаггүй. Их хуурай халуун болон давсархаг марцлаг газарт зохилдсон ургамлууд ургамлын нөмрөгт голлох үүрэг гүйцэтгэнэ. Дорнод говийн хойд хэсгийн тойргийн бүх нутаг нь нэлэнхийдээ цөлөрхөг хээр, цөлийн хээрийн нунтаг карбонатлаг цайвар хүрэн хөрстэй хялгана-жижиг хялганат, хазаар өвс-жижиг хялганат, чулуурхаг бор хөрстэй бударгана-жижиг хялганат, жижиг хялгана-бударганат, баглуур-жижиг хялганат цав толгод ба тал газрын хуурай хээрийн бэлчээртэй. 4-5 ц/га тэжээлийн нөөцтэй, 250-300 кг/га нэгжтэй. Зун-намар бог мал, тэмээнд тохиромжтой.

Хотос хонхор газраар мараалаг бор, бор саарал хөрстэй бор бударганат, цөлөрхөг хээрийн давсархаг бор хөрстэй, олон наст бударганат, бор саарал ба цөлөрхөг хээрийн давсархаг бор хөрстэй заг-давслаг сөөгт мараалаг, марзлаг бэлчээр зонхилно. Зун-намарт тэмээнд тохиромжтой. 2.0-2.5 ц/га тэжээлийн нөөцтэй, 120-150 кг/га тэжээлийн нэгжтэй. Дорнод говийн өмнөд хэсгийн тойргийн ихэнх хэсэг болох Заг Сүүжийн говь, Борзонгийн говь, Галбын говь, Өөшийн говь, Борхойн тал нь мараалаг бор, бор саарал хөрстэй бор бударганат, бор саарал ба цөлөрхөг хээрийн давсархаг бор хөрстэй заг-давслаг сөөгт бэлчээртэй зун-намар тэмээнд тохиромжтой. 1.5-2 ц/га тэжээлийн нөөцтэй, 90-120 кг/га тэжээлийн нэгжтэй. Цөлийн бор саарал хөрстэй чулуусаг бударганат тал, хотгор газрын цөлийн бэлчээртэй. 1.0-1.5 ц/га тэжээлийн нөөцтэй: 50-80 кг/га нэгжтэй. Тойргийн зүүн хэсэг 1000 м орчим өндөр уулсаар нунтаг карбонатлаг цайвар хүрэн хөрстэй, хазаар өвс-жижиг хялганат цөлөрхөг хээрийн чулуурхаг бор хөрстэй бударгана-жижиг хялганат, жижиг хялгана-бударганат цөлөрхөг хээрийн, цөлийн бэлчээртэй. 3.0-3.5 ц/га нөөцтэй, 150-200 кг/га тэжээлийн нэгжтэй.

Элсэрхэг газраар хуурай хээрийн ба цөлөрхөг хээрийн харганат, үетэн-харганат, шарилжит элсний бэлчээртэй. 1.0-1.5 ц/га тэжээлийн нөөц бүхий 50- 60 кг/га нэгжтэй.

2.1.4. Хамрагдах мужуудын хөрсөн бүрхэвч

Дундад Халхын болон Дорнод Монголын талархаг хээрийн муж: Энэ мужид ердийн болон сайр чулуурхаг хүрэн, хар хүрэн, хүрэн, цайвар хүрэн хөрс голчлон тархах бөгөөд 80 орчим хувийг эзэлж байна. Үүнээс 30 орчим хувь нь нам ухаа толгодын цайвар хүрэн хөрс байна. Бүс дундын нуга намгийн хөрс 6 орчим хувийг эзэлж байна. Тус мужид газар тариаланд тохиромжтой хүрэн хөрсний иж бүрдэл Мэнэнгийн тэгш талын Т-4 тойрогт буюу Халхголын сав газарт тархах ба үржил

шимт буюу ялзмагт үе давхаргын зузаан их, шим тэжээлийн бодисоор баялаг байдаг онцлогтой юм.

Хүснэгт №12. Дундад халхын болон дорнод Монголын талархаг хээрийн мужийн хөрсний нөөц

д/д	Хөрсний нэр	Т-3	
		%	га
1	Нуур	4877.0	0.0
2	Уулын карбонаттай хар шороон/уулын карбонатгүй хар хүрэн		0.0
3	Уулын хар шороон/уулын хар хүрэн		0.0
4	Уулын карбонатгүй хар хүрэн/уулын карбонатгүй хар шороон		0.0
5	Уулын хар хүрэн/уулын нимгэн хар шороон	337230.9	3.4
6	Уулын хүрэн/уулын хар хүрэн		0.0
7	Толгодын карбонатгүй хар шороон/нимгэн сайр чулуурхаг хар хүрэн		0.0
8	Толгодын карбонатгүй хар хүрэн/нимгэн сайр чулуурхаг хар хүрэн	302754.4	3.1
9	Толгодын хар хүрэн/нимгэн сайр чулуурхаг хар хүрэн	3939374.2	40.0
10	Толгодын хүрэн/нимгэн сайр чулуурхаг хүрэн	1297373.5	13.2
11	Сайр чулуурхаг цайвар хүрэн	382296.5	3.9
12	Карбонатгүй хар хүрэн/нугат хүрэн		0.0
13	ердийн хар хүрэн/сайр чулуурхаг хар хүрэн	396608.8	4.0
14	Ердийн хар хүрэн/мараалаг хар хүрэн	6166.8	0.1
15	Ердийн хар хүрэн/далд глейрхэг хар хүрэн	253294.0	2.6
16	Үлдмэл нугат хар хүрэн/нугын мараалаг хар хүрэн	40915.9	0.4
17	Давсархаг хар хүрэн/хужир мараалаг хар хүрэн	34620.2	0.4
18	Ердийн хүрэн/сайр чулуурхаг хүрэн	470367.3	4.8
19	Ердийн хүрэн/сайр чулуурхаг болон хужир мараалаг хүрэн	1295913.2	13.1
20	Ердийн болон нугат хүрэн/үлдмэл нугат хүрэн	65518.4	0.7
21	Мараалаг хүрэн/карбонаттай хүрэн ба нугын хужир	124510.3	1.3
22	Ердийн цайвар хүрэн/сайр чулуурхаг цайвар хүрэн	101669.8	1.0
23	Ердийн цайвар хүрэн/нугат цайвар хүрэн	99239.6	1.0
24	Ердийн цайвар хүрэн/хужир марааны бүрдэл	86654.1	0.9
25	Мараалаг цайвар хүрэн/сайр чулуурхаг цайвар хүрэн	4690.2	0.0
26	Сийрэг элсэн хүрэн	88270.5	0.9
27	Мараалаг нугат хүрэн/үлдмэл нугат хүрэн/хужир марааны бүрдэл	19861.9	0.2
28	Нугат намгийн цэвдэгт хужирлаг/нугын цэвдэгт хужирлаг		0.0
29	Нугын цэвдэгт/нугат хар шороон		0.0
30	Нугын хужир/хужирлаг нуга	145707.4	1.5
31	Аллювийн нугат намгийн/Аллювийн нугын хужирлаг	1316.4	0.0
32	Аллювийн нугын/Аллювийн нугын давсархаг	171279.4	1.7
33	Аллювийн нугын хужирлаг ба Аллювийн үелсэн тогтоцтой		0.0
34	Хужир марааны бүрдэл	140868.0	1.4
35	Нугын иж бүрдэл	2719.2	0.0
36	Хужир болон хужирлаг нугат бор		0.0
37	Хужир болон хагас бэхэжсэн элс	13413.9	0.1
38	Хагас бэхэжсэн элс	32914.0	0.3
39	Хад асга		0.0
	Дүн	9860425.7	100.0

Дорнод говийн цөлөрхөг муж: Энэ мужийн хөрсөн бүрхэвчийн 70 орчим %-д цөлийн болон хээржүү цөлийн, толгодын бор саарал хөрс тархах ба ердийн болон толгодын сайр чулуурхаг цайвар хүрэн хөрс 20 орчим хувьд нь тархаж байна. Нам хотосуудаар жинхэнэ хужир, шал хөрс тархана. Шал, элсэн хөрс 4 орчим хувийг эзэлж байна. Цөлийн бор саарал хөрсний ургамлан нөмрөг маш сийрэг үүнээс шалтгаалан энэ хөрсний үржил шим, агро үйлдвэрлэлийн чадавх үлэмж муу, усны элэгдлийн нөлөөгөөр гадарга нь ихээхэн атираажиж, өнгөндөө гандсан хучаас тогтсон байдаг.

Хүснэгт №13. Дорнод говийн цөлөрхөг мужийн хөрсний нөөц

Д/д	Хөрсний нэр	Г-9	
		га	%
1	Нуур	11651.69	0.08
2	Уулын хар хүрэн/уулын нимгэн хар шороон	20.06	0.00
3	Уулын хүрэн/уулын хар хүрэн	1217.77	0.01
4	Уулын карбонаттай цайвар хүрэн/ уулын нимгэн цайвар хүрэн	34111.39	0.24
5	Уулын цөлөрхөг хээрийн нимгэн бор/сайрын		0.00
6	Уулын хээржүү цөлийн нимгэн бор/сайрын		0.00
7	Уулын хээржүү цөлийн нимгэн бор саарал/сайрын		0.00
8	Толгодын хүрэн/нимгэн сайр чулуурхаг хүрэн	818093.73	5.86
9	Сайр чулуурхаг цайвар хүрэн	2025831.77	14.52
10	Толгодын цөлөрхөг хээрийн бор	795135.19	5.70
11	Толгодын хээржүү цөлийн бор/хээржүү цөлийн нимгэн сайр чулуурхаг бор	457927.01	3.28
12	Толгодын бор саарал/нимгэн бор саарал		0.00
13	Ердийн хүрэн/сайр чулуурхаг хүрэн	83440.26	0.60
14	Ердийн хүрэн/сайр чулуурхаг болон хужир мараалаг хүрэн	33181.60	0.24
15	Мараалаг хүрэн/карбонаттай хүрэн ба нугын хужир	18534.31	0.13
16	Ердийн цайвар хүрэн/сайр чулуурхаг цайвар хүрэн	1183864.42	8.48
17	Ердийн цайвар хүрэн/нугат цайвар хүрэн	439222.04	3.15
18	Ердийн цайвар хүрэн/хужир марааны бүрдэл	64650.26	0.46
19	Мараалаг цайвар хүрэн/сайр чулуурхаг цайвар хүрэн	596107.30	4.27
20	Сийрэг элсэн хүрэн	123383.00	0.88
21	Мараалаг нугат хүрэн/үлдмэл нугат хүрэн/хужир марааны бүрдэл	107105.19	0.77
22	Цөлөрхөг хээрийн бор	2400144.02	17.20
23	Цөлөрхөг хээрийн бор/сайрын болон элсэн хучаастай бор	1316016.75	9.43
24	Цөлөрхөг хээрийн бор/хужир марааны бүрдэл	175748.54	1.26
25	Цөлөрхөг хээрийн сайр чулуурхаг бор	367677.45	2.63
26	Цөлөрхөг хээрийн мараалаг бор/хужирлаг нугат бор	517846.38	3.71
27	Хээржүү цөлийн бор/хээржүү цөлийн сайр чулуурхаг бор	483175.47	3.46
28	Хээржүү цөлийн бор/элсэн хучаастай бор болон хээржүү цөлийн мараалаг бор	540712.43	3.87
29	Хээржүү цөлийн мараалаг бор/шалархуу болон хагас бэхэжсэн элс	148511.49	1.06
30	Хээржүү цөлийн гөлтгөнөт бор	4415.77	0.03
31	Хээржүү цөлийн хужирлаг бор/хээржүү цөлийн сайр чулуурхаг бор		0.00
32	Элсэн хучаастай бор/элсэн хучаастай сийрэг бор	537771.64	3.85
33	Цөлийн бор саарал/мараалаг цөлийн бор саарал		0.00
34	Цөлийн мараалаг бор саарал/сайр чулуурхаг бор саарал		0.00
35	Цөлийн гөлтгөнөт бор саарал/мараалаг бор саарал		0.00
36	Цөлийн гөлтгөнөт мараалаг бор саарал ба хужирлаг бор саарал		0.00
37	Цөлийн элсэн хучаастай бор саарал ба цөлийн гөлтгөнөт бор саарал		0.00
38	Хэт хуурай цөлийн борзон/шалархуу		0.00
39	Сайрын болон цөлийн бор саарал	17695.87	0.13
40	Нугын хужир/хужирлаг нуга	22968.68	0.16
41	Аллювийн нугын хужирлаг ба Аллювийн үелсэн тогтоцтой	46212.47	0.33
42	Хужир марааны бүрдэл	210416.30	1.51
43	Нугын иж бүрдэл	80561.66	0.58
44	Хужир болон хужирлаг нугат бор	1491.26	0.01
45	Хужир болон хагас бэхэжсэн элс	132858.25	0.95
46	Шал шалархуу	8614.97	0.06
47	Шалархуу хагас бэхэжсэн элс		0.00
48	Хагас бэхэжсэн элс	149574.71	1.07
49	Хөдөлгөөнт элс		0.00
50	Хад асга		0.00
	Дүн	13955891.09	100

/Эх үүсвэр: УГЗБЕТ, 2018 он/

2.1.5. Хамрагдах мужуудын ан амьтан

Дундад Халхын болон Дорнод Монголын талархаг хээрийн муж: Энэ мужид нийтдээ 6 ангийн 343 зүйл буюу манай орны сээр нуруутан амьтдын зүйлийн бүрэлдэхүүний 52.7% нь оршин амьдардаг байна.

Хүснэгт №14. Дундад халхын болон дорнод Монголын талархаг хээрийн мужийн сээр нуруутан амьтдын зүйлийн бүрэлдэхүүн*

Нэгж	Дэлэнтэн	Шувуу	Мөлхөгчид	Хоёр нутагтан	Загас	Дугариг амьтан	Бүгд
Баг	5	17	1	1	7	1	32
Овог	17	44	4	3	11	1	80
Зүйл	63 (45.3%)	219 (52.7%)	8 (38.1%)	3 (50.0%)	49 (71.0%)	1 (100%)	343 (52.7%)

/*Тайлбар: Монгол оронд бүртгэгдсэн тухайн ангийн амьтдын зүйлийн бүрэлдэхүүний хэдэн хувийг эзэлж буйг хаалтад бичив./

Дорнод говийн цөлөрхөг муж: Энэ мужид нийтдээ 4 ангийн 131 зүйл буюу манай орны сээр нуруутан амьтдын зүйлийн бүрэлдэхүүний 20.1 % нь оршин амьдардаг байна.

Хүснэгт №15. Дорнод говийн цөлөрхөг мужийн сээр нуруутан амьтдын зүйлийн бүрэлдэхүүн*

Нэгж	Дэлэнтэн	Шувуу	Мөлхөгчид	Хоёр нутагтан	Загас	Дугариг амьтан	Бүгд
Баг	5	10	1	1	-	-	17
Овог	11	22	5	1	-	-	39
Зүйл	44 (31.6%)	76 (18.3%)	10 (47.6%)	1 (16.6%)	-	-	131 (20.1%)

/*Тайлбар: Монгол оронд бүртгэгдсэн тухайн ангийн амьтдын зүйлийн бүрэлдэхүүний хэдэн хувийг эзэлж буйг хаалтад бичив./
/Эх үүсвэр: УГЗБЕТ, 2018 он/

2.2. ИНЖЕНЕР ГЕОЛОГИЙН НӨХЦӨЛ

Инженер геологийн нөхцөлийг тодорхойлохдоо “Монгол орны одоо байгаа төрөл бүрийн масштабтай зураг /геологи, геоморфологи, гадаргын хэрчигдэл, шинэ тектоник, газар чичирхийлэл, ашигт малтмал, инженер-геологийн нөхцөл, мужлал, онцгой шинж чанар бүхий ул хөрс, газар хөдлөл, цэвдэг, гидрогеологи, гидрологи, түүх археологи/-ын тоон өгөгдлийн санг нэгдсэн арга зүй программ хангамж, стандартын дагуу нэгтгэж орон зайн мэдээллийн дэд бүтцийн гео-системийн давхарга байгуулах” төслийн хүрээнд Сүхбаатар аймгийн нутаг дэвсгэрийн инженер-геологийн өргөтгөсөн судалгааг 2014 онд “Инжгеотех” ХХК-ийн мэргэжлийн баг хийж гүйцэтгэсэн тайлангийн мэдээллийг ашиглав. (“Инжгеотех”, 2014 он)

Баяндэлгэр сумын инженер геологийн нөхцөл:

Геологийн тогтцыг палеозой настай боржин чулуу болон дээд дөрөвдөгчийн настай, пролювийн гаралтай үүсэлтэй сэвсгэр хучаас хурдас тодорхойлно. Голлох хөрс нь хайргархаг шавранцар, элсэнцэр чигжээстэй хайр, хайрган хөрс, хайр, хайрган хөрс байна. Палеозойн настай боржин чулуу болон дөрөвдөгчийн настай сэвсгэр хөрсүүдийг инженер-геологийн 4 элемент болгон авч үзлээ. Дээд дөрөвдөгч-орчин үеийн настай, пролювийн гаралтай хурдасны геологи-гарал үүслийн комплекс /pQ2 /

ИГЭ-1. Хайргархаг шавранцар хөрс Бор өнгөтэй, хатуу консистенцтэй, хайргархаг шавранцар хөрс нь 1.5 м хүртэл зузаантай сумын төвийн төв хэсэгт багаар тархсан, баруун болон төвийн хэсгээр түр зуурын ус урсдаг сайр дагуу тархсан байдаг.

ИГЭ-2. Элсэнцэр чигжээстэй хайр, хайрган хөрс Бор өнгөтэй, хатуу консистенцтэй, элсэнцэр чигжээстэй хайр, хайрган хөрс нь 0.8 м хүртэл зузаантайгаар сумын төвийн хойд хэсгээр үндсэн чулуулгийн хучин тархсан байна.

ИГЭ-3. Элсэн чигжээстэй хайр, хайрган хөрс Хөх саарал, шаргал өнгөтэй бага чийгтэй хайр, хайрган хөрс нь 2.4м хүртэл зузаантайгаар сумын төвийн хэмжээнд төв болон урд хэсгээр давамгайлан тархсан байна. Палеозойн настай гүний гаралтай чулуулгийн геологи-гарал үүслийн комплекс /D3 -S1 /

ИГЭ-4. Боржин чулуу Боржин чулуу нь сумын төвийн хойд хэсгээр зонхилон тархсан байдалтай дөрөвдөгчийн пролювийн гарал үүсэлтэй хайргархаг элсэн хөрсөөр хучигдан тогтсон байна.

Хүснэгт №16. Ширхгийн бүрэлдэхүүн болон чийгийн төлөв байдлын үзүүлэлт

Элементийн дугаар	Хөрсний нэр	Гарал, үүсэл	Ширхгийн бүрэлдэхүүн, %				Чийг төлөв байдлын үзүүлэлт						
			Сайр, сайрга	Элс	Тоос	Шавар	Байгалийн чийг	Уян налархайн үзүүлэлт			Чиглэлийн зэрэг	Консистенц	
								Шигшүүрийн хэмжээ, мм					
						Урсгалтын хязгаар		Имрэгдэлтийн хязгаар	Уян налархайн тоо				
			>2	2-0.05	0.05-0.005	<0.005							
1	Хайргархаг шавранцар	pQ ₂	46.1	45.4	4.3	4.2	0.034	0.243	0.162	0.081	0.17	-1.58	
2	Элсэнцэр чигжээстэй хайр, хайрга	pQ ₂	53.9	39.4	3.9	2.9	0.024	0.226	0.179	0.047	0.10	-3.29	
3	Элсэн чигжээстэй хайр, хайрга	pQ ₂	60.5	35.1	2.9	1.4	0.029	Уян налархай биш			0.13		

Хүснэгт №17. Нягт болон ул хөрсний механик шинж чанарын үзүүлэлтийн норматив болон тооцооны утга

Элементийн дугаар	Хөрсний нэр	Гарал үүслийн тэмдэглэгээ	Нягтын үзүүлэлтүүд					Ул хөрсний механик шинж чанарын үзүүлэлтийн норматив болон тооцооны утга					
								Зууралдлын хүч, кПа		Хэв гажилтын модуль МПА		Тооцооны эсэргүүцэл кгс/см ³	
			Хувийн жин г/см ³	Эзлэхүүн жин г/см ³	Цогцсын эзлэхүүн жин г/см ³	Сүвшил, %	Сүвшлийн коэффициент	CI	CII	φI	φII	E	Ro
1	Хайргархаг шавранцар	pQ ₂	2.67	1.81	1.75	34.5	0.526	26	39	22	25	27	400
2	Элсэнцэр чигжээстэй хайр, хайрга	pQ ₂	2.68	1.68	1.64	38.8	0.634	11	17	38	44	42	450
3	Элсэн чигжээстэй хайр, хайрга	pQ ₂	2.69	1.72	1.67	37.9	0.612	1.3	2	36	40	45	600


Хүснэгт №18. Чулуулгийн физик механик шинж чанарын үзүүлэлт

ИГЭ-ийн дугаар	Чулуулгийн нэр	Геологийн нас, гарал үүсэл	Өгөршсөн чулуулгийн эзлэхүүн эзлэхүүн, г/см ³	Өгөршөөгүй чулуулгийн эзлэхүүн жин, г/см ³	Өгөршлийн коэффициент	Нэг чиглэлийн шахагдалд үзүүлэх түр зуурын эсэргүүцэл кгс/см ²
4	Боржин	D -S		2.71		150

Хүснэгт №19. Хөрс, чулуулгийн овойлт болон газар шорооны ажлын зэрэг

ИГЭ	Хөрсний нэр	Симбол	Овойлтын зэрэг	Газар шорооны ажлын зэрэг
1	Хайргархаг шавранцар	pQ2	Дунд зэрэг овойлттой	III
2	Элсэнцэр чигжээстэй хайр, хайрга	pQ2	Сулавтар овойлттой	IV
3	Элсэн чигжээстэй хайр, хайрга	pQ2	Овойлтгүй	III
4	Боржин	D -S	Овойлтгүй	VII

Зураг №21. Баяндэлгэр сумын инженер-геологийн нөхцөлийн зураг



/Эх сурвалж: Сүхбаатар аймгийн нутаг дэвсгэрийн инженер-геологийн өргөтгөсөн судалгаа

2.3. ГАДАРГЫН УС


2.3.1. Усны сав газар, усны эх үүсвэр

Монгол орны нийт нутаг дэвсгэрийг усны 29 сав газарт хувааж үздэг бөгөөд Баяндэлгэр сумын нутаг дэвсгэр нь Умард говийн гүвээт халхын дундад талын сав газар, Галба-Өөш-Долоодын сав газруудад тус тус хамаарч байна.


Хүснэгт №20. Усны сав газрын үзүүлэлт

Сумын нэр	Сав газрын нэр	Талбай /га/
Баяндэлгэр	Умард говийн гүвээт халхын дундад талын сав газар	258637.3
	Галба-Өөш-Долоодын сав газар	498771.2

Зураг №22. Баяндэлгэр сумын нутаг дэвсгэр хамаарах усны сав газар



Зураг №23. Гадаргын усны зураг



2.3.2. Усны сан бүхий газрын ашиглалт хамгаалалт, тооллого, судалгаа

Монгол улсын Усны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4.-т “усны сан бүхий газар” гэж нуур, цөөрөм, тойром, гол мөрөн, горхи, булаг, шанд, усан сан, рашаан, намаг, мөстөл, мөсөн голын эзэлж байгаа талбай, тэдгээрийн хамгаалалтын бүсийн газрыг; хэлнэ гэж тодорхойлсон.

Мөн энэ хуулиар усны сан бүхий газрын эргээс 50 метрээс доошгүй зайд болон гол мөрний татамд онцгой хамгаалалтын бүс тогтоох, усны сан бүхий газрын эргээс 200 метрээс доошгүй зайд энгийн хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрээс 100 метрээс доошгүй зайд эрүүл ахуйн бүс тогтоохоор хуульчилсан.

Усны сан бүхий газрын өнөөгийн ашиглалтын талаар сумын хэмжээнд нийт 60 нуур, тойром, 38 булаг, 124 худаг байна. (БОАЖЯ, Усны сав газрын захиргаа, 2020-2021 он)

Хүснэгт №21. Сав газрын усны тооллогоор бүртгэгдсэн булаг

№	Булгийн нэр	Урсцын горим				Үүнээс:				
		Байнгын урсацтай	Түр зуурын урсацтай	Ширгэсэн	Сэргэсэн	Устай	Усгүй	Хашиж хамгаалсан	Хамгаалах шаардлагатай	Хамгаалах шаардлагагүй /боломжгүй эсвэл байгалийн аясаар хамгаалагдсан/
	Баяндэлгэр сум									
1	Гүн булаг					1				1
2	Тал булаг					1				1
3	Цоорхой булаг					1				1
4	Зүүн булаг					1				1
5	Энгэр цагаан булаг					1				
6	Адаг тосонгийн булаг					1				
7	Сэхүүл					1				
8	Сайн хүр булаг					1				1
9	Хар овооны булаг					1				1
10	Хөх хөв					1				
11	Цагаан толгойн булаг					1				
12	Ар гол булаг					1				
13	Гангат булаг					1				
14	Болохын булаг					1				1
15	Цоргот булаг					1				
16	Баянгийн голын булаг					1				1
17	Цагаан эргийн булаг					1				1
18	Дэрсэн худаг булаг					1				
19	Хулсан булаг					1				1
20	Хошуу дэрсний булаг					1				
21	Хойд захын дэрс булаг					1				
22	Сүүдэрт булаг					1				
23	Баюу					1				1
24	Жирмийн булаг					1				1
25	Хужирт булаг					1				1
26	Зуслан					1				
27	Өлзийт булаг					1				1
28	Хулгар					1				
29	Бага бууцны булаг						1			
30	Бага толгой					1				1
31	Могойт булаг					1				1
32	Өндөр хавцгайн булаг					1				1

БАЯНДЭЛГЭР СУМЫН НУТАГ ДЭВСГЭРИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
СУУРЬ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

2023 он

33	Сугын булаг					1				1
34	Тасархай					1				1
35	Сайр						1			
36	Залаат					1				1
37	Энгэрийн хар					1				1
38	Бадарч					1				1
Нийт		0	0	0	0	36	2	0	0	22

/Эх үүсвэр: БОАЖЯ, Усны сав газрын захиргаа, Гадаргын усны тооллого 2020-2021 он/

Дээрх хүснэгтээс харахад 2021 оны усны тооллогын мэдээгээр Баяндэлгэр сумын хэмжээнд 38 булаг, шанд бүртгэгдсэнээс устай 36, усгүй 2, хамгаалах шаардлагагүй 22 булаг, шанд бүртгэгдсэн байна.

Хүснэгт №22. Сав газрын усны тооллогоор бүртгэгдсэн нуур, тойром

№	Нуурын нэр	Устай	Ширгэсэн	Сэргэсэн	Тайлбар
Баяндэлгэр сум					
1	Зүүн төгрөгийн тойром	1			Хур борооны усаар тэжээгддэг.
2	-	1			Хур борооны усаар тэжээгддэг.
3	-	1			Хур борооны усаар тэжээгддэг.
4	Шүүтийн тойром	1			Хур борооны усаар тэжээгддэг.
5	Алаг толгойн тойром	1			Хур борооны усаар тэжээгддэг.
6	Дунд төгрөгийн тойром	1			Хур борооны усаар тэжээгддэг.
7	Замын төгрөгийн тойром	1			Хур борооны усаар тэжээгддэг.
8	Хулстайн тойром	1			Хур борооны усаар тэжээгддэг.
9	Ялавцайн тойром	1			Хур борооны усаар тэжээгддэг.
10	Өндөр дэлийн тойром	1			Хур борооны усаар тэжээгддэг.
11	Хүрлийн тойром	1			Бэлчээрийн ус хангамж
12	Хадан хөвийн нуур	1			Бэлчээрийн ус хангамж
13	Овоотын тойром	1			Бэлчээрийн ус хангамж
14	Үет тойром	1			Бэлчээрийн ус хангамж
15	Хар тойром	1			Бэлчээрийн ус хангамж
16	Хар овооны тойром	1			Бэлчээрийн ус хангамж
17	Цагаан худгийн тойром	1			бэлчээр ус хангамж, шаварлаг
18	Нуур/ нэр тодорхойгүй/	1			Бэлчээрийн ус хангамж
19	Шавын тойром	1			Бэлчээрийн ус хангамж
20	Зүүн оломтын улаан нуур	1			бэлчээр ус хангамж, маш том шал тойром, 1-2 жил өнждөг
21	Бөлтгөр	1			Бэлчээрийн ус хангамж
22	Тойром/нэр тодорхойгүй/	1			Бэлчээрийн ус хангамж
23	Ар хужрын тойром	1			Бэлчээрийн ус хангамж
24	Адъяат тойром	1			Бэлчээрийн ус хангамж
25	Цэлэмтийн тойром	1			Бэлчээрийн ус хангамж
26	Цэлэмт зүүн тойром	1			Бэлчээрийн ус хангамж
27	Эргэн тойром	1			Ус ихтэй жил Дэрсэн худаг-ын тойромтой нийлдэг
28	Дэрсэн худгийн тойром-1	1			Сүүлийн 5 жил устай байгаа, бэлчээрийн ус хангамж
29	Дэрсэн худгийн тойром-2	1			Сүүлийн 5 жил устай байгаа, бэлчээрийн ус хангамж
30	Гурван тойром	1			2020 онд хур борооны ус тогтсон, бэлчээр ус хангамж
31	Ширээ нуур	1			2020 онд ус тогтсон, бэлчээрийн ус хангамж
32	Дэнж	1			Бэлчээрийн ус хангамж, Хур бороо ихтэй жил тойром дүүрдэг
33	Хашаат	1			Сүүлийн 5 жил устай байгаа, Намартаа ширгэдэг, Бэлчээр ус хангамж
34	Алаг тойром	1			Сүүлийн 3 жил устай байгаа, намартаа ширгэнэ. Бэлчээрийн ус хангамж
35	Давст	1			Хур борооны усаар тэжээгддэг, Бор давс гаргаж авдаг, Тэмээ бэлчээрлэдэг
36	Өөш шүү	1			Малын шүү авдаг, мал бэлчээрлэдэггүй, Хур борооны усаар тэжээгддэг

**БАЯНДЭЛГЭР СУМЫН НУТАГ ДЭВСГЭРИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
СУУРЬ СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

2023 он

37	Улаан тойром	1		Сүүлийн жилүүдэд устай байгаа, намартаа ширгэдэг, бэлчээрийн ус хангамж, хур борооны усаар тэжээгддэг
38	Шүүт	1		Тэмээ бэлчээрлэдэг, Шүүтэй тойром, хур борооны усаар тэжээгддэг
39	Гашууны тойром	1		Хур борооны усаар тэжээгддэг, бага хэмжээний устай
40	Улаан нуур	1		Сүүлийн 3 жил устай байгаа, намартаа ширгэдэг, бэлчээр ус хангамж, Хур борооны усаар тэжээгддэг
41	Арын дэлгэр-1	1		Сүүлийн 3 жил устай байгаа, намартаа ширгэдэг, бэлчээр ус хангамж, хур борооны усаар тэжээгддэг
42	Арын дэлгэр-2	1		Сүүлийн 3 жил устай байгаа, намартаа ширгэдэг, бэлчээр ус хангамж, хур борооны усаар тэжээгддэг
43	Үет	1		Сүүлийн 3 жил зундаа устай байсан, намартаа ширгэдэг, хамгийн их гүн-80см
44	Улаан хүр	1		Сүүлийн 3 жил борооны ус дүүрсэн, намартаа ширгэдэг, ойр хавийн айлын мал ундаалдаг
45	Далай нуур	1		2016, 2017, 2018 онуудад өнжмөл устай байсан, Сүүлийн 10 жилийн төлөв зундаа бага зэргийн устай намартаа ширгэдэг, борооны тогтоол ус
46	Сэхүүл /Далайн/	1		Жилийн 4 улиралд мал уудаг, хамгийн их гүн-80см
47	Сүүдэрт хүр		1	2018,2019 онуудад бага зэргийн устай байсан, 2020 онд усгүй байсан, намартаа ширгэдэг, ус ихтэй үеийн гүн-1.50м
48	Ходоод	1		Сүүлийн 5 жил устай байсан, Намартаа ширгэдэг, ус ихтэй үеийн гүн-1.80м
49	Дэрсэн хүрээ	1		2019, 2020 онд бага зэрэг борооны тогтсон, намартаа ширгэдэг, ус ихтэй үеийн гүн-80см
50	Бор хужирын баруун шүү	1		Ус их дүүрвэл өнждөг, 2019 онд өнжөөгүй, Намартаа ширгэдэг, борооны тогтоол ус тэжээгдэлгүй
51	Бор хужирын зүүн шүү	1		Сүүлийн жилүүдэд зундаа устай байгаа, намартаа ширгэдэг, ус ихтэй үеийн гүн-2м, борооны тогтоол ус тэжээгдэлгүй
52	Гурван тойром /баруун/	1		2020 онд борооны ус тогтсон, өмнө жилүүдэд усгүй хуурай тойром байсан, намартаа ширгэнэ, тойрмын гүн-1.20м
53	Гурван тойром /зүүн/	1		2020 онд борооны ус тогтсон, өмнө жилүүдэд усгүй хуурай тойром байсан, тойрмын гүн-1.20м, намартаа ширгэнэ, борооны усны тогтоол тэжээгдэлгүй
54	Гурван тойром /дунд/	1		2020 онд борооны ус тогтсон, өмнө жилүүдэд усгүй хуурай тойром байсан, тойрмын гүн-50см, намартаа ширгэнэ, борооны усны тогтоол тэжээгдэлгүй
55	Булан	1		2020 онд борооны ус тогтсон, өмнө жилүүдэд усгүй хуурай тойром байсан, намартаа ширгэнэ, борооны усны тогтоол тэжээгдэлгүй
56	Улаан толгой	1		2020 онд борооны ус тогтсон, өмнө жилүүдэд усгүй хуурай тойром байсан, намартаа ширгэнэ, борооны усны тогтоол тэжээгдэлгүй
57	Хужирын тойром	1		2020 онд борооны ус тогтсон, Өмнө жилүүдэд усгүй хуурай тойром байсан, намартаа ширгэнэ, борооны усны тогтоол тэжээгдэлгүй
58	Хүрэн толгой		1	Сүүлийн 5 жил устай байсан, 2020 онд усгүй хуурай тойром, борооны тогтоол ус тэжээгдэлгүй
59	Цагаан нуур	1		Тойрмын хамгийн их гүн-1.20м орчим, 2020 онд тойром дүүрсэн, Урьд жил усгүй байсан, өнжих магадлалтай
60	Ногоон нуур	1		Намартаа ширгэнэ, тэжээгдэлгүй борооны ус, хамгийн их гүн-40см
Нийт		58	2	0

Дээрх хүснэгтээс харахад 2021 оны усны тооллогын мэдээгээр Баяндэлгэр сумын хэмжээнд 60 нуур, тойром бүртгэгдсэнээс 58 нь устай, 2 нь ширгэсэн байдалтай байна.

Хүснэгт №23. Худгийн бүртгэл

№	Газрын нэр	Худгийн гүн, м	Худгийн төрөл	Ашиглалтын зориулалт	Тайлбар
1	Адгийн хойд худаг	3.23м	Э/У	Унд ахуй, бэлчээр	Модон хашлагат, 9 айлын 6000 мал ундаалдаг, 4м, 5м төмөр онгоцтой, мотпомптой, засах шаардлагатай, усны түвшин-1.84м
2	Цагаан эргийн худаг	3.23м	Э/У	Унд ахуй, бэлчээр	5 айлын 3000 мал ундаалдаг, 2.30м төмөр онгоцтой, усны түвшин-2.12м, бетон кольцо модон хашлагат
3	Өндөр худаг		Э/У	Унд ахуй, бэлчээр	Усны чанар сайтай боловч үхрийн усанд дарагдаж элсээр дүүрсэн.
4	Эхэн ус	2.44м	Э/У	Унд ахуй, бэлчээр	3м, 8м төмөр онгоцтой, чулуун хашлагат, усны түвшин-30см
5	Тунгалагын моторт		Ө/Х	Унд ахуй, бэлчээр	4м төмөр онгоцтой, паспортгүй
6	Арын даравгай	4.27м	Э/У	Унд ахуй, бэлчээр	Хуучны кашка худаг, 9 айлын 5000 орчим мал 2 амыг ашиглан ундаалдаг, үерийн усаар бохирдсон, 2.50м, 3.50м төмөр онгоцтой, бетон хашлагат, усны түвшин-1.15м
7	Богино худаг	4.77м	Э/У	Унд ахуй, бэлчээр	5 айлын 4000 орчим мал ундаалдаг, 6м бетон онгоц, 5м төмөр онгоцтой, бетон хашлагат, усны түвшин-2.63м
8	Хар худаг	1.62м	Э/У	Унд ахуй, бэлчээр	5 айлын 3000 мал ундаалдаг, 3м төмөр онгоцтой, модон хашлагат, усны түвшин-1.35м
9	Сайрын шандны худаг	6.84м	Э/У	Унд ахуй, бэлчээр	7 айлын 4000 гаран мал ундаалдаг, 3м, 5м төмөр онгоцтой, мотпомптой, бетон хашлагат, усны түвшин-3.27м
10	Хар хад	3.51м	Э/У	Унд ахуй бэлчээр	5 айлын 6000 мал ундаалдаг, 3м төмөр, 6м бетон онгоцтой, мотпомптой, бетон хашлагат худаг, усны түвшин-2.69м
11	Даравгай	5.48м	Э/У	Унд ахуй, бэлчээр	Хуучны кашка худаг, 6 айлын 5000 орчим мал ундаалдаг, 5м төмөр онгоцтой, усны түвшин-1.60м
12	Баян Овоо	6.31м	Э/У	Унд ахуй, бэлчээр	Хуучны кашка худгийг энгийн уурхайн худаг болгон ашиглаж байсан, одоогоор ашиглалтгүй засварлах шаардлагатай, усны түвшин-4.57м
13	Гэээг	3.50м	Э/У	Унд ахуй, бэлчээр	7м, 4м төмөр онгоцтой, 7 айлын 5000 мал ундаалдаг, усны түвшин-1.25м, бетон ам, модон хашлагатай
14	Дэрсэн шанд	3.54м	Э/У	Унд ахуй, бэлчээр	усны түвшин-2.02м, хуучны кашка худаг, бетон кольцо доторлогоотой
15	Цахиуртай	5.72м	Э/У	Унд ахуй, бэлчээр	3 айлын 2500 мал ундаалдаг, 3м, 5м төмөр онгоцтой, усны түвшин-2.63м, бетон хашлагат худаг
16	Гэээгийн хавцал	45м	Ө/Х	Унд ахуй, бэлчээр	9м төмөр онгоцтой, мотпомптой,
17	Могойт	3м	Э/У	Унд ахуй, бэлчээр	5.30м, 4м төмөр онгоцтой, 9 айлын 6000 мал ундаалдаг, чулуун мод холимог хашлагат, усны түвшин-1.07м
18	Цагаан овоо	4.77м	Э/У	Унд ахуй, бэлчээр	Унданд ашигладаг, Хуучны кашка худаг, усны түвшин-2.87м, модон хашлагат

БАЯНДЭЛГЭР СУМЫН НУТАГ ДЭВСГЭРИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
СУУРЬ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

2023 он

19	Тоост-1	2м	Э/У	Унд ахуй, бэлчээр	Үерийн усанд автсан, лайдах шаардлагатай, амаараа хальсан, усны түвшин-12см
20	Тоост-2		Э/У	Унд ахуй, бэлчээр	5м, 4м төмөр онгоцтой, бетон хашлагат, мотпомптой
21	Хонхор		Э/У	Унд ахуй, бэлчээр	Үерийн усанд дарагдсан, ашиглах боломжгүй, модон хашлагат
22	Адаг урд	3.52м	Э/У	Унд ахуй, бэлчээр	Гадна тал бага зэрэг цөмөрсөн, 4м, 5м төмөр онгоцтой, модон хашлагат, усны түвшин-2м, засвар хийх шаардлагатай
23	Дэлгэрийн хойд худаг-1	2.77м	Э/У	Унд ахуй, бэлчээр	6м төмөр онгоцтой, гар насостой, 4 айлын 80 гаруй үхэр усалдаг, 2 амтай худаг, модон хашлагат, усны түвшин-2.19м
24	Дэлгэрийн урд худаг		Э/У	Унд ахуй, бэлчээр	Хуучны кашка худаг байсан, нурсан, хогоор дүүрсэн, бетон хашлагат
25	Дэлгэрийн хойд худаг-2	2.70м	Э/У	Унд ахуй, бэлчээр	5м төмөр онгоцтой, хуучны кашка худаг, усны түвшин-2.19м, бетон хашлагат, засах шаардлагатай
26	Мөргөцөг-1	3.26м	Э/У	Унд ахуй, бэлчээр	4 айлын 2000 гаруй мал ундаалдаг, 3м төмөр онгоцтой, модон хашлага, папришкан амтай, усны түвшин-2.24м
27	Мөргөцөг-2	2.57м	Э/У	Унд ахуй, бэлчээр	2м төмөр онгоцтой, модон хашлага, папришкан амтай, усны түвшин-2м
28	Зүүн цагаан чулуут	70м	Ө/Х	Унд ахуй, бэлчээр	3м төмөр онгоцтой, 2 айл 2000-3000 мал ундаалдаг, 1 тонны усны нөөцийн савтай, усны түвшин-2.85м
29	Алаг	23.7м	Э/У	Унд ахуй, бэлчээр	1 айлын 600 гаран мал ундаалдаг, 2м, 3м, 4м төмөр онгоцтой, онгоцны суурийг цементэлсэн, бетон хашлагат, модоор амыг тойруулж хашаалсан, усны түвшин-3.53м
30	Хөх шанд		Ө/Х	Унд ахуй, бэлчээр	2000 гаран мал ундаалдаг, 6м төмөр онгоц, 2 тонны төмөр усан сантай, онгоцны суурь цементэлсэн, 8000-тай мотпомптой
31	Хашаат-1	2.91м	Э/У	Унд ахуй, бэлчээр	2м төмөр онгоц, цементэн тавцантай, 4 айл 4000 мал ундаалдаг, бетон хашлагатай, хашаат-1,2,3 гэсэн 3 амтай, бохирдол ихтэй булингартсан, усны түвшин-1.63м
32	Хашаат-2	3.16м	Э/У	Унд ахуй, бэлчээр	7м төмөр онгоцтой, 4000 мал ундаалдаг, модон хашлагатай, худаг, онгоцыг тойруулаад цементэлсэн.
33	Хашаат-3	3м	Э/У	Унд ахуй, бэлчээр	4м, 6м төмөр онгоц, 4 айлын 4000 мал ундаалдаг, модон хашлага, усны түвшин-1.65м
34	Айраг	6.12м	Э/У	Унд ахуй, бэлчээр	5м, 3м төмөр онгоцтой, 1000 мал ундаалдаг, модон хашлагат, усны түвшин-3.55м, 2019 онд шинээр гарсан
35	Дэнж-1	4.5м	Э/У	Унд ахуй, бэлчээр	3-5 айлын 3000 мал ундаалдаг, мотпомптой, папришкан ам, модон хашлагатай, усны түвшин-2.96м, 2019 онд сэргээн засварласан.

БАЯНДЭЛГЭР СУМЫН НУТАГ ДЭВСГЭРИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
СУУРЬ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

2023 он

36	Айргийн цагаан толгой	90м	Ө/Х	Унд ахуй, бэлчээр	усны түвшин-60м, 4 айлын 4000 гаруй мал ундаалдаг, 5м төмөр онгоцтой, байшин дотроо 1 тонны усан сантай
37	Дэнж-2	4.5м	Э/У	Унд ахуй, бэлчээр	7м төмөр онгоцтой, 3-5 айл 3000 орчим мал ундаалдаг, модон хашлагатай, усны түвшин-2.74м
38	Ширээ нуурын худаг-1	3.87м	Э/У	Унд ахуй, бэлчээр	3.50м төмөр онгоцтой, 2 айлын 1500 гаруй мал ундаалдаг, 2 амтай худаг, папришкан амтай модон хашлагатай, усны түвшин-1.27м
39	Дунд худаг-1	2.62м	Э/У	Унд ахуй, бэлчээр	3м төмөр онгоцтой, 2 айлын 1000 орчим мал ундаалдаг, модон хашлагатай, блокон амтай, усны түвшин-1.33м
40	Айраг	8.40м	Э/У	Унд ахуй, бэлчээр	3 айлын 4000 мал ундаалдаг, 8м төмөр онгоц, урьд нь кашка худаг байсан, бетон хашлагат, усны түвшин-6м
41	Долоон нуур-1	3.74м	Э/У	Унд ахуй, бэлчээр	3 айлын 1000 гаруй мал ундаалдаг, 3м төмөр, 3м бетон онгоцтой, усны түвшин-1.77м, Богино яндант худаг
42	Дунд худаг-2		Э/У	Унд ахуй, бэлчээр	Усанд автсан
43	Амгалантын хойд худаг	5.79м	Э/У	Унд ахуй, бэлчээр	9 айлын 8000 мал 3 амаар ундаалдаг, 6,4м төмөр онгоцтой, усны тогтсон түвшин-40см, папришкан амтай модон хашлагат 1970 оны худаг
44	Амгалантын 3-р худаг	3м	Э/У	Унд ахуй, бэлчээр	3м, 8м төмөр онгоцтой, 9 айлын 8000 мал 3 амаар ундаалдаг, 2019 онд гаргасан, усны түвшин-1.59м, модон ам, модон хашлагатай
45	Товог	60м	Ө/Х	Унд ахуй, бэлчээр	1 тонны усан сантай, 3 айлын 1700 гаруй мал ундаалдаг, 2020 онд ашиглаагүй
46	Үетийн худаг	3.06м	Э/У	Унд ахуй, бэлчээр	2018 онд сэргэн засварлаж бетоноор хашсан, Хаврын цагт 1000 хоньтой айл ашигладаг, 3м төмөр онгоцтой, 1.5 тонны нөөцийн савтай
47	Сондуул	11.57м	Э/У	Унд ахуй, бэлчээр	1 айлын 1000 мал ундаалдаг, 4м төмөр онгоцтой, бетон хашлагат инженерийн хийцтэй худаг, усны түвшин-7.30м
48	Хөөвөрийн урд худаг	50м	Ө/Х	Унд ахуй, бэлчээр	2 айлын 1000 мал ундаалдаг, 8м төмөр онгоцтой, мотортой, 2 тонны усан сантай
49	Хөөвөр-1	1.40м	Э/У	Унд ахуй, бэлчээр	13 хот айл Хөөвөр-1,2,3-аг ашигладаг, 5000-6000 мал, 6м бетон онгоцтой
50	Хөөвөр-2	2.67м	Э/У	Унд ахуй, бэлчээр	13 хот айл Хөөвөр-1,2,3-аг ашигладаг, 5000-6000 мал, 3м, 4м төмөр онгоцтой, модон амтай, бетон хашлагат худаг, усны түвшин-60см
51	Хөөвөр-3	7.37м	Э/У	Унд ахуй, бэлчээр	13 хот айл Хөөвөр-1,2,3-аг ашигладаг, 5000-6000 мал, 5м, 4м төмөр онгоцтой, усны түвшин-3.07м, бетон хашлагатай, модон амтай
52	Арын дэлгэр-1	3.66м	Э/У	Унд ахуй, бэлчээр	5м, 6м төмөр онгоцтой, 3000 гаруй мал ундаалдаг, модон

БАЯНДЭЛГЭР СУМЫН НУТАГ ДЭВСГЭРИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
СУУРЬ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

2023 он

					амтай модон хашлагат, усны түвшин-1.95м
53	Арын дэлгэр-2	2.65м	Э/У	Унд ахуй, бэлчээр	Арын дэлгэрийн 2 ам худгийг ойр орчмын хот айлууд нийт 3000 гаруй мал ундаалдаг, 5м төмөр онгоцтой, 2 мотпомптой, модон амтай, модон хашлагатай, усны түвшин-1.09м
54	Сонингийн худаг	3.36м	Э/У	Унд ахуй, бэлчээр	3м 2 ширхэг папришкан онгоцтой 1 айл ашигладаг
55	Гашууны худаг	2.17м	Э/У	Унд ахуй, бэлчээр	2 айлын 1600 гаруй ундаалдаг, мотпомптой, 4м төмөр онгоцтой, папришкан ам, модон хашлагатай, усны түвшин-1м
56	Долоон нуур-2	3.91м	Э/У	Унд ахуй, бэлчээр	6м төмөр онгоцтой, 3 айлын 1000 гаруй мал ундаалдаг, мод, бетон хашлагат, усны түвшин-2м, 1970-1980 онд гаргасан худаг
57	Бор хужирын зүүн худаг	3.72м	Э/У	Унд ахуй, бэлчээр	3м төмөр онгоцтой, 3 айлын 2000 орчим мал ундаалдаг, мотпомптой, усны түвшин-2.64м, 1970-1980 оны үед гаргасан, бетон ам, бетон хашлагатай
58	Бор хужирын баруун худаг	5.10м	Э/У	Унд ахуй, бэлчээр	3 айлын 2000 орчим мал ундаалдаг, 4м төмөр онгоцтой, бетон хашлагат, бетон ам, усны түвшин-2.40м
59	Амгалантын урд худаг	2.46м	Э/У	Унд ахуй, бэлчээр	Амгалантын 3 ам худгийг 9 айлын 8000 мал ундаалдаг, 4м, 5м төмөр онгоцтой, папришкан амтай, модон хашлагат, усны түвшин-1м
60	Бор хужирын худаг		Ө/Х	Унд ахуй, бэлчээр	ашиглаж эхлээгүй байгаа, барилга баригдаагүй
61	Харваах	100м	Ө/Х	Унд ахуй, бэлчээр	1000 гаран мал ундаалдаг, 1 тонны усан сантай, усны түвшин-0.9м, 6м төмөр онгоцтой, усны түвшин-8м, 5м төмөр онгоцтой, 1 айлын 800 гаруй мал ундаалдаг, мотпомптой
62	Хөөвөрийн тохой	80м	Ө/Х	Унд ахуй, бэлчээр	Усны түвшин-2.91м, 2.50м, 2.50м 2 ширхэг төмөр онгоцтой, папришкан амтай, чулуун хашлагат, 1 айлын 500-600 мал ундаалдаг
63	Хөөвөрийн тохойн хойд худаг	3.50м	Э/У	Унд ахуй, бэлчээр	2.50м бетон онгоцтой, бетон хашлагат, 2 айлын 100 гаруй мал ундаалдаг, 1970 оноос хойш ашиглаж байгаа, усны түвшин-3.76м,
64	Хөөвөрийн тохойн зүүн урд худаг	10.53м	Э/У	Унд ахуй, бэлчээр	Усны түвшин-3м, 4м төмөр онгоцтой, 2 айлын 1000 гаруй мал ундаалдаг, 1984 оноос хойш ашиглаж байгаа, модон хашлагат, мотпомптой
65	Гээгэн шанд	4м	Э/У	Унд ахуй, бэлчээр	7м төмөр онгоцтой
66	Бамбай худаг	72	Ө/Х	бэлчээр ус хангамж	Түвшин 3.1м, өдөрт 1100 бог мал усалдаг
67	Хөтлийн эх	3.5	Э/У	бэлчээр ус хангамж	
68	Хөтөл	90	Ө/Х	бэлчээр ус хангамж	
69	Ногооны худаг	тодорхойгүй	Ө/Х	бэлчээр ус хангамж	усалгаатай газар тариаланд ашигладаг
70	Багийн төвийн худаг 1	8	Э/У	бэлчээр ус хангамж	-
71	Багийн төвийн худаг 2	тодорхойгүй	Ө/Х	бэлчээр ус хангамж	Битүүмжлэх шаардлагатай

БАЯНДЭЛГЭР СУМЫН НУТАГ ДЭВСГЭРИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
СУУРЬ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

2023 он

72	Түймэрт	тодорхойгүй	Ө/Х	бэлчээр ус хангамж	Хувь хүний хөрөнгөөр шинээр гаргасан
73	Хүүхэн толгой	тодорхойгүй	Ө/Х	бэлчээр ус хангамж	2015 онд хувь хүн өөрийн хөрөнгөөр гаргасан, байшин сэргээн засварлах шаардлагатай
74	Бор хөндийн худаг	тодорхойгүй	Ө/Х	бэлчээр ус хангамж	Худаг цоожтой байсан
75	Хадат хөв	тодорхойгүй	Ө/Х	бэлчээр ус хангамж	8м бетон онгоцтой
76	Шар доровгуйн худаг	тодорхойгүй	Э/У	бэлчээр ус хангамж	6м төмөр онгоцтой.
77	Болдоогийн худаг	55	Ө/Х	бэлчээр ус хангамж	6м төмөр онгоцтой.
78	Нарийны худаг	2	Э/У	бэлчээр ус хангамж	6м төмөр онгоцтой, 2м дугуй онгоцтой
79	Готовын худаг	тодорхойгүй	Ө/Х	бэлчээр ус хангамж	өдөрт 1200 бог мал усалдаг
80	Хол худаг	7	Э/У	бэлчээр ус хангамж	Өдөрт 1000 бог мал усалдаг
81	Шинэ булгийн худаг	5	Э/У	бэлчээр ус хангамж	өдөрт 100 бог, 300 бод мал усалдаг
82	Эргэнэ булгийн худаг	тодорхойгүй	Ө/Х	бэлчээр ус хангамж	1х1 бетон усан сантай, 2м бетон онгоцтой, битүүрсэн, битүүмжлэх шаардлагатай
83	Хулсан булгийн гар худаг	3	Э/У	бэлчээр ус хангамж	өвөлжөөний хажууд байдаг, 500-600 мал усалдаг
84	Цагаан булгийн цорго	тодорхойгүй	Ө/Х	бэлчээр ус хангамж	Хуучны цооног амаараа гардаг, артезын ус, 50м мал угаах ванн барьсан зөрчилтэй
85	Жалганы худаг	73	Ө/Х	бэлчээр ус хангамж	6м бетон, 4м төмөр онгоцтой, 1тонн усан сантай
86	Баюу худаг	90	Ө/Х	бэлчээр ус хангамж	70м насос гацсан
87	Цагаан худгийн гар худаг	тодорхойгүй	Э/У	бэлчээр ус хангамж	Бүртгэлгүй байсан.
88	Төгрөгийн худаг	тодорхойгүй	Э/У	бэлчээр ус хангамж	Түвшин 1.71м
89	Төгрөгийн худаг 2	тодорхойгүй	Э/У	бэлчээр ус хангамж	3м, 5м төмөр онгоцтой, түвшин 2м
90	Хадны худаг	75	Ө/Х	бэлчээр ус хангамж	6м төмөр онгоцтой
91	Өндрийн худаг	83	Ө/Х	бэлчээр ус хангамж	6м төмөр онгоцтой
92	Лхагвадоржын худаг	100м	Ө/Х	Тариалан	Бага зэргийн шаравтар устай
93	Сумын төв	2..16м	Э/У	Бэлчээр	Урьд нь сумын усан хангамжид ашигладаг байсан одоо бэлчээрт ашигладаг, онгоцгүй, чулуун хашлага, бетон амтай, усны түвшин-1.21м
94	Модот		Э/У	Унд ахуй, бэлчээр	Одоогоор ашиглалтгүй, лайдах шаардлагатай, хогоор дүүрч ус бохирдсон, усны түвшин-5м, модон хашлагат
95	Сумын төв-1		Ө/Х		Ашиглахгүй байгаа
96	Эмнэлэг		Ө/Х	Унд ахуй	
97	Сургууль		Ө/Х	Ахуй	Мэдээлэл байхгүй
98	Аваагийн худаг	70м	Ө/Х	Унд ахуй, тариалан	4м төмөр онгоцтой, ус шүүтэй
99	Баярбатын худаг	20-30м	Ө/Х	Унд ахуй, бэлчээр	Мэдээлэл байхгүй
100	Орон сууцны худаг-1		Ө/Х	Унд, ахуй	Мэдээлэл байхгүй
101	Орон сууцны худаг-2		Ө/Х	Унд, ахуй	Мэдээлэл байхгүй
102	Сумын төв-2	60м	Ө/Х	Унд, ахуй	Насос шавранд дарагдсан
103	Очирцогтын худаг	75м	Ө/Х	Ахуй	Унданд ашигладаггүй сүү ээдэж, мах улайдаг, ахуйдаа ашигладаг, усны түвшин-12м
104	Цэрэндоржын худаг	70м	Ө/Х	Ахуй	Зураг дарах боломжгүй
105	Салаагийн худаг		Ө/Х	Бэлчээрийн усан хангамж унданд хэрэглэдэггүй	

106	Салайтын худаг		Ө/Х	Бэлчээрийн усан хангамж унданд хэрэглэдэггүй	
107	Адгийн худаг	4.86	Э/У	Бэлчээр, унд ахуй	ТТ-4.09м
108	Ачаатын худаг-1	3.2	Э/У	Бэлчээр, унд ахуй	ТТ-0.34м
109	Ачаатын худаг-2	3	Э/У	Бэлчээр, унд ахуй	Худгийн амсар хүртэл устай байсан
110	Цахиуртын худаг	7	Э/У	Бэлчээрийн усан хангамж унданд хэрэглэдэггүй	ТТ-2.69м
111	Шанагны худаг	8	Э/У	Бэлчээр, унд ахуй	ТТ-2.22м
112	Говийн худаг	9	Э/У	Бэлчээр, унд ахуй	ТТ-0.94м
113	Улаан шандны худаг	9	Э/У	Бэлчээрийн усан хангамж унданд хэрэглэдэггүй	
114	Дунд зээрдийн худаг	9	Э/У	Бэлчээрийн усан хангамж унданд хэрэглэдэггүй	ТТ-2.75м
115	Хөөтийн шанд	2	Э/У	Бэлчээр, унд ахуй	ТТ-0.99м
116	Хөөтийн худаг	5	Э/У	Бэлчээрийн усан хангамж унданд хэрэглэдэггүй	ТТ-2.4м
117	Зүүн сэвхүүлийн худаг	6	Э/У	Бэлчээрийн усан хангамж унданд хэрэглэдэггүй	ТТ-3.42м
118	Зүүн төгрөгийн худаг		Ө/Х	Бэлчээрийн усан хангамж унданд хэрэглэдэггүй	
119	Зүүн төгрөгийн энгийн уурхайн худаг	4	Э/У	Бэлчээрийн усан хангамж унданд хэрэглэдэггүй	Борооны усаар дүүрсэн байсан
120	Дунд төгрөгийн худаг	5	Э/У	Бэлчээр, унд ахуй	ТТ-1.58м
121	Алтат төгрөгийн худаг		Ө/Х	Бэлчээрийн усан хангамж унданд хэрэглэдэггүй	
122	Алтат төгрөгийн энгийн уурхайн худаг	4.5	Э/У	Бэлчээрийн усан хангамж унданд хэрэглэдэггүй	ТТ-1.0м
123	Өндөр дэлийн худаг		Ө/Х	Бэлчээрийн усан хангамж унданд хэрэглэдэггүй	
124	Өндөр дэлийн энгийн уурхайн худаг		Э/У	Бэлчээрийн усан хангамж унданд хэрэглэдэггүй	

/Эх үүсвэр: БОАЖЯ, Усны сав газрын захиргаа, Гадаргын усны тооллого 2020-2021 он/

2.4. ГИДРОГЕОЛОГИ

2.4.1. Гидрогеологийн нөхцөл

Монгол орны газрын доорх ус орчин үеийн болон эртний янз бүрийн насны хурдас чулуулагт агуулагдана. Газрын доорх ус орших байдлаараа нүх сүвийн, ан цавын гэсэн үндсэн хоёр хэв шинжид хуваагдана. Гидрогеологийн мужлалаар улирлын хомс хангалттай, Дорноговийн мужид багтана. Шинэ төрмөлийн үеийн бялхмал чулуулгийн нэгэн хэлбэр шүлтлэг хүрмэн чулуулагт агуулагддаг газрын гүний ус нь ерөнхийдөө эрдэсжилт ихтэй байдаг. Элсний хонхор, түүний орчны тал газар тааралдах булаг, гар худгийн ус ундарга багатай, цагт ойролцоогоор 15-20 л

ус хуримтлагдах нөөцтэй байдаг. Энэ орчимд Дагшин булаг, Оргих булаг, Дэлгэрэх булаг зэрэг том жижиг найман булагтай.

Сүхбаатар аймгийн Дарьганга сумаас баруун хойш 14-15 км. Баруун-Урт хотоос зүүн урагш 180 км зайтай далайн түвшнээс дээш 1070 м өндөрт Рашаантын рашаан байдаг. Баруун хойш урссан Рашаантын голын өмнөд хөвөө дагаж шүүрсэн олон тооны булагтай бөгөөд маш нарийн цагаан наанги шавартай холилдон ундардаг. Лүн, Уу булгийн Цагаан толгой, Эмээлцэгийн Цагаан тогой, Баруун нарт, Зүүн нарт, Хонгор овоо, Дарь овоо зэрэг шинэ төрмөлийн эриний гуравдагч, дөрөвдөгч галавын үед оргилж байсан олон тооны шинэхэн унтарсан галт уулс энэ рашааныг эргэн тойрон 5-6 км зайтай хүрээлнэ. Энэ рашаан галт уулын үнс чандруунаас бүтсэн монтмориолит буюу чандруун шавар гэдэг маш нарийн ширхэгтэй цагаан наанги шавар тунамал хурдас дотроос гардаг. Нэлээд зузаан улаан шавар тунамал хурдастай газрын хөрсөн доороос энэхүү монтмориолит буюу цагаан чандруун шавар түлхэгдэн дов сондуул мэт олон булаг оргилон гарч байдаг.

Газрын доорх усны нөөц жигд бус тархалттай, хойноос урагшлах тутам түүний тархалт алаг цоог болж, эрдэсжилт нь ихсэх хандлага ажиглагдана. Энэ нь хойноос урагшлах тутам хур тунадасны хэмжээ багасах, агаарын температур, ууршил нэмэгдэх зэргээр уур амьсгалын нөхцөл өөрчлөгддөгөөс голчлон шалтгаална. Газрын доорх усны нөөц бүрэлдэх процесст хур тунадас, усны уурын өтгөрөл, тектоник хагарлын тогтоц, ялангуяа бүс нутгийн шинжтэй томоохон хагарал нөлөө үзүүлнэ. Голын урсцын гидрографыг ялгах замаар газрын доорх усны эзлэх хувийг тогтоодог. Газрын доорх усны их баялаг нөөц нь голын хөндийн аллюви, пролювийн хурдас болон томоохон хотгор газарт тархсан Цэрдийн галавын настай сэвсгэрдүү хурдас, тектоник хагарлын зарим хэсэгт хуримтлагдаж байна.

Усны эх үүсвэрүүдийн нөөцийн эрэл хайгуулын ажил явуулж, улсын хэмжээгээр газрын доорх усны 130 ордыг илрүүлэн нөөцийг нь тогтоосон байдаг.

Гарал үүслийн шинж тэмдгээр нь 3 уст комплексын ялгарал

1. Дөрөвдөгчийн хурдасны уст комплекс
2. Цэрдийн хурдасны уст комплекс
3. Палеозойн хурдасны уст комплекс

Дөрөвдөгчийн хурдасны уст комплексын гадаргуугаас анхлан илрэх хөрсний ус нь зонхилон аллюв-пролюв, делюв-пролювийн гарал үүсэлтэй байна. Ус агуулагч хурдас нь элсэнцэр-, шавранцар чигжээстэй том хэмхдэст хөрс, мөн түүнчлэн элс, элсэнцрийн бага зузаантай линзүүд бүрдүүлнэ. Баруун-Урт голын хөндийд хөрсний ус 1,5-1,9 м гүнд илэрнэ. Уст давхаргын зузаан 4-10 м-ийн хооронд хэлбэлзэнэ.

Барилга үйлдвэрийн баазын өмнөх хонхорт делюв-пролювийн хурдаст хөрсний ус 4.5 м гүнд илэрсэн. Энэхүү хөрсний ус нь дээд доод 2 талаасаа ус үл нэвтрүүлэх шавар хөрснөөр хязгаарлагдан даралттай нөхцөлд оршино. Уст үеийн зузаан энэ хэсэгтээ 0,6 м байна. Уст давхарга зуны улиралд агаарын хур тунадасны усаар тэжээгдэх ба үлдсэн хугацаанд палеозойн гүний чулуулаг болон тунамал-


бялхмал чулуулгийн урсцаас тэжээмжээ авдаг байна. Хөрсний усны түвшний хэлбэлзлийн агууриг делюв-пролювийн хурдаст 2.5-3.0 м байна.

Цэрдийн уст комплекс сулавтар цементлэгдсэн нуур-аллювийн хурдаст 20-25 м гүнээс гидрокарбонат-натри-кальцийн найрлагатай цэнгэг ус илэрдэг. Энэхүү ус нь гүний боржингийн ан цавын усаар тэжээгдэнэ. Цэрдийн уст комплексийн горим хангалтгүй судлагдсан ба усан хангамжийн зориулалтаар ашиглагддаггүй байна. Палеозойн хадан хурдасны уст комплекс ан цавлаг боржингийн массив болон тунамал-бялхмал чулуулгийн үед агуулагдана. Зураглалын талбайн баруун хэсэгт бялхмал болон диоритод хөрсний ус агуулагдах боловч нэг ч цооногт 10-15 м хүртэлх гүнд илрээгүй байна. Өмнөх судлаачдын судалгааны материалаас үзэхэд /Казакова, Маринов ба бусад/ дээд палеозойн бялхмал-тунамал комплекст агуулагдах хөрсний ус 35 м-ээс доош гүнд илэрдэг гэж тогтоожээ Доод пермийн ан цавжсан боржингийн массив дахь ус гадаргуугаас 2.4-24.0 м гүнээс илэрдэг ба хөндийн захаар булаг хэлбэрээр илэрдэг байна. Боржингийн массив усны горим уур амьсгалын хүчин зүйлээс хамаардаг ба агаарын хур тунадас, агаарын чийгийн конденсацын уснаас тэжээмжээ авдаг байна. Уст үеийн зузаан ойролцоогоор 40-45 м байна. Үүнээс Сүхбаатар аймагт дараах ордууд илэрсэн болно. (ГЗБГЗЗГ, 2014 он)

Хүснэгт №24. Газрын доорх усны нөөц баялгийн нөхцөлийн шалгуур

Далайн түвшнээс дээших өндөр	Хотгор гүдгэрийн дундаж хэвгий	Геологи тектоник тогтоц /давамгайлах төрлөөр/	Хур тунадас, мм	Гадаргуугийн урсац /жилийн дундаж/, мм	Газрын доорх урсац /жилийн дундаж/, мм	Газрын доорх усны нөхөн сэргээгдэх чадвар	Зонхилон тархсан уст үеийн				Ашиглалтын нөөцийн модуль л/с км ²	Газрын доорх хангамшлын нөхцөл
							Үндсэн төрөл	Усжилт	Уст үеийн зузаан, мм	Ус дамжуулах чадвар м/хон		
1000-1500	1.5-3.0	Хотгор kz-Q	155-200	5-10	30-50	Дунд	Q-kz-н ул хөрсний Mz-Kz-н үе	00.5-5.0	5-30	200-300	20-3	Сайн
1500-2000	3.0-6.0	Q-н элс хайрган хуримтлал	200-225	10-50	50-100 >100	Сайн	Q-н зузаан ул хөрсний	1-20.0	10-50	100-500	>3-4	Нэн сайн
2000-5000	6.0-12.0	Q-н хуримтлал, kz-өргөгдөл	225-250	50-100	20-50	Дунд	Q-н ба ан цавт ул хөрсний	0.5-10.0	1-10	50-100	2-3	Дунд
2500-3000	12.0-20.0	Kz-Mz өргөгдөл	250-300	100-200	20-10	Дунд	Q-н ба цавт ул хөрсний тектоник хагарал, судлын	0.1-5.0	2.5	20-50	0.5-1.0	Дунд юм уу муу
3000-4000	20.0	Pz-Mz-Kz өргөгдөл	300-400	200-300	<10	Муу	Ан цавт ул хөрсний тектоник хагарал судлын	0.1-3.0	1-5	5-20	05-аас бага	Маш муу

Зураг №24. Гидрогеологийн зураг



Хүснэгт №25. Баяндэлгэр сумын гидрогеологийн нөхцөл

№	Ангилал	Талбай /га/
1	Газрын доорх локал, хязгаарлагдмал нөөц бүхий устай чулуулаг	126607.14
2	Локал тархалттай ундрага ихтэй эсвэл их тархалттай	281088.17
3	Тархалт, ундрага ихтэй устай давхрага /Нүх сүвийн устай/	5041.32
4	Үндсэндээ газрын доорх усгүй чулуулаг	350385.48

Баяндэлгэр сумын нутаг дэвсгэр нь гидрогеологийн нөхцөлийн хувьд 126607.14 га талбай газрын доорх локал, хязгаарлагдмал нөөц бүхий устай чулуулаг, 281088.17 га локал тархалттай ундарга ихтэй эсвэл их тархалттай, 5041.32 га тархалт, ундарга ихтэй устай давхарга /Нүх сүвийн устай/, 350385.48 га үндсэндээ газрын доорх усгүй чулуулаг байна.

2.4.2. Газрын доорх усны орд ба нөөц, чанар

Газрын доорх усны ордын мэдээг 2013 онд БОАЖЯ-ны захиалгаар хийгдсэн “Хүн амын ундны эх үүсвэр, усан хангамжийн эрүүл ахуйн бүсийн цэсийн зураг гаргах ажлын “Аймгийн төвүүдийн болон сумын төв жижиг хот суурин газрын ус хангамжийн эх үүсвэрийн гадаад болон дотоод тэжээгдлийн мужийг тогтоох” ажил тайлангаас авч ашиглав.

МУ-ын хэмжээнд гидрогеологийн эрэл хайгуул хийж, газрын доорх усны ашиглалтын нөөцийг үйлдвэрлэлийн зэргээр буюу бодит үнэмшилтэй тогтоосон газрын доорх усны 213 ордоос Сүхбаатар аймагт 6 байна. Үүнээс Баяндэлгэр суманд улсын санхүүжилтээр 1111558.38 га-д хийсэн газрын доорх усны эрэл, нарийвчилсан хайгуулаар, С зэргээр 172.8 м³/хоног хоногийн нөөцийг баталсан байна. (БОАЖЯ, 2013 он)

Хүснэгт №26. Баяндэлгэр сумын газрын доорх усны ашиглалтын нөөц

№	Сумын нэр	Үүнээс			Тархалтын нийт талбай /га/
		Маш бага /0.1 л/с/км ² -аас бага/ нөөц баялагтай ус агуулсан хурдас	Бага /0.1-1 л/с/км ² -аас бага/ нөөц баялагтай ус агуулсан хурдас	Дунд зэргийн /1-5 л/с/км ² / нөөц баялагтай ус агуулсан хурдас	
1	Баяндэлгэр	616018	43135	97363	756516

/Эх үүсвэр: БОАЖЯ, 2018 он/


Газрын доорх усны ордын мэдээг 2013 онд БОАЖЯ-ны захиалгаар хийгдсэн “Хүн амын ундны эх үүсвэр, усан хангамжийн эрүүл ахуйн бүсийн цэсийн зураг гаргах ажлын “Аймгийн төвүүдийн болон сумын төв жижиг хот суурин газрын ус хангамжийн эх үүсвэрийн гадаад болон дотоод тэжээгдлийн мужийг тогтоох” ажил тайлангаас авч ашиглав.

Баяндэлгэр сумын ус хангамжийн газрын доорх усны орд

1991 онд Баяндэлгэр сумын төвийн ус хангамжийн эх үүсвэрийг тогтоох, газрын доорх усны эрэл, урьдчилсан хайгуулын ажил хийгдэж, 1991 оны 6-р сарын 28-нд үйлдвэрлэлийн С зэргээр 172.8 м³/хоног нөөцийг 27 жилийн хугацаатайгаар баталсан байдаг.

Тус ордын нөөц баялгийн хэмжээг сумын төвөөс 0.8 км зайд орших гидрогеологийн массивын хэсэг дэх дээд палеозойн интрузив чулуулгийн ан цавын бүсийн ан цав-грунтын усны газрын доорх уст цогцолборын хүрээнд тооцсон. Ордын газрын доорх ус нь химийн найрлагаараа ба чанараараа ундааны усны улсын стандартын шаардлагыг бүрэн хангадаг. Гидрокарбонат-сульфат, кали-натрийн найрлагатай, эрдэсжилт 0.4-0.7 г/л, ерөнхий хатуулаг 2.97-7.5 мг-экв/л байна.

Зураг №25. Баяндэлгэр сумын төвийн усан хангамжийн газрын доорх усны орд



2.4.3. Баяндэлгэр сумын ундны усны чанарын судалгаа

Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл, Шинжлэх Ухааны Академийн Газарзүй-Геоэкологийн хүрээлэнгийн хамтран боловсруулсан Сүхбаатар аймгийн төв болон сум, суурин газрын ундны усны чанарын судалгаанд нийт 13 сумын төв, суурин газрын ус хангамжийн эх үүсвэрийн 48 худаг, уст цэгээс сорьц авч судалгаа хийж үр дүнг боловсруулсан байна. Тус судалгаанаас авч үзэхэд:

Тус сумын төвийн хүн амын унд ахуйн хэрэгцээнд ашиглаж байгаа Зургаан булант, Ногооны талбайн, Өлзийтийн, Ухаалаг, 24 айлын 1,2-р гэсэн 6 худгаас усны сорьц авсан. Шинжилгээний дүнгээр Зургаан булант худгийн ус нь ундны усны стандартад заасан хэмжээнээс давсан давсархаг (эрдэсжилт 1467 мг/л), бусад худгийн ус нь цэнгэгээс цэнгэгдүү (эрдэсжилт 367-703 мг/л), хатуулгийн хувьд Зургаан булант худгийн ус нь ундны усны стандартад заасан хэмжээнээс давсан маш хатуу (хатуулаг 11.8 мг-экв/л), бусад худгийн ус нь зөөлнөөс хатуувтар

(хатуулаг 2.65-5.15 мг-экв/л), Зургаан булант болон 24 айлын орон сууцны 2 худгийн усны магнийн ион болон ураны хэмжээ ундны усны стандартад заасан хэмжээнээс давсан (Mg^{2+} 39-89 мг/л, U 42-54 мкг/л, их утга нь Зургаан булант), бүх худгийн усны фторын агууламж өндөр (F^{-} 2-2.75 мг/л) байна. Бичил элементүүдээс Зургаан булантын худгийн усанд стронци, Ухаалаг худгийн усанд хүнцлийн агууламж тус тус ундны усны стандартад заасан хэмжээнээс ялимгүй давсан үзүүлэлттэй байна. Эндээс дүгнэхэд Зургаан булант худгийн усыг унданд хэрэглэхэд тохиромжгүй, 2-айлын 2 худагт усны чанарыг сайжруулах төхөөрөмж суурилуулах /нэгдсэн санд хуримтлуулж, тэндээ төхөөрөмж тавьж болно/, бусад /Ногооны талбайн, Өлзийтийн-Ухаалаг/ худгийн ойр орчмыг тохижуулж бохирдуулахгүй байлгах бүх талын арга хэмжээ-авах, шинжилгээнд тогтмол хамруулж байх шаардлагатай. Баяндэлгэр сумын бүх худгийн усанд фторын ион ундны усны стандартад заасан хэмжээнээс их байгаа учир фторжуулсан бүтээгдэхүүн хэрэглэхээс татгалзах хэрэгтэй. (ХСУХАТАУЗЗ, ШУА, Сүхбаатар аймгийн ЗДТГ, 2021 он)

Хүснэгт №27. Ундны усны стандартын шаардлага хангаагүй худаг, уст цэгүүд, болон стандарт хангаагүй үзүүлэлтүүд

№	Худаг, уст цэгийн нэр	Ундны усны стандарт хангаагүй үзүүлэлтүүд
1	Зургаан булант худаг	Эрдэсжилт их (1464.3 мг/л)
		Хатуулаг их (11.8 мг-экв/л)
		Фторын агууламж их (F^{-} -2.33 мг/л)
		Натрийн ион их (Na^{+} -210.1 мг/л)
		Магнийн ион их (Mg^{2+} -88.8 мг/л)
		Нитратын ион их (NO_3 -180 мг/л)
		Ураны агууламж их (U-54.5 мкг/л)
		Стронци (Sr- 2095 мкг/л)
2	Ногооны талбайн худаг	Фторын агууламж их (F^{-} -2.39 мг/л)
		Гэдэсний бүлгийн нийт нянгийн тоо-50
		Халуунд тэсвэртэй гэдэсний бүлгийн нян-14
3	Өлзийтийн худаг	Фторын агууламж их (F^{-} -2.33 мг/л)
4	Ухаалаг худаг	Фторын агууламж их (F^{-} -2.0 мг/л)
		Хүнцлийн агууламж их (As -12.3 мг/л)
		Гэдэсний бүлгийн нийт нянгийн тоо-38
		Нийт нянгийн тоо- 102
	24 айлын орон сууцны 1-р худаг	Фторын агууламж их (F^{-} -2.75 мг/л)
		Магнийн ион их (Mg^{2+} - 40.1 мг/л)
		4Ураны агууламж их (U-42.0 мкг/л)
5	24 айлын орон сууцны 2-р худаг	Фторын агууламж их (F^{-} -2.75 мг/л)
		Магнийн ион их (Mg^{2+} - 38.9 мг/л)
		Ураны агууламж их (U-48.0 мкг/л)
		Гэдэсний бүлгийн нийт нянгийн тоо-1

/Эх үүсвэр: ХСУХАТАУЗЗ, ШУА-Газарзүй Геоэкологийн хүрээлэн, Сүхбаатар аймгийн төв болон сум, суурин газрын ундны усны чанарын судалгаа 2021 он/

2.5. ХӨРСӨН БҮРХЭВЧ

Хөрсний хэв шинжийн хувьд гүйцэт бус хөгжилтэй хүрэн хөрс 3189.03 га, довцог элс 22160.7 га, жинхэнэ хүрэн хөрс 537340.51 га, нугын хужир /чийгт хэлбэрийн хужир/ хөрс 59388.39 га, нугын хүрэн хөрс 7351.71 га, уулын цөлөрхөг хээрийн бор хөрс 11197.92 га, цайвар хүрэн хөрс 98201.94 га, цөлөрхөг хээрийн бор хөрс 18578.37 га тус тус эзэлж байна.

Баяндэлгэр сумын нутагт зонхилон тархсан хөрсөн бүрхэвчийн онцлог:

Цөлөрхөг хээрийн бор хөрс: Агь-хазаар өвс-говийн хялганат, таана-говийн хялганат, хазаар өвс-говийн хялганат, баглуур-таана-говийн хялганат бүлгэмдэл бүхий 15-25% бүрхэцтэй цөлөрхөг хээрийн ургамалшилтай газраар тархаж улсын бүх нутгийн 7%-тай тэнцэх талбайг хамарна. Энэ хөрсний дээд давхаргад боровтор өнгөтэй, хатуувтар өнгөн үе, түүний доод үе хоёр морфологийн хувьд бүдэг илэрнэ.

Уулын цөлөрхөг хээрийн бор хөрс: Энэ хэв шинжийн хөрс дээд талаараа уулын хүрэн, цайвар хүрэн хөрстэй хиллэж уулын хажуугийн дээд ба дунд хэсгээр тархана. Говийн хялгана голлосон цөлөрхөг хээрийн ургамал хад чулууны завсар зайгаар армаг тармаг ургаж 15-25% орчим бүрхэц үүсгэнэ. Хөрсний гадаргыг бүрхсэн сайр чулуунууд нь томовтор хэмжээтэй, тогтвор муутай сул байрлалтай, гадна тал нь цөлийн бараан хүрэн түлэнхий гандаасаар хучигдмал байна. Сайр чулуун бүрхэвчийн доор цайвар бор өнгөтэй, сайн ажиглавал үелсэн бүтэц бүдэг илэрсэн AB_{Ca} давхарга шууд орших бөгөөд нургисан хөнгөн шавранцар бүрэлдэхүүнтэй, давсны хүчилд бургилж хөөсөрнө. Түүнээс доош цайвар шаргал өнгөтэй, карбонатын хуримтлал ихтэй BC_{Ca} давхарга муухан ялгарч 30 см орчмын гүнд элюви-делювийн чулуурхаг хурдас эхэлнэ. Гадаргаасаа эхлээд сайр чулуу ихтэй учраас хөрсний үе давхаргууд үргэлжилсэн тогтоцтой биш, тасалданги байдалтай нь онцлог. Гадаргаасаа эхэлж нунтаг карбонатын хуримтлалтай, бүх үе давхарга нь шүлтлэг урвалын орчинтой, хөрсний дээд үе дэх ялзмагийн хэмжээ 0.8-1% орчим байна. Тал газрын заримдаг цөлийн бор хөрстэй адил хальслаг өнгөн үе, түүний доод үелсэн бүтэцтэй нимгэн үе аль аль нь илэрч ажиглагдахгүй байдаг нь уулын хөрс үүсвэрийн үйл явцын нэг үр дагавар мөн.

Чийгт хэлбэрийн хужир хөрс: Энэ хэв шинжийн хөрс хээрийн болон заримдаг цөлийн бүсэд, мөн говийн баян бүрдүүдэд нэлээн түгээмэл тархсан байна. Ер нь манай орны хужир хөрсний дийлэнх нь чийгт хэлбэрийнх гэж болно.

Ийм хөрс газрын доорх усны түвшин 1-2.5м гүнд буюу заримдаа түүнээс ч дээхнүүр оршдог, ууршилт хүчтэй явагдах боломжтой өвөрмөц нөхцөлд тогтворждог байна. Ус чийг нь байнга өөдөө хөөрч гадагшаа алдагдах учраас хөлрөх маягийн чийгийн горимтой гэж үздэг. Хөрсний гүнээс дулаан улирлын турш их хэмжээний ус дээшээ хөөрч дэгдэхдээ бүх үе давхаргуудыг нь нэвт дамжиж гадагшаа ууршиж алдагдах бөгөөд устай цуг түүнд ууссан давсны нэгдлүүд мөн

өөдөө хөөрч хөрсний өнгөн давхаргад хүрээд тэндээ тунаж хуримталсаар хужир марз болж тогтдог байна. Ингэж үүссэнийг чийгт хэлбэрийн хужир хөрс гэнэ. Чийгт хэлбэрийн хужир үүсэхэд газрын доорх ус заавал их эрдэсжилттэй байх албагүй, ус нь цэнгэг байсан ч хужир тогтохдоо л тогтоно. Давсжилтын хувьд хэд хэдэн хэвшинжийнх байдгийн дотор буултлаг хэвшинжийн давсжилт цөөнгүй тохиолддог явдал чийгт хэлбэрийн хужир хөрсний нэг онцлог. Чийгт хэлбэрийн хужир хөрсийг дотор нь 1) глейт, 2) глейрхэг гэсэн хоёр дэд хэв шинжид хуваана.


Жинхэнэ хүрэн хөрс: Хуурай хээрийн бүсийн өмнөд хэсгээр, эсвэл хархүрэн хөрстэй талархаг нутгийн доторх уудам хотгоруудад харгана бүхий үетэнт, агь-үетэнт ургамалшилтай газраар тархах бөгөөд ургамал нөмрөгийн бүрхэц нь 30-50% байна. Хөрсний чийгийн хангамж төдий л сайн биш, зуны хамгийн их хур бороотой үед ус чийг хөрсөнд дөнгөж 20-40 см хүртэл нэвчдэг тул түүнээс дооших хэсэг нь хуурай голдуу байна. Хөрсний үе давхарга үүнээс гүн чийглэгдэх нь ховор. Хүрэн хөрс өвлийн улиралд 2.8-3.5 м хүртэл гүн хөлдөх авч -10°C -ын температур 60 см-ээс доош бараг нэвтэрдэггүй. Зуны цагт хөрс хүчтэй халж $+10^{\circ}\text{C}$ -температур 2 м хүртэл буюу түүнээс гүн нэвтэрдэг. Энэ бүгдээс харахад хүрэн хөрсний дулааны горим хархүрэн хөрснийхөөс их ялгаатай.

Цайвар хүрэн хөрс: Цөлөрхөг хээрийн бүсийн хойд хэсэгт үетэн-монгол өвст бүлгэмдэл голлож агь, сонгино, харгана нэлээн холилдсон газраар тархах бөгөөд ургамлын бүрхэц 20-30%-аас үл хэтэрнэ. Хөрсний гадаргын ихэнх хэсэг ургамалгүй цулгуй байдаг учраас салхины үлээгдэлд хялбар өртөж том ширхэгтэй элс, жижиг сайр чулуугаар бүрхэгдсэн байна. Заримдаа халцгай газраар үелсэн бүтэцтэй, нимгэн (0.5-0.6 см), маш хэврэг хальслаг үе тогтсон харагддаг. Ялзмаг хуримтлалын давхарга (А) нь цайвар хүрэн өнгөтэй, бүдэг бөөмөрхөг бүтэцтэй, нэлээд тод илэрсэн, зузаан нь дунджаар 10 см (хамгийн зузаан нь 18-19 см, хамгийн нимгэн нь 6-8 см) байна. Түүний доорх арай нягтавтар шинжтэй, бага зэрэг ялзмагжсан, боровтор өнгөтэй B_1 давхарга ихэнх тохиолдолд ялгарч харагдах бөгөөд давсны хүчилд бургих гүн янз бүр байна.

Цайвар хүрэн хөрсний ялзмаг хуримтлалын давхарга дахь органик бодисын хэмжээ 1-2% орчим байх ба ялзмагийн найрлага дахь гуминий хүчил, фульво хүчлийн хэмжээ ойролцоо байна. Өвөл 2.5-3 м хүртэл гүн хөлдөнө. Зуны хур борооны ус хөрсөнд дөнгөж 15-20 см гүн нэвчиж хөрсний профилийн дээд хэсгийг чийглэдэг. Үржил шимээр тааруухан, шим тэжээлийн бодисын хангамж бага байна. Хөрсний дээд 0-20 см үе дэх ялзмагийн нөөц 30-40 т/га, бүх азотын нөөц 3 т/га орчим байдаг. Энэ хөрс бэлчээрийн эдэлбэр газрыг бий болгох бөгөөд зөвхөн усалгаатай нөхцөлд тариаланд ашиглах боломжтой. (Л.Доржготов, 2003 он)

/Эх үүсвэр: Монгол орны хөрс. Л.Доржготов 2003 он/

Зураг№26. Хөрсний зураг



2.6. УРГАМЛЫН АЙМАГ, УРГАМАЛЖИЛТ

Монголын ургамлын аймаг нь бүр эртнээс, тухайлбал эртний төрмөлийн эрингийн чулуун нүүрс-пермийн галавын үеэс эх газар үүсэж улмаар Цэрдийн галавын үеэс эх газрын, хуурай уур амьсгал зонхилох болсон тэр цагаас үүсэж хөгжсөн гэж үздэг. Ялангуяа Неогений үеэс Гимлай, тэнгэр уул, Куньлуэнь, Их Хянган зэрэг өндөр уулсын систем эрчимтэй өргөгдөж сүндэрлэснээр Төв Азийн агаарын урсгал, хур тунадасны хуваарилагдах байдал өөрчлөгдөн хуурайшин цөлжих явцад ихээхэн нөлөөлсөн нь Төв Азийн цөлийн хээрийн ургамлыг аймгийг бүрдүүлэхэд онцгой үүрэг гүйцэтгэжээ.

Н. Өлзийхутаг (1976 он) Монголын ургамлын аймгийг 16 тойрогт хуваасан байдаг. Энэ мужлалаар Сүхбаатар аймгийг ургамлын 3 тойрогт хуваасан. Үүнд:

1. Дундад Халхын хээрийн тойрог
2. Дорнод Монголын хээрийн тойрог
3. Дорноговийн цөлөрхөг хээрийн тойрог

Дундад Халхын хээрийн тойрог

Энэ тойрогт Баруун-Урт хотоос хойших нутаг хамрагдах ба энэ тойрог нь ургамлын аймгийн хувьд биеэ даасан өвөрмөц онцлог багатай, хэд хэдэн тойргийн шилжих зааг дээр байрлах учир Төв Азийн Монгол хошуу болоод Дагуурын хээрийн, зарим нь цөлөрхөг хээрийн бас умардын уулсын элементүүд оролцоно. Зөвхөн энэ тойрогт *Taraxacum bessarabicum*, *Taraxacum Printzii* гэсэн 2 зүйл тохиолдоно.

Дорнод Монголын хээрийн тойрог

Энэ тойрогт Баруун-Урт хотоос урагших нутаг хамрагдах ба умард зүгээс дагуурын, өмнө зүгээс Төв Азийн Монгол хошууны ургамлын аймгийн төлөөлөгчид харилцан нийлж буй шилжилтийн бүс таардаг байна. Бас Дорноос Манжуурын элементүүд цөөнгүй үзэгдэнэ. Тухайн тойрогт тохиолддог зүйл 17 байна. Жишээ нь: Литвиновын ботууль, Урт дохиурт сонгино, Потанины сараана, Цуулбарнавчит зогдор, өвс, Валерийн тарна, Грубовын бэрмэг, Үст дэлбээт бүрзэг, Урт навчит далан товч, Манж сүүт өвс, Тал нүцгэн гичгэнэ, Бамбай, түмэнтана, Сэгсгэр хошоон бут, Наалданхай гүүн хөх, Өргөний зохимон, Саваан лууль зэрэг өвөрмөц төлөөлөгчидтэй.

Дорноговийн цөлөрхөг хээрийн тойрог

Энэ тойрогт тус аймгийн Дорноговь аймагтай хиллэх баруун урд багахан хэсэг хамрагдах бөгөөд энэ тойрог нь жинхэнэ говийн цөлөрхөг хээр, цөлийн төлөөлөгчдөөс бүрдсэн ургамлын аймагтай. Зөвхөн тухайн тойрогт тохиолдох 6 зүйл байгаагийн жишээ нь Говийн бэрмэг, Боргоцой хамхуул, Хатгуурт сэдэргэнэ, Зөөлөвтөр лавай, Монгол шарилж, Арзгар ишт сульхиаг болно.

Ургамалшлын тархалтад голлон нөлөөлөх хүчин зүйл нь газар нутгийн хэмжээ, хотгор гүдгэр 2 юм. Манай улсын нутаг дэвсгэр хойноосоо урагшаа 1200

гаруй км үргэлжилсэн тул тэр чиглэлд өргөргийн хэд хэдэн бүс дараалан оршино. Гэвч хойд хэсэг гол төлөв уулсаар эзлэгдсэн тул бүсүүдийн байршилтыг ямар нэг хэмжээгээр ээдрээтэй болгож, босоо бүслүүрийг үүсгэнэ. Харин уулс ихэвчлэн хойд хэсэгт өндөр, урд хэсгээр нам учир босоо бүслүүрүүд хойд талын нутгаар тод, урд талын нутгаар тодорхой гарч чаддаггүй. Монгол орны газрын гадаргын онцлогтой холбоотой ургамалжилтын 6 бүс, бүслүүртэй бөгөөд тус аймагт хээрийн ба цөлөрхөг хээрийн бүсийн ургамал тархана.

Харин ГЗБГЗЗГ-аас гаргасан “Бэлчээрийн газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны ажлыг гүйцэтгэх, үр дүнг хүлээн авах журам”-д “Монгол орны бэлчээр хадлангийн ангилаа”-гаар нийт 9-бүсэд хуваан ангилсан байдаг. Үүнд:

Ө- Өндөр уулын бэлчээр

У- Дундаж өндөр болон нам, бэсрэг уулын бэлчээр

ӨХ- Өндөр уулын хоорондох нуга хөндий

УХ- Нам бэсрэг уулсын хоорондох нуга хөндий

Х- Тал хээрийн бэлчээр

ЦХ- Цөлөрхөг хээрийн бэлчээр

Ц- Говь цөлийн бэлчээр

Н - Бүс дундын голын хөндий, нам хотосын нугын бэлчээр

БТ- Бэлчээрт тохиромжгүй газар

Эдгээрээс Сүхбаатар аймгийн нутаг дэвсгэрт Дундаж өндөр болон нам, бэсрэг уулын бэлчээр /У/, Тал хээрийн бэлчээр /Х/, Цөлөрхөг хээрийн бэлчээр /ЦХ/, Бүс дундын голын хөндий, нам хотосын нугын бэлчээр /Н/, Бэлчээрт тохиромжгүй газар /БТ/ гэсэн бүсүүд байна.

Тал хээрийн бүс

Монголын хээр нь Европ дахь Мажар улсын Дунай “пушт” хэмээх хээрээс Дорнод Ази дахь Манжуурын хээр хүртэлх хээрийн дорнод хэсэгт нь оршдог юм. Хээрийн ургамалжилт зонхилж хатуу, хуурайсаг үетнээс бүрдэх боловч Монголын хээрийн бусдаас ялгагдах нэг онцлог нь хуурайсаг сөөг болох хэд хэдэн зүйл Харгана, Агь (хүйтсэг Шарилж) зэрэг сөөг сөөгөнцөр ихтэй явдал юм.

Хээрийн бүсэд үржил шим сайтай хар хүрэн, заримдаа элсэнцэр хүрэн хөрстэй. Хээрийн бүс нь Дорнод Монгол, Дундад халхын тэгш өндөрлөг, өргөн уудам тал газрыг хамарч баруун тийш нарийссаар Хангайн нурууны өврийн нам уулсын бэлээр дамжин Хан-Хөхийн өмнөд бэл хүртэл нарийн зурвас газраар Их нууруудын хотгорт хүрч замхарна.

Монголын хээрт Хялгана-Хазаар өвст, Хиаг-Хялганат, Хиаг-Өлөн-Агьт, Хялгана-Хазаар өвс-Агьт, Хялгана-Агьт, Хиаг –элдэв өвст, Шивээт хялгана-Монгол өвст, Хялгана-Таанат, Дэгнүүлт дөрвөн үетэнт, Зүр өвст, Элдэв өвст-үетэнт, Харганат хээр зонхилно. Хээрийн бүсийн дээр дурдсан эвслүүдийг бүрэлдүүлэгч

ургамал нь өдлөг Хялгана, (Монгол өвс) Байгал Хялгана, Крыловын Хялгана, том Хялгана, дэрвээн Хазаар өвс, Саман Ерхөг, хиаглан Түнгэ, Нангиад Хиаг, туяхан дурваа, туужууны биелэг, зэрэг үетэн; ширэг, Улалж, зогдор өлөн зэрэг өлөн; Хүтсэг Шарилж, Адамсын шарилж, маралхин Шарилж, хөх ногоон Шарилж, Ишгэн Шарилж, ишгүй Гичгэнэ, маралнавчит Гичгэнэ, имт Гичгэнэ, Сибирь Зүр өвс, Дагуур Хатны өвс, Турчаниновын Яргуй, Бунгийн яргуй, хоёр ишт Бэриш, арзгар Согсоолж, Хонгорзул, Амманы Сэдэргэнэ (Бор элгэнэ), юлдэн Тарваган шийр, хоншоохой хунчир, орос Чирэг, нарийн сонгино, Гогод, Мангир, үхэр Тарна, Дагуурын Тайжинс, алаг Башир, жинхэнэ Өрөмтүүл, Байгал Маалинга, Дагуур Бортайр, шаралдуу Уул-өвс, Дагуур Хуж өвс, Дагуур Хэрээний нүд, цомогт Бэрцэцэг, буурал Янгиц, буурал Гандбадраа, шар Хумхаал, тарваган Далан түрүү, намхан Сараана, дэрвээн Буржгар, говийн Ганга, бүхэл навчит Багдай элдэв өвс болно.

Хээрт хамгийн түгээмэл хэвшил нь өнгөн үедээ нэлээд элсэрхэг юм уу хайргархаг хөрстэй нутагт тохиолдох харганат хээр юм. Харганат хээр нь Хялганат ба хялгана-хазаар өвст хээрээс зүйлийн бүрдлээрээ онцын ялгаагүй бөгөөд гол төлөв Дундад Халхад түгээмэл тархжээ. Хялганат хээрийн олон хувилбар болох Зүр өвст хээр, Дэгнүүлт дөрвөн үетэнт хээр, Шивээт ба өдлөг Хялганат хээр, Хялгана-Таанат хээр нь тус аймагт бий. Жижиг толгод, нам уулсын хажуу, энгэр дагаж чулуурхаг, хайргархаг хээрийн хувилбар байх ба энд хээрийн бусад хэв шинжээс зүйлийн бүрдлээрээ ялгагдах зүйл үгүй, харин харьцангуйгаар нэлээд чийгсэг, нам хөндийд ургадаг Хиаг, хиаглай Түнгэ, зарим зүйлийн элдэв өвс алга болдог. Уул, толгодын эгц хажуу, энгэр, жалга дагаж бариулт Бүйлс, улаан Харгана, Сөөгөн Эмгэншилбэ, Тэхийн шээг, Монгол Догор, орог Тэсэг, дэлхээ Тогторгоно, Цагаан Ортууз, зэрэг сөөг сөөгөнцөр ургана. Уулархаг газруудаараа Хялганат, Хялгана-алаг өвст, Хялгана-хиагт, Хялгана-үетэнт, Хялгана-хазаарт, Хялгана-харганат Жижиг дэгнүүл үетэн-алаг өвст, Үетэн-алаг өвст, Хазаар-хялганат, Хазаар өвс-үетэнт зэрэг бэлчээр тархсан байна. Уулын хээрээр Хиагт, Хиаг-алаг өвст, Хиаг-дэрст, Хялгана-жижиг дэгнүүл-үетэнт, Хялгана-хиагт, Хялгана-хазаарт, Хялганат, Хялгана-алаг өвст, Жижиг дэгнүүлт үетэн, Жижиг дэгнүүлт үетэн-хялганат, Алаг өвс-үетэнт, Хялгана-харганат, Үетэн-алаг өвст, Хазаар-жижиг дэгнүүл үетэнт, Хазаар өвс-хялганат бэлчээрийн төрлүүд зонхилж байна.

Голын хөндий, нам хотосоор Үетэн-цахилдаг-алаг өвст, Дэрс-хиаг-алаг өвст, Дэрс-өлөнгөт, Дэрс-алаг өвст (таанатай) бэлчээрийн төрлүүд нь голын нам хотосын хужир мараат нугад ихэвчлэн тархсан байна.

Тал хөндийн бэлчээрт Шивээт хялгана, Хиаг, Гашуун агь, Саман ерхөг, Эмт гичгэнэ, Хурган чих, Шувуун хөл, Нарийн харгана, Үхэр харгана, Гоо юлд, Нарийн бэрмэг, Хонгор зул, Дааган сүүл гэх мэт ургамал.

Нам хотос газруудын хужир мараалаг хөрстэй бэлчээрт Дэрс, Хиаг, Биелэг, Улаан толгой, Нугын дурвалаг, Ширэг улалж, Бясаат улалж, Бут улалж, Намгийн гурвалж, Галуун гичгэнэ, Таван салаа, Багваахай, Сорвоо, Үхэр харгана, Бор шар бударгана, Хэрс зэрэг ургамлууд зонхилсон байна.

Нам уулын бэлчээрт Ленийн ботууль, Туужууны биелэг, Шивээт хялгана, Мөлхөө ганга, Марал навчит гичгэнэ, Хоёр гэрт бэрж, Бэр цэцэг, Ягаан ганга, Саман ерхөг, Шувуун хөл, Орос чирэг, Ортууз, Хунчир, Нарийн ба үхэр харгана, Хонгор зул, Гол гэсэр, Хүж өвс зэрэг зонхилох ба Шивээт хялгана зарим газартаа 70-80 см бусад үетэн алаг өвс 20-50см өндөртэй.


Цөлөрхөг хээрийн бүс

Энэ бүсэд Сүхбаатар аймгийн урд багахан хэсэг хамрагдах бөгөөд энэ нь Монголын хээр, Төв Азийн цөлийн зааг дээр нэлээд эрт үүсэж бий болсон, зөвхөн энэ бүсдээ ургадаг зонхилгогч ургамлуудтай байдгаараа онцлог бөгөөд цөлөрхөг хээрт амьдралын хэлбэрийн хувьд хуурайсаг сөөгөнцрүүд нэлээд оролцож, дэгнүүлт жижиг үетэн зонхилдог. Энд уул толгодын бэл, уулс хоорондын өргөн хөндий, ухаа гүвээний бор хөрсөнд Монгол өвст (өдлөг хялгана) цөлөрхөг хээр түгээмэл тааралддаг. Энд өдлөг Хялганын бүлэгт хамаарах Говийн хялгана, Сайрын хялгана, (эдгээрийг Монгол өвс гэдэг), Дорнодын хялгана, Кавказын хялгана мөн Нангиад Хазаар өвс зонхилохоос гадна Таана, Агь, Цагаан шаваг, Бор шаваг, Боролзой оролцоно. Дэлхээ, Догторгоно, навчгүй Баглуур, буурал Янгиц, Бор Элгэнэ, өргөст Ортууз, орог Тэсэг, нэлээд тохиолдохоос гадна хур бороо ихтэй зун ямаан Шарилж, Шүлхий Шарилж их ургадаг. Энд Могол өвс-Боролзойт хээр, Могол өвс-Таанат цөл, Монгол өвс-Таана-Бударгана, Монгол өвс-бударагнат, Харгана-монгол өвст, Тэсэг-Монгол өвст, Хотир-Монгол өвст, Шаваг-Монгол өвст, Бор бударганат, Бор бударгана-хойрогт, Баглуурт, сөөгт цөлөрхөг хээр их тааралдана. Цөлөрхөг хээр жижиг үетнүүдээс гадна гуравласан Боролзой, төлөгчдүү Боролзой, Таана, орог Тэсэг, Бор бударгана, навчгүй Баглуур, Нохой Шээрэн, улаан Харгана, Бунгийн (бор) Харгана, шивүүрт Харгана, Цулбуур өвс, Хойрог, говийн Тост, Хамхуул, Хамхаг ургана. Энд бас Булгансүүл, Оготнынсүүл, Хургалж, Нохойн бөөдий зэрэг нэг наст үетэн, хамхаг, хамхуул, будан, Хамхаг, зарим шарилж хуртай зун их ургаж өтгөн сахлаг ургацтай болно. Марц, хужиртай тойромд Улаан бударгана, Шар бударгана, Цагаан мод, түүний хүрээг дагаж Хармаг их ургаж товцог үүсгэнэ. Элсэрхэг хөндий, манхан дагаж Шар Шаваг, Хар суль, Элсний Цултхир, цагаан суль, монгол Торлог, Цулбуур өвс, сайр садарга дагаж Нангиад Хазаар өвс, сайрын Хялгана, хад чулуурхаг хажууг дагаж Пеллиотын Шивэлз, сөөгөн Боролзой, Төвд Заан таваг, Монгол Чоногоно, Монгол Догар, Морин зээргэнэ, данхар Хависхана ургадаг. (ГЗБГЗЗГ, 2020 он)

Хүснэгт №28. Баяндэлгэр сумын ургамалжилт

№	Шифр	Индекс	Нэр	Талбай /га/
1	Н-II	208	Улалж-үетэн-алаг өвст	430.61
2	Н-III	216	Үетэн-дэрст	3750.31
3	Н-III	221	Дэрс-хиаг-алаг өвст	2154.54
4	Н-III	223+154	Дэрс-алаг өвст (таанатай) + Хазаар өвс-таана-жигжиг алаг өвст	3590.16
5	Н-III	224	Дэрс-жигжиг улалжит	5660.95
6	Н-III	225	Дэрс бударганат	613.07
7	Н-IV	232+235	Шар бударгана-дэрст + Бударганат	17504.19
8	Н-IV	235	Бударганат	20580.60
9	Н-IV	236	Бударгана-дэрст	3416.42
10	Н-IV	236а	Бударгана-дэрст	18229.11
11	У-IV	40	Хялгана-хазаар өвст	861.81
12	У-IV	46	Хазаар өвс-үетэнт	10307.81
13	У-V	52	Хялгана-ерхөгт	2337.66
14	У-V	54	Үетэн-хялганат	2708.45
15	У-V	55+123	Үетэн-агь-шавагт + Жигжиг дэгнүүлт үетэнт, жигжиг дэгнүүлт үетэн-алаг өвст	20623.56
16	У-VI	58	Монгол өвс-ерхөгт	2022.22
17	У-VI	59	Монгол өвс-хазаар өвст, Хазаар өвс-монгол өвс	117993.45
18	У-VI	59+153	Монгол өвс-хазаар өвст, Хазаар өвс-монгол өвс + Хазаар өвс-монгол өвст	35828.18
19	У-VI	59а	Монгол өвс-хазаар өвст, Хазаар өвс-монгол өвс	29111.90
20	У-VI	61	Монгол өвс-таанат	441.85
21	Х-I	104а	Хялгана-жигжиг дэгнүүлт үетэнт	449.98
22	Х-I	106	Хялгана-хазаарт	8521.86
23	Х-I	106а	Хялгана-хазаарт	31961.83
24	Х-II	123	Жигжиг дэгнүүлт үетэнт, жигжиг дэгнүүлт үетэн-алаг өвст	19701.19
25	Х-II	126а	Хялгана-жигжиг дэгнүүлт үетэнт	12486.16
26	Х-II	132	Хазаар өвс хялганат	24254.34
27	Х-II	132а	Хазаар өвс хялганат	2147.65
28	Х-II	134	Агь-үетэнт	2731.84
29	Ц-II	183	Сүль-элсний шарилжит	14182.07
30	Ц-II	188	Харганат	4907.54
31	ЦХ-I	143	Монгол өвс-хазаар өвст	34314.95
32	ЦХ-I	143+153	Монгол өвс-хазаар өвст + Хазаар өвс-монгол өвст	42725.77
33	ЦХ-I	143а	Монгол өвс-хазаар өвст	3898.18
34	ЦХ-I	148а	Монгол өвс-таана-бударганат	15906.50
35	ЦХ-I	150	Монгол өвс-улаан бударганат	46780.87
36	ЦХ-I	151	Монгол өвс-бударганат	185.29
37	ЦХ-I	153	Хазаар өвс-монгол өвст	49688.32
38	ЦХ-I	154	Хазаар өвс-таана-жигжиг алаг өвст	1735.06
39	ЦХ-I	154а+148	Хазаар өвс-таана-жигжиг алаг өвст + Монгол өвс-таана-бударганат	82660.50
40	ЦХ-I	158	Таана-монгол өвст	38093.44
41	ЦХ-I	158+131	Таана-монгол өвст + Хазаар өвс-жигжиг дэгнүүлт үетэнт	17622.62
42	ЦХ-I	161	Харганат	1103.83
43	ЦХ-I	161а	Харганат	156.76

Зураг №27. Ургамалжилтын зураг



2.7. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

Монгол Улсын Засгийн газрын 2015.05.29-ний өдрийн 324 тоот тогтоолоор “Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг баталсан. 2016 онд “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал”-д аялал жуулчлалын дэд бүтцийн чанарыг сайжруулах, эко аялал жуулчлалын бүсүүдийг батлах, аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлэх, аялагч жуулчдын тоог 1 саяд хүргэх зорилтуудыг дэвшүүлсэн. Засгийн газрын 2018.06.13-ны өдрийн 171 тоот тогтоолоор “Аялал жуулчлалын гол чиглэл”-ийг баталсан бөгөөд Сүхбаатар, Хэнтий, Дорнод аймагт түүхэн аялал жуулчлалын маршрут хөгжүүлэхийг онцлон тусгасан.

2013 онд Сүхбаатар аймгийн ИТХ-аас “АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН МАСТЕР ТӨЛӨВЛӨГӨӨ”-г баталж Сүхбаатар аймагт түүхэн аялал жуулчлалыг хөгжүүлэх, аялал жуулчлалаас иргэдийн олох ашиг орлогыг нэмэгдүүлэх, Шилийн богдын аяллын маршрутыг гол бүтээгдэхүүн болгон хөгжүүлэх, үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэхээр төлөвлөсөн.

“СҮХБААТАР АЙМГИЙН ХӨГЖЛИЙН ХЭТИЙН ЗОРИЛТ 2020 – 2028” бодлогод тус аймгийн хөгжлийн тэргүүлэх чиглэлийн хоёрдугаарт “Шинжлэх ухаан, технологи, инновац, дэд бүтцэд тулгуурлан өрсөлдөх чадвар бүхий хөдөө аж ахуй, үйлдвэрлэл, аялал жуулчлалыг хослуулан хөгжүүлэх замаар бие даасан эдийн засгийн хөгжлийг хангана” гэж заасан. Мөн “Сүхбаатар аймгийн Засаг даргын 2020 – 2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээ, чанар стандартыг сайжруулж, байгаль орчинд ээлтэй аялал жуулчлалыг хөгжүүлэхээр тусгасан.

Эдгээр зорилго, зорилттой уялдуулан “Сүхбаатар аймгийн хөгжлийн хэтийн зорилт”-ын 5.3.1-д “Аймгийн аялал жуулчлалын салбарын судалгаа, шинжилгээ хийж зөвлөх үйлчилгээ авч, урт хугацааны хөгжлийн стратегийг боловсруулан хэрэгжүүлэх” хэмээх заалтыг үндэслэн СҮХБААТАР АЙМГИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ /2021-2026 он хүртэлх/-г Сүхбаатар аймгийн ЗДТГ, БОАЖГ-ын захиалгаар “Монголиан гайд тур” ХХК боловсруулсан байна.

Сүхбаатар аймгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх 2021-2026 оны дунд хугацааны менежментийн төлөвлөгөөнд Сүхбаатар аймгийн аяллын үндсэн 6 маршрут тусгагдсан байна.

Маршрут 1: УБ – Баруун-Урт – Алтан овоо – Шилийн богд – Баруун-Урт – УБ (1546км)

Маршрут 2: УБ – Сайншанд – Хамарын хийд – Хужирт – Онгон таван булаг – Дарьганга – УБ (1710км)

Маршрут 3: УБ – Түвшинширээ – Баяндэлгэр – Дарьганга – Баруун-Урт – УБ (1608км)

Маршрут 4: УБ – Баяндэлгэр – Онгон – Дарьганга – Эрдэнэцагаан – Сүхбаатар – Баруун-Урт (2000км)

Маршрут 5: УБ – Чойбалсан – Матад хан – Шилийн богд – Алтан овоо – Чойбалсан (986км)

Маршрут 6: УБ – Хэнтий аймаг – Дорнод аймаг – Сүхбаатар аймаг – УБ (2840км)

Сүхбаатар аймгийн аяллын үндсэн 6 маршрутад Баяндэлгэр сумыг дайран өнгөрөх аялалын 3 маршрут тусгагдсан байна.

Аялал жуулчлалын боломжит газруудад дараах байгаль, түүх соёлын дурсгалт газруудыг тусгасан байна. Үүнд:

- Орлой гурван зээрд
- Онгон таван булаг
- Өөш морин хошуу
- Өргөө таван толгой
- Өргөн цагаан дэрс
- Тойг тээгийн тал
- Төгрөг гүйлстэйн нуруу
- Дөхөмийн говь, Дөхөмийн баян овоо
- Онгон элс
- Хужиртын ам
- Дунд булгийн цоорхой, Цагаан булаг
- Хужиртын хавцал, хадны бичээс
- Замын нуурын хадны бичээс
- Бударгана
- Байшинтын туурь

Тус менежментийн төлөвлөгөөнөөс харахад аялал жуулчлалын өрсөлдөх чадвараараа Баяндэлгэр сум нийт аймгийн 13 сумаас 6-рт орсон байна. (БОАЖГ, "Монголиан гайд тур" ХХК, 2021он)

Хүснэгт №29. Баяндэлгэр сумын аялал жуулчлалын өрсөлдөх чадвар

№	Байгаль нөөц	Түүхийн нөөц	Музей	Зочид буудал	Жуулчны бааз	Дэн буудал	Хоолны газар	Эвент	Тахилгат уул	Буддын сүм, хийд	Христ, Исламын сүм	Банк	АТМ	Утасны сүлжээ	ШТС	Хий түгээх станц	Цэцэрлэгт талбай	Нийт тоо	Байр
1	15	4	-	1	-	2	4	-	1	2	-	2	2	4	3	-	-	40	

2.8. ТҮҮХ СОЁЛЫН ДУРСГАЛ

Түүх, археологи, соёлын дурсгалт газрын мэдээллийг 2008 онд Соёлын өвийн төвөөс гаргасан “Монгол нутаг дахь түүх соёлын үл хөдлөх дурсгал” 2-р дэвтрээс түүвэрлэн авсан болно.

Баяндэлгэр сумын нутаг дахь түүх соёлын үл хөдлөх дурсгалууд:

Баяндэлгэр сумыг УБХ-ын Тэргүүлэгчдийн 1931 оны 5 дугаар хурлын тогтоолоор хуучны Хан Хэнтий уулын аймгийн Дарьганга уулын хошууны нутгаас салган Дорнод аймгийн харьяанд байгуулжээ. 1942 онд Сүхбаатар аймгийг байгуулахад харьяанд нь шилжүүлсэн байна. Сумын төв Ширээт суурин нь аймгийн төвөөс баруун урагш 135 км зайтай. Бага айргийн булш Бадарчийн хөшөө чулуу, Байшинтын хийдийн туурь, Баруун цагаан чулуутын булш, Босгын булш, Босонгийн хадны хятад бичээс, Бударгана усны хийдийн туурь, Дэрсэн хийдийн туурь, Гашууны голын булш, Залаатын булш, бургасны хурлын туурь, Ламтын хүрээний туурь, Мухарын өвөлжөөний булш, бичээ, Нарангийн хийдийн туурь, Өгөөмөрийн хийдийн туурь, Өлзийт булгийн булш, Өндөр булштын дөрвөлжин булш, Өндөр хавцгайн булш, Сайн усны хөшөө чулуу, Хамжлагын хийдийн туурь, Хужиртын хадны зураг, бичээс, Хужиртын хавцлын булш, Цагаан худгийн сүмийн туурь, Ширээтийн хийдийн туурь, Эрээн хошууны булш, Эрдэнэ толгойн хурлын туурь зэрэг түүх соёлын үл хөдлөх дурсгалуудтай. (Соёлын өвийн төв, “Монгол нутаг дахь түүх соёлын үл хөдлөх дурсгал” 2-р дэвтэр, 2008 он)

1. Бударгана усны хийдийн туурь



Бударгана усны хийдийн туйр (урдаас)

Сумын төвөөс баруун зүгт 20 гаруй км-т, Бударгана ус хэмээх газар хуучны томоохон хийдийн туурь бий. Туурь дээгүүр том, жижиг, хэрэмтэй, хэрэмгүй олон сүм дуган, барилга байшингийн нурсан үлдэгдэл байдаг. Хийдийн туурийг хожуу үед хүмүүс ирж ухаж сүйтгэжээ.



Босонгийн бичигт хадны хятад бичээс

2. Босонгийн хадны хятад бичээс

Сумын төвөөс зүүн зүгт 50 гаруй км-т, Хөвийн хөндийн хойд биед Босонгийн бичигт хад оршино. Бичигт хадны урагш харсан гадаргуу дээр том, жижиг 2 мөр сийлмэл хятад бичиг бий.



3. Өндөр булштын дөрвөлжин булш

Сумын төвөөс зүүн зүгт 13-15 орчим км-т өндөр булшт хэмээх газарт таруу байрлалтай 20 орчим дөрвөлжин булш бий.



Өндөр хавцгайн булш (урдаас)

4. Өндөр хавцгайн булш

Сумын төвөөс баруун урагш 20-иод км-т, Өндөр хавцгай хэмээх газар гүн жалганы арын эрэг дээр цөөн хэдэн булш бий.



Сайн усны тахилын онгон (баруунаас)

5. Сайн усны хөшөө чулуу

Сумын төвөөс зүүн урагш 40-өөд км-т, Сайн ус хэмээх газар гадаргуу дээрээ ямар нэг тамга тэмдэггүй боржин чулуун хөшөөтэй эрт үед эвдэгдсэн тахилын онгон бий.




Хужиртын амны агуй, хадны зураг, бичээс

6. Хужиртын амны хадны зураг бичээс

Сумын төвөөс зүүн урагш 22 орчим км-т орших зүүн талаараа өндөр ханан хадтай амыг хужиртын ам гэдэг. Энэ амны баруун тийш харсан хадны дунд нэгэн хөмөг байх бөгөөд түүний ойр орчмоор хүний гарын алга дүрсэлсэн зураг болон төвд маанийн үсэг цөөнгүй бий.

/Эх үүсвэр: "Монгол нутаг дахь түүх соёлын үл хөдлөх дурсгал" 2-р дэвтэр 2008 он/

Зураг №28. Баяндэлгэр сумын нутаг дахь түүх соёлын үл хөдлөх дурсгалын байршил



2.9. ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТАГ

Тусгай хэрэгцээний газар ашиглалтын өнөөгийн байдал

Баяндэлгэр сумын нутаг дэвсгэрт Улсын тусгай хамгаалалтад буюу Байгалийн нөөц газарт хамаарах нийт 1 газар буюу 9939.11 га талбай байна.

Хүснэгт №30. Улсын тусгай хамгаалалтад авсан газар

№	ТХГН-ийн ангилал	ТХГН-ийн нэр	Хамгаалалтад авсан огноо	Хамгаалалтад авсан тогтоол, шийдвэр	Засаг захиргааны хуваарь	Талбайн хэмжээ, га
1	БНГ	Онгон таван булаг	2011-01-20	2011 оны УИХ-ын 4-р тогтоол	Сүхбаатар аймгийн Баяндэлгэр, Онгон сумын нутагт оршино.	9939.11

/Эх үүсвэр: Улсын ТХГН-ийн мэдээллийн сан <https://sur.ly/o/eic.mn>, 2022 он/

Онгон таван булаг - Байгалийн нөөц газар. Сүхбаатар аймгийн Баяндэлгэр, Онгон сумын нутагт оршино. Энэ хавийн хүн малын ундны усны хэрэгцээг олон зууны турш хангаж, ундаалж ирсэн таван булгийн усны нөөц сүүлийн жилүүдэд бий болсон байгаль, экологийн өөрчлөлт, хүний зохисгүй үйл ажиллагааны нөлөөллөөр талхлагдан доройтож, элсжих, усны нөөц, ундрог нь багасаж татрах, улмаар ширгэж хатан алга болох зэргээр төлөв байдал нь доройтон сэтгэл эмзэглүүлсэн зохисгүй байдал нүүрлэх болсон байна. Энэ бүс нутагт бий болсон дээрх нөхцөл байдлыг засах, сайжруулах, байгаль экологийн таатай нөхцөл, орчин бүрдүүлэх үүднээс Онгон таван булаг, түүний орчны 9939 га газрыг 2011 онд

улсын тусгай хамгаалалтад авсан байна. Онгон таван булаг нь Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын нутагт цөлөрхөг хээрийн бүсэд оршдог, байгалийн мужлалаар Баруун-Уртын суурьт болон давхаргат өндөрлөг тал, үлдмэл, цулдмал уул бүхий хуурай хээрийн дэд мужид хамрагдана. Баруун хойноос зүүн урагш сунаж тогтсон, салхин гаралтай Онгон элс хэмээх элсэн тарамцгийн баруун хаяанаас Гүн, Тал, Дунд, Зүүн, Баруун гэж нэрлэгдэх 5 булаг ундрэн гарах цэвэр тунгалаг устай газар юм. Эдгээр таван булгийг нийтэд нь Онгон таван булаг гэх ба 4,5-9 орчим км урсан элсэн хуримтлалын баруун хойгуур байх Байшинтын шал хэмээх хоолойн зах хүрч сэвсгэр хурдсанд шургана.


Хүснэгт №31. Орон нутгийн тусгай хамгаалалттай газрын мэдээлэл

№	ОНТХГ-ын ангилал	ОНТХГ-ын нэр	Тусгай хамгаалалтад авсан огноо	Тусгай хамгаалалтад байлгах жил	Газрын нэр
1	Сумын	Лүнгийн овоо	2020-01-21	10	Баяндэлгэр сумын нутаг
2	Сумын	Бурхант, Өгөөмөр уул	2020-01-21	10	Баяндэлгэр сумын нутаг
3	Сумын	Ямаатын айраг	2013-02-04	10	Баяндэлгэр сум
4	Сумын	Өгөөмөрийн хийдийн туурь	2013-02-04	10	Баяндэлгэр сум
5	Сумын	Хонгорын ухаа	2013-02-04	10	Баяндэлгэр сумын нутаг
6	Сумын	Сайн эрийн чулуу	2011-01-11		Баяндэлгэр сумын нутаг
7	Аймгийн	Дөхөмийн говь	2010-10-20	10	Баяндэлгэр сумын нутаг
8	Аймгийн	Өөшийн говь	2010-10-20	10	Баяндэлгэр сумын нутаг
9	Аймгийн	Халзан, Баяндэлгэр сумдын зааг	2009-04-13	-	Баяндэлгэр сумын нутаг
10	Аймгийн	Онгон таван булаг	2004-05-10	-	Баяндэлгэр сумын нутаг

/Эх үүсвэр: Улсын ТХГН-ийн мэдээллийн сан <https://sur.ly/o/eic.mn>, 2022 он/

Баяндэлгэр сумын хэмжээнд Улсын ТХГН-ийн мэдээллийн санд бүртгэлтэй аймгийн болон сумын тусгай хамгаалалтад авсан нийт 10 газар байна (Улсын ТХГН-ийн мэдээллийн сан,, 2023 он).

Зураг №29. Баяндэлгэр сумын тусгай хамгаалалттай газар нутгийн зураг



2.10. УУЛ УУРХАЙН ҮЙЛДВЭРЛЭЛ, АШИГТ МАЛТМАЛЫН СУДАЛГАА


Тус суманд ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий 1 лицензийн талбай байна.

Хүснэгт №32. Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн судалгаа


№	Лицензийн нэр	Лицензийн дугаар	Тусгай зөвшөөрөл	Эзэмшигч	Төрөл	Талбай /га/
1	Хүрэн уул	MV-016938	Ашиглалтын тусгай зөвшөөрөл	Талын элч	Нүүрс	2719.94

/Эх үүсвэр: Ашигт малтмал, газрын тосны газар, 2022 он/

Зураг №30. Геологийн зураг



Зураг №31. Баяндэлгэр сумын ашигт малтмалын тархалтын зураг



ГУРАВДУГААР БҮЛЭГ. СҮХБААТАР АЙМГИЙН БАЯНДЭЛГЭР СУМЫН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

3.1. ХҮН АМ ЗҮЙ

УИХ-ын 2004 оны 4-р сарын 23-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор “Монгол Улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого”-ыг баталсан. Уг бодлогод хүн амын өсөлтийн талаар “Хүний нөхөн үржихүйн эрхийг хүндэтгэсэн чөлөөт сонголт бүхий зохистой төрөлтийг дэмжиж, өвчлөл, нас баралтыг бууруулах замаар хүн амын тогтвортой өсөлтийг хангана.” гэж заасан байдаг. Хүн амын өсөлтийг нэмэгдүүлэх үүднээс төрөлт, гэр бүлийг дэмжих бодлого баримталж байна. (Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, 2022 он)

3.1.1. Хүн амын тоо


2017 оны дүнгээр тус сумын хүн амын тоо 4958 үүний эрэгтэй 2482, эмэгтэй 2476 байсан бөгөөд 2022 онд хүн амын тоо 5083 болж үүнээс эрэгтэй 2514, эмэгтэй 2569 болж нийт хүн ам 3.5 хувиар өссөн байна.

Хүснэгт №33. Хүн амын тоон өөрчлөлт


№	Багаар	2017	2018	2019	2020	2021	2022
1	1-р баг, Баян	833	839	849	846	851	856
2	2-р баг, Дэлгэр	758	769	768	776	794	810
3	3-р баг, Төв	675	699	700	703	711	681
4	4-р баг, Дөхөм	944	976	999	1,005	999	979
5	5-р баг, Хонгор	849	852	847	854	874	848
6	6-р баг, Ширээт	899	898	883	905	907	909
Баяндэлгэр сум		4958	5033	5046	5089	5136	5083

/Эх үүсвэр: www.1212.mn/

Зураг №32. Баяндэлгэр сумын хүн амын өсөлт, 2017-2022



Зураг№33. Хүн амын тоон өөрчлөлт, багаар 2017-2022



/Эх үүсвэр: www.1212.mn/


3.1.2. Хүн амын цэвэр өсөлт, бууралт

Тухайн жилийн хүн амын төрөлт нас баралтын тооны зөрүүг хүн амын ердийн цэвэр өсөлт, бууралт гэдэг.

Хүснэгт№34. Баяндэлгэр сумын хүн амын ердийн өсөлт

Үзүүлэлт	2017	2018	2019	2020	2021
Төрөлт	101	125	117	112	114
Нас баралт	25	23	36	26	32
Ердийн өсөлт	76	102	81	86	82

Зураг№34. Хүн амын ердийн өсөлт




3.1.3. Хүн амын ердийн цэвэр өсөлт, бууралтын коэффициент

Хүн амын ердийн цэвэр өсөлт, бууралтын коэффициент нь тухайн жилийн хүн амын төрөлт, нас баралтын тооны зөрүүгээр илэрхийлэгдэнэ. Уг зөрүүг жилийн дундаж хүн амд эзлэх хувиар тооцно. Баяндэлгэр сумын хүн амын ердийн цэвэр өсөлт, бууралтын коэффициентийг доорх хүснэгт, графикаар харуулав.

Хүснэгт №35. Хүн амын ердийн цэвэр өсөлт/бууралтын коэффициент

Сум	2017	2018	2019	2020	2021
Баяндэлгэр	15.4	20.4	16.1	17.0	16.1

Зураг №35. Хүн амын ердийн цэвэр өсөлт/бууралтын коэффициент




3.1.4. Нас хүйсийн бүтэц

Хүн амын нас, хүйсийн бүтэц гэдэг нь тухайн нас, хүйсийн бүлэг дэх хүн амын тоо хэмжээний тархалтыг хэлдэг. Нас, хүйсийн бүтцийн судалгаа нь тухайн хүн амын өнөөгийн байдал, түүнээс гарч болох үр дагавар, ирээдүйн төлөвийг тодорхойлоод зогсохгүй цаашид баримтлах бодлого, төлөвлөлтийн үндэс суурь болдог байна. Хүн амын нас, хүйсийн бүтэц ямар байгааг:

- Абсолют тоо,
- Хувийн жин, зураг ашиглан харуулж болдог. Насны бүтэц нь залуужих, идэрших, хөгшрөх гэсэн 3 үндсэн хандлагад хуваагддаг.

Насны бүтэц: 2021 оны байдлаар Баяндэлгэр сумын 5136 хүний 49.7% нь эрэгтэй, үлдсэн 50.3% нь эмэгтэй хүн байна. Нийт хүн амын 31.2 хувийг 0-14 насны хүүхэд, 61.4 хувийг 15-59 насны хүмүүс, 7.4 хувийг 60 ба түүнээс дээш насны хүмүүс эзэлж байна. Насны бүлгээс харахад 70 ба түүнээс дээш настай 106 хүн байна.

Зураг№36. Баяндэлгэр сумын нас хүйсийн суварга, 2021 он



3.1.5. Хүн ам зүйн үзүүлэлтүүд


Хүн ам зүйн ачаалал: Хөдөлмөрийн насны 100 хүнд ногдох тэжээлгэгчийн тоо (15 хүртэлх, 65 ба түүнээс дээш насны хүн амын тоо) буюу хөдөлмөрийн бус насны хүн амын нийгэмд үзүүлж буй ачааллыг харуулна.

Баяндэлгэр сумын хүн ам зүйн ачаалал 2018 оны байдлаар 51% байсан бол 2022 онд 53% болж өссөн байна.

Хүснэгт№36. Хүн ам зүйн ачаалал

Сум	2018	2019	2020	2021	2022
Баяндэлгэр	51	52	54	55	53

Зураг№37. Хүн ам зүйн ачаалал, харьцуулалт




Хүн амын нягтрал

Хүн амын нягтрал гэдэг нь нэгж газар нутагт ногдох хүн амын тоог илэрхийлнэ. Хүн амын нягтрал 2018-2022 оны хүн амын нягтрал 0.6 байна. Баяндэлгэр сумын хувьд хүн амын нягтрал 10 га талбайд 6 хүн оногдоно.


Хүснэгт №37. Баяндэлгэр сумын хүн амын нягтрал

Сум	2018	2019	2020	2021	2022
Баяндэлгэр	0.6	0.6	0.6	0.6	0.6
Түвшинширээ	0.8	0.8	0.8	0.8	0.8
Уулбаян	0.6	0.6	0.6	0.6	0.6

Зураг №38. Хүн амын нягтрал, ойролцоох самдуудтай харьцуулсан байдал



Зураг №39. Баяндэлгэр сумын хүн амын нягтшил 2022 оны байдлаар




Гэрлэлт, гэр бүл цуцлалт, үрчлэлт

Хүснэгт №38. Гэрлэлт, гэр бүл цуцлалт

№	Баяндэлгэр	2017	2018	2019	2020	2021
1	Гэрлэлт	29	15	24	30	39
2	Цуцлалт	5	3	3	3	2

Зураг №40. Гэрлэлт, гэр бүл цуцлалт




/Эх үүсвэр: www.1212.mn/

Хүснэгт №39. Гэрлэлт хүйс, насны бүлгээр

Үзүүлэлт	Насны бүлэг	2017	2018	2019	2020	2021
Эрэгтэй	Бүгд	29	15	24	30	39
	18-19	0	0	1	0	0
	20-24	16	4	7	4	17
	25-29	6	8	12	14	17
	30-34	3	2	2	7	3
	35-39	3	1	2	1	1
	40-44	1	0	0	1	1
	45-49	0	0	0	0	0
	50+	0	0	0	3	0
Эмэгтэй	Бүгд	29	15	24	30	39
	18-19	2	2	3	0	2
	20-24	18	5	6	13	23
	25-29	4	6	9	8	12
	30-34	3	1	4	4	2
	35-39	2	1	2	0	0
	40-44	0	0	0	2	0
	45-49	0	0	0	0	0
	50+	0	0	0	3	0

Зураг №41. Гэрлэлт хүйс, насны бүлгээр сүүлийн 5н жилээр харьцуулсан байдал



/Эх үүсвэр: www.1212.mn/

3.1.6. Өрхийн мэдээлэл

Нэг орон байранд хамт амьдардаг, нэгдмэл төсөвтэй, хүнс, амьдралын наад захын бусад хэрэгцээгээ хамтран хангадаг нэг буюу хэсэг бүлэг хүмүүсийг өрх гэнэ. Өрхийг бүтцээр нь


- Ганц бие өрх
- Ам бүлээрээ байгаа өрх;
- Нийлмэл өрх;
- Холимог өрх гэж ангилдаг.

2017 оны байдлаар Баяндэлгэр сумын өрхийн тоо 1393 байсан бол 2022 онд 1420 болж өссөн байна.


Хүснэгт №40. Баяндэлгэр сумын нийт өрхийн тоо, багаар

№	Багийн нэр	2017	2018	2019	2020	2021	2022
1	1-р баг, Баян	232	234	228	229	233	234
2	2-р баг, Дэлгэр	209	208	208	211	218	219
3	3-р баг, Төв	186	191	188	186	192	194
4	4-р баг, Дөхөм	265	267	267	270	270	269
5	5-р баг, Хонгор	235	236	233	234	245	243
6	6-р баг, Ширээт	266	262	243	250	255	261
	Баяндэлгэр	1393	1398	1367	1380	1413	1420

Зураг№42. Баяндэлгэр сумын нийт өрхийн тоон үзүүлэлт



Зураг№43. Өрхийн тоо багаар



/Эх үүсвэр: www.1212.mn/


Өрхийн ам бүлийн дундаж тоо

Энэ үзүүлэлт нь нэг өрхөд ногдох хүний тоог илэрхийлнэ. Баяндэлгэр сумын хэмжээнд 2021 оны тоон үзүүлэлтээр 1 өрхөд 3.6 хүн ноогдож байна. Сүүлийн 5 жилийн өрхийн ам бүлийн дундаж тоог багуудаар гаргаж хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт №41. Өрхийн ам бүлийн дундаж

Баяндэлгэр	2017	2018	2019	2020	2021
1-р баг, Баян	3.6	3.6	3.7	3.7	3.7
2-р баг, Дэлгэр	3.6	3.7	3.7	3.7	3.6
3-р баг, Төв	3.6	3.7	3.7	3.8	3.7
4-р баг, Дөхөм	3.6	3.7	3.7	3.7	3.7
5-р баг, Хонгор	3.6	3.6	3.6	3.6	3.5
6-р баг, Ширээт	3.4	3.4	3.6	3.6	3.5
Нийт	3.6	3.6	3.7	3.7	3.6

Зураг №44. Өрхийн ам бүлийн дундаж тоон харьцуулалт 2017-2021 он



3.1.7. Шилжих хөдөлгөөн

Монгол Улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлогод дотоод шилжих хөдөлгөөний талаар дөрвөн заалт байдаг. Үүнд:

- Бүсийн тулгуур төв, нийслэлийн дагуул хотыг хөгжүүлэх хот, суурин газарт чиглэсэн шилжих хөдөлгөөний эрчимжилтийг зохицуулна.
- Хүний чөлөөтэй шилжин суурьших эрхийг хүндэтгэж, ажиллах амьдрах газраа сонгох нөхцөлийг бүрдүүлнэ.
- Орон нутагтаа тав тухтай амьдран суурьших нөхцөлийг хангаж, байгаль орчин, эдийн засгийн болзошгүй эрсдэлээс хамгаална.
- Шилжин суурьшигчдын нийгмийн үйлчилгээнд ногдох зардлыг оршин сууж байсан аймаг, сумын төсвөөс шилжин суурьшсан газарт нь шилжүүлэх эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлнэ.


Тухайн нутаг дэвсгэрийн хилийн хүрээн доторх засаг захиргааны нэгж хоорондох, түүнчлэн байршлын хувьд явагдах хүн амын суурьшлын өөрчлөлтөөр тодорхойлогдоно. Шилжих хөдөлгөөний үндсэн үзүүлэлт нь шилжин ирэгчдийн тоо,

шилжин явагчдын тоо болно. 2017-2021 оны хугацаанд Баяндэлгэр сумын хэмжээнд 178 хүн, жилд дунджаар 36 хүн шилжин ирж, 2017-2018 оны хооронд 62 хүн шилжин явсан байна. 2020 онд шилжин явалтыг бүртгэхгүй болсон тул мэдээлэлгүй байна.

Хүснэгт №42. Баяндэлгэр сумын шилжих хөдөлгөөн, 2017-2021 он

№	Үзүүлэлт	2017	2018	2019	2020	2021	Нийт	Жилийн дундаж
1	Шилжин ирсэн	47	36	11	34	50	178	36
2	Шилжин явсан	15	47	-	-	-	62	31

Зураг №45. Баяндэлгэр сумын шилжих хөдөлгөөн, 2017-2021 он



Дотоод шилжих хөдөлгөөний цэвэр коэффициент

Дотоод шилжих хөдөлгөөний цэвэр коэффициент гэдэг нь шилжин ирсэн, шилжин явсан хүн амын тооны зөрүүг жилийн дундаж хүн амд харьцуулж тодорхойлно.


Энэ коэффициент нь сөрөг гарвал 1000 хүн тутамд шилжин явалт өндөр, эерэг гарвал шилжин ирэлт өндөр байгааг илтгэнэ.

Баяндэлгэр сумын хувьд хүснэгтээс харвал 2018 онд шилжин явсан хүн шилжин ирсэн хүний тооноос өндөр байгаа тул шилжин ирэлт нь сөрөг гарсан байна. 2019-2021 шилжин явсан хүн бүртгэгдээгүйн улмаас шилжих хөдөлгөөний цэвэр коэффициент эерэг буюу 2.2-9.8 гарсан байна.

Хүснэгт №43. Дотоод шилжих хөдөлгөөний цэвэр коэффициент

Сум	2017	2018	2019	2020	2021
Баяндэлгэр	6.5	-2.2	2.2	6.7	9.8

Зураг№46. Дотоод шилжих хөдөлгөөний цэвэр коэффициент



3.2. МАЛ АЖ АХУЙН САЛБАР

3.2.1. Малчин өрх

Малчин өрхөд жилийн дөрвөн улирлын туршид малаа маллаж, малаас ашиг шим олж байгаа нь тэдний амьжиргааны эх үүсвэр болж байгаа өрхийг хамруулна.

Малтай өрх гэж мал бүхий өрх болон малчин өрхийг хэлнэ. Мал бүхий өрх гэж малыг ахуй амьдралдаа туслах чанарын үүрэгтэй өсгөн үржүүлдэг өрхийг ойлгоно.


Баяндэлгэр сумын хэмжээнд 2022 оны байдлаар 1109 өрхийн буюу нийт өрхийн 78% нь малчин өрх байна. (Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, 2022 он)

Хүснэгт№44. Малчин өрхийн тоо, багаар

№	Багийн нэр	2017	2018	2019	2020	2021	2022
1	1-р баг, Баян	188	172	163	161	168	181
2	2-р баг, Дэлгэр	192	194	197	200	199	203
3	3-р баг, Төв	155	167	165	170	174	175
4	4-р баг, Дөхөм	240	223	224	226	233	239
5	5-р баг, Хонгор	205	206	208	210	214	214
6	6-р баг, Ширээт	70	76	70	71	81	97
	Нийт	1050	1038	1027	1038	1069	1109

Сумын малчин өрхийн тоо 2019 онд хамгийн бага буюу 1027 өрх тоологдсон ба тус онтой харьцуулахад 2022 онд малчин өрхийн тоо 1109 болж өссөн байна.


Зураг№47. Баяндэлгэр сумын малчин өрх



Хүснэгт№45. Малтай өрх

№	Багийн нэр	2017	2018	2019	2020	2021	2022
1	1-р баг, Баян	207	208	202	212	209	209
2	2-р баг, Дэлгэр	196	198	202	209	215	216
3	3-р баг, Төв	166	174	175	176	177	183
4	4-р баг, Дөхөм	246	254	255	259	260	256
5	5-р баг, Хонгор	223	224	223	222	226	226
6	6-р баг, Ширээт	147	142	139	154	160	169
	Нийт	1185	1200	1196	1232	1247	1259

Зураг№48. Баяндэлгэр сумын малтай өрхийн тоо



3.2.2. Малын тоо


2022 оны мал тооллогоор 565805 толгой мал тоолуулснаас адуу 26778, үхэр 31501, тэмээ 1097, хонь 307736, ямаа 198693 толгой болж өссөн байна.

Хүснэгт №46. Малын тоо, төрлөөр 2017-2022 он


№	Малын төрөл	2017	2018	2019	2020	2021	2022
1	Адуу	20167	22643	23644	23251	25192	26778
2	Үхэр	20768	24339	26881	27884	29435	31501
3	Тэмээ	898	926	911	961	1018	1097
4	Хонь	220538	251143	273485	269911	286415	307736
5	Ямаа	145108	166980	183170	181466	181011	198693
	Бүгд	407479	466031	508091	503473	523071	565805

/Эх үүсвэр: www.1212.mn/

Зураг №49. Сумын нийт малын тоон өөрчлөлт



Зураг №50. Сумын нийт малын өсөлт, төрлөөр




Хүснэгт №47. Нийт малын тоо, багаар 2017-2022 он

Багийн нэр	Малын төрөл	2017	2018	2019	2020	2021	2022
1-р баг, Баян	Бүгд	78761	90996	102666	99985	100670	109433
	Адуу	2348	2894	3182	3383	3604	3844
	Үхэр	2862	3487	4113	4290	4534	4996
	Тэмээ	121	137	141	176	166	181
	Хонь	44028	50386	56767	54698	56942	61984
	Ямаа	29402	34092	38463	37438	35424	38428
2-р баг, Дэлгэр	Бүгд	56803	65799	71936	75171	78550	85611
	Адуу	2316	2662	2871	2848	3303	3473
	Үхэр	2338	2828	3130	3378	3578	3988
	Тэмээ	93	97	98	99	91	100
	Хонь	32376	36721	39770	41676	44853	48842
	Ямаа	19680	23491	26067	27170	26725	29208
3-р баг, Төв	Бүгд	57916	69416	75001	75467	76534	87514
	Адуу	3746	4570	4704	4284	4493	5009
	Үхэр	2771	3484	3931	4205	4342	4979
	Тэмээ	137	146	159	159	165	193
	Хонь	30073	35580	38784	40187	41867	46553
	Ямаа	21189	25636	27423	26632	25667	30780
4-р баг, Дөхөм	Бүгд	101973	119379	128415	124109	128424	130942
	Адуу	3827	4486	4679	4507	4925	5113
	Үхэр	4873	5897	6530	6593	6884	7036
	Тэмээ	122	129	131	126	134	110
	Хонь	57517	67438	72114	69468	72262	72287
	Ямаа	35634	41429	44961	43415	44219	46396
